# СИТИ SCIENCE

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГААНЫ СЭТГҮҮЛ

**МЭДЛЭГ БОЛ ХҮЧ ЧАДАЛ, ЭРХ ЧӨЛӨӨ** - *SCIENTIA EST POTENTIA, LIBERTAS*

ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗАРИМ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА, ТУЛГАМДСАН АСУУДАЛ.

ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН СУДАЛГАА.

MEASURING KNOWLEDGE

МОНГОЛ, ХЯТАДЫН НҮҮРСНИЙ ХУДАЛДААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

THE APPLICATION OF "BRAND-VISUAL-GENES" IN "SMALL TOURIST TOWNS" DESIGN

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН САДГҮЙ ХУВЦАС МОДУЛЬ АРГА ЗҮЙН СУДАЛГАА БОЛОН ХЭРЭГЛЭЭ

БНХАУ, ОХУ-ЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ МОНГОЛ УЛСТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ

БАРИЛГА, АРХИТЕКТУР ДИЗАЙНЫ СУРГУУЛЬ

УРЛАГИЙН СУРГУУЛЬ

ГОО САЙХНЫ СУРГУУЛЬ

ISSN 2788-7685 · 2021 ХОЁРДУГААР УЛИРАЛ · www.citi.edu.mn

№2

CITI SCIENCE
2021 он №02

1 Ц.МӨНХБАТ
Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалтын албаны прокурор, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

**ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗАРИМ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА, ТУЛГАМДСАН АСУУДАЛ.....4**

2 Н.ОДОНТУУЛ
Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Дотоод хэргийн их сургуулийн докторант

**ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН СУДАЛГАА.....11**

3 Д.ЦЭНДСҮРЭН
Дэлхийн гаалийн байгууллагын Эрсдэлийн удирдлагын зөвлөх, Монголын гаалийн итгэмжит зөвлөх, Доктор (Ph.D)
Г.АЛТАНТОВЧ
«СИТИ» Их сургуулийн Бизнесийн сургуулийн Захирал, Дэд профессор

**БНХАУ, ОХУ-ЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ МОНГОЛ УЛСТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ...19**

4 Н.ОТГОНСАЙХАН
Худалдаа, үйлдвэрлэлийн их сургууль, Доктор (Ph.D)

**МОНГОЛ, ХЯТАДЫН НҮҮРСНИЙ ХУДАЛДААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....40**

5 XIAO-LI CAI
Lecturer in Visual Communication Design, Faculty of Digital Art and Design, the College of Guangzhou Nanyang Polytechnic, Guangzhou

**THE APPLICATION OF «BRAND-VISUAL-GENES» IN «SMALL TOURIST TOWNS» DESIGN.....50**

6 PUREVDASH MUNKHTOGTOKH
Assistant professor to the «CITI» University (MBA)

**MEASURING KNOWLEDGE.....57**

7 CHEN ZHENGHAN
«СИТИ» Их сургуулийн Хувцас дизайны магистрант
Б.АЛТАНХАЙЧ
«СИТИ» Их сургуулийн Хувцас дизайны тэнхимийн багш, магистр

**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН САДГҮЙ ХУВЦАС МОДУЛЬ АРГА ЗҮЙН СУДАЛГАА БОЛОН ХЭРЭГЛЭЭ.....63**

# Редакцын зурвас

Монголчууд бид 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталснаас хойш хууль, шүүхийн байгууллагын шинэчлэл, өөрчлөлтийн талаар “идэвхтэй” ярьсан боловч дорвитой ахиц гарсангүй. Авлига, хээл хахууль, хүнд сурталтай тэмцэж, нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгахад хууль, шүүхийн байгууллагын шударга, хараат бус, бие даасан үйл ажиллагаа нэн чухал. Шударга ёсыг тогтооход маш чухал асуудал бол хууль дээдлэх зарчим, тэр тусмаа Үндсэн хуульд төрийн бүх шийдвэр, үйл ажиллагааг нийцүүлэх явдал юм. Гэвч улс орны хамгийн чухал хууль Үндсэн хуулиа сахин биелүүлэхгүй, зөрчих явдал байсаар байгаа нь харамсалтай.

Энэ удаагийн дугаарт нийтлэгдсэн хууль зүйн ухааны доктор Ц.Мөнхбатын бичсэн өгүүлэлд хууль дээдлэх зарчмын тухай хөндөж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжсэн Прокурорын тухай хуулийн зохицуулалтын зарим тулгамдсан асуудлыг тодорхойлж, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болсныг судалгааны үндсэн дээр гаргасан нь чухал ач холбогдолтой юм. Энэ дашрамд дурдахад сэтгүүлийн редакцын зүгээс ч хууль, шүүхийн шинэчлэл, өөрчлөлтийг дэмжсэн бодлого баримтлан ажиллана.

Мөн эрүүгийн хариуцлагын нэг төрөл болох эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, зөвлөмж болон манай улсын гадаад худалдаанд хамгийн чухал нүүрсний экспорт, дэлхийн нүүрсний зах зээлийн төлөв байдал, Монгол Улсын нүүрсний экспортод БНХАУ-ын эзлэх байр суурь, БНХАУ-ын нүүрсний импортын зах зах зээлд Монгол Улсын эзлэх байр суурийн талаар сонирхолтой судалгааны ажил нийтлэгдсэн. Мөн зах зээлийн өрсөлдөөнд тэсэж үлдэх, амжилт олох түлхүүрүүдийн нэг инновац, мэдлэгийн хэмжүүрийн тухай болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан саадгүй хувцас зохион бүтээх модуль загварын тухай гэх мэт олон сонирхолтой бүтээлийг энэ удаагийн дугаараас уншаарай.

Сэтгүүлийн редакцын зүгээс манай улсын гадаад худалдааны гол түнш, стратегийн хамтрагч орнууд болох БНХАУ, ОХУ-ын гадаад худалдааны бодлого, зохицуулалтыг өөрийн орныхтой харьцуулсан судалгааны өгүүллийг онцолж байна. Монгол Улсын гадаад худалдаанд ОХУ 16.53 хувийг эзэлжээ. Тус улсаас импортолсон бараа 2005 онд 0.4 тэрбум ам.доллар байсан бол 2019 онд 1.79 тэрбум ам. долларт хүрч нэмэгджээ. Тэгвэл сүүлийн 15 жилд Монгол-Хятадын гадаад худалдааны эргэлт 71.27 тэрбум ам. долларт хүрсэн бөгөөд 2019 онд 8.85 тэрбум ам. долларт хүрсэн нь хамгийн өндөр өсөлтөд тооцогдож байна. Гадаад худалдааг хөнгөвчлөх, нэмэгдүүлэхэд учирч буй зарим саад бэрхшээлийг даван туулах арга замын талаар өгүүлэлд санал дэвшүүлсэн нь сонирхолтой юм.

Эрхэм уншигч Та бүхэн Сити-Science сэтгүүлд нийтлэгдсэн өгүүлэл, бүтээлийн талаарх санал, хүсэлтээ info@citi.edu.mn хаягаар ирүүлээрэй. Бид уншигчдынхаа санал, бодлыг анхаарч, сэтгүүлийн үйл ажиллагааг илүү сайжруулахын төлөө идэвхтэй ажиллах болно.

**Мэдлэг бол Хүч, Эрх чөлөө!**
**Scientia est Potentia, Libertas!**


## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

**ДАРГА:**

**Д.Мөнх-Эрдэнэ**
/«СИТИ» Их сургуулийн удирдах зөвлөлийн дарга/

**ДЭД ДАРГА:**

**Ц.Байгалмаа**
/«СИТИ» Их сургуулийн Ерөнхийлөгч/

**ГИШҮҮД:**

**Д.Энхбат**
/Захиргаа, хүний нөөцийн газрын захирал/

**Х.Наранхүү**
/Сургалтын бодлого, зохицуулалтын газрын захирал/

**Т.Сугарсүрэн**
/Инновац, бизнес хөгжлийн газрын захирал/

**Т.Алтанцэцэг**
/Гадаад харилцааны албаны захирал/

**Д.Отгонзаяа**
/Барилга, архитектур, дизайны сургуулийн захирал/

**Г.Алтантөвч**
/Бизнесийн сургуулийн захирал/

**Б.Одонгэрэл**
/Хууль зүйн сургуулийн захирал/

**И.Ундрахгэрэл**
/Хүмүүнлэгийн сургуулийн захирал/

**Ч.Дэлгэрцэцэг**
/Урлагийн сургуулийн захирал/

**Н.Чанцалдулам**
/Гоо сайхны сургуулийн захирал/

**НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**

**Д.Сандагсүрэн**
/Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч/

**ЭХ БЭЛТГЭСЭН**

**З.Райымбек**
/Сургалтын бодлого, зохицуулалтын газрын менежер/


## СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн зөвлөл нь дарга, гишүүд, нарийн бичгийн даргаас бүрдэнэ. Уг зөвлөл нь сэтгүүлийн нийтлэлийн бодлогыг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих, сэтгүүлийг цаашид хөгжүүлэх бодлого, чиглэлийг боловсруулж батлуулах эрхтэй.

https://www.citi.edu.mn/citi-science/

***Ц.МӨНХБАТ***
***Улсын Ерөнхий прокурорын газрын Сургалтын албаны прокурор,***
***Хууль зүйн ухааны доктор (Ph.D)***

# ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗАРИМ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

## Хураангуй

Эрх зүйн шинэчлэлтэй холбоотойгоор 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжсэн Прокурорын тухай хууль[1] дахь эрх зүйн зохицуулалтын зарим тулгамдсан асуудлыг тодорхойлж, нийгмийн хөгжлийн цаг үеийн шаардлагаар нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай болсныг судалгааны үндсэн дээр гаргаж, холбогдох санал, дүгнэлтийг дэвшүүлэн тавихыг зорьсон болно.

## Түлхүүр үгс

Үндсэн хууль, Прокурорын тухай хууль, прокурорын хяналт, харьцуулалт, тулгамдсан асуудал, нэмэлт, өөрчлөлт, шийдвэрлэх арга зам.

## I. ОРШИЛ

1992 оны Үндсэн хуульд хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн[2] гээд прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно[3] хэмээн заасан. Өөрөөр хэлбэл, прокурорын гүйцэтгэх чиг үүргийг тов тодорхой зааж өгсөн байна. Гэтэл Үндсэн хуульд огт заагаагүй чиг үүрэг буюу зөрчлийн хэрэг бүртгэлт, гүйцэтгэх ажилд тавих хяналтыг Прокурорын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль[4] болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх процессын хуульд оруулж мөрдүүлсэн нь анхаарал татаж байна.

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, хууль зүйн ухааны доктор, профессор Б.Чимид «Зөвхөн Үндсэн хууль, түүнд нийцүүлж баталсан хуулиуд л улс орны хэмжээнд нэгдмэл байдлыг тогтоож хамгаалах хуулийн дээд хүчинтэй, түүгээрээ нийгмийн бүх хөдөлгөөнийг жигдрүүлж, нэгдмэл байдлыг хангах хамгийн гол хэрэглүүр болно»[5] гэж тэмдэглэсэн байна. Прокурорын хяналттай холбоотой практикт хэрэгжиж буй хуулиуд нь давхардал, хийдэгдэл, зөрчилдөөнтэй байгаа нь хуулийг нэг мөр хэрэглэх, тулгарч буй асуудлыг шударгаар шийдвэрлэхэд таагүй нөлөөлөх нь бий. Хуулиуд хоорондоо амин холбоотой, нэг нь нөгөөтэйгээ авцалдан амсаж, аль алиныгаа дэмжин хамгаалж байдаг[6] ба хэрэв энэхүү шаардлагыг хангахгүй бол холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр хийж, шинэчилж байх нь чухал ач холбогдолтой юм. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нягт уялдсан байх ёстойг дурдах байна.

[1] Прокурорын тухай хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2017. №24
[2] Үндсэн хууль.Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 1992. №1. Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг
[3] Дурдсан эх сурвалж. Тавин зургадугаар зүйл 1 дэх хэсэг
[4] Гүйцэтгэх ажлын тухай хууль.Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 1998. №3
[5] Чимид.Б. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ., 2006. 147 дахь тал
[6] Чимид.Б. Төрийн засах ёс. УБ., 2019. 109 дэх тал

## II. ХУУЛИЙН ЗӨРЧИЛДӨӨН, НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

### А. Үндсэн хууль ба салбарын хуулийн зөрчилдөөн

Үндсэн хуульд тусгагдаагүй прокурорын хяналт буюу зөрчлийн хэрэг бүртгэлт болон гүйцэтгэх ажилд тавих хяналтыг Прокурорын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль[7], Шүүхийн шийдвэр гүйцэтгэх процессын хуульд оруулсанд судлаачийн хувьд шүүмжлэлтэй хандаж байна.

Тухайлбал, зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих прокурорын хяналт, гүйцэтгэх ажилд тавих хяналт[8], зөрчлийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхэд прокурор хяналт тавихаар хуульчилсан[9] байна.

Түүнчлэн ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналт гэдэгт судлаачийн хувьд зөвхөн Эрүүгийн хуульд заасан торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих, эрх хасах ял[10] эдлүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх болон холбогдох хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн, хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэхэд тавих хяналт зэргийг хамааруулж ойлгож байхад ял эдлүүлэхтэй ямар ч хамааралгүй тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа, баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд[11] тавих хяналтыг Прокурорын тухай хуульд оруулсан нь Үндсэн хуультай зөрчилдсөн байна.

Дээрх зөрчилдөөнийг шийдвэрлэх арга замыг хоёр хэлбэрээр тухайлбал, Үндсэн хуульд шинээр прокурорын хяналтын чиг үүргийг бүрэн тодорхой бичих, эсхүл хэрэгжиж байгаа салбарын хуулиас хасах байдлаар шийдвэрлэх боломжтой гэж харж байна. Бодит байдлыг судалж үзвэл Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах байдлаар прокурорын хяналтыг дэлгэрүүлж тусгах нь илүү оновчтой байна.

### Б. Хуульд нэмэлт оруулах

Үндсэн хуулийг дээдлэх ёсыг хууль дээдлэх суурь зарчим хэмээн судлаачид тэмдэглэсэн байдаг. Иймд Прокурорын тухай хуулийн 3 дугаар зүйл дахь прокурорын үйл ажиллагааны үндсэн зарчимд «хууль дээдлэх, гагцхүү хуульд захирагдах» зарчмыг нэмж тусгах нь зүй ёсны асуудал юм. Прокурорын тухай хуульд «Хуулийн нэр, томьёоны тодорхойлолт» байхгүй нь Хууль тогтоомжийн тухай хуульд[12] заасан шаардлагыг зөрчсөн байна. Тэгэхээр уг тодорхойлолтыг бий болгож, түүнд жишээ нь дагнасан прокурорын газар, нөлөөллийн мэдүүлэг, дээд шатны прокурор г.м өөр бусад ойлголтыг оруулах хэрэгтэй.

Нийгмийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэж байгаа прокурор албан тушаалтан юуг хийж болохгүйг заасан жагсаалтыг тухайлбал, «Прокурорт хориглох зүйл»-ийг хуульчлах нь прокурорыг сахилгажуулахад үр нөлөөтэй юм. Энэ талаар 2021 онд батлагдсан Шүүхийн тухай хуулиас[13] үлгэрлэн авах санаа их байна. Прокурор, прокурорын байгууллагын хараат бус байдлыг хангах, хариуцлага сахилгыг дээшлүүлэх, ашиг сонирхол, ёс зүйн зөрчил гаргасан бол прокурор хариуцлага хүлээдэг байх зарчмыг нарийвчлан зохицуулахад үр нөлөөтэй арга хэрэгсэл болно. Прокурор нь нийгмийн хэрэгцээ, шаардлагын үүднээс үргэлж хөгжиж байх шаардлагын үүднээс өөрийн хүсэлтээр ахисан түвшинд (магистр, доктор) мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор 2 жил хүртэл хугацаагаар гадаад улсад суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон тохиолдолд хөхиүлэн

[7] Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2017. №24.
[8] Прокурорын тухай хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2017. №24. 11-13, 25 дугаар зүйл
[9] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2017. №24. 300.2 дугаар зүйл
[10] Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2016. №7. 5.2 дугаар зүйл
[11] Прокурорын тухай хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2017. №24. 22 дугаар зүйл
[12] Хууль тогтоомжийн тухай хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2015. №25
[13] Шүүхийн тухай хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2021. №05. 50 дугаар зүйл

дэмжиж, ажлын байрыг нь хэвээр хадгалах нь боловсрол өндөртэй хүний нөөцийг тогтоон барихад үр дүнгээ өгнө.

Прокурорын мэргэжил, чадварыг сайжруулах, шүүн таслах ажиллагааны дадлага эзэмшүүлэх, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор өөр прокурорын газарт сэлгэн ажиллуулахдаа Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталсан журмаар биш, харин хуульчлах нь чухал асуудал юм.

Өмгөөллийн тухай хуулийн[14] «прокурор ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаа өнгөрөөгүй бол өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзах» тухай заалттай нийцүүлж, прокурор өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох заалтыг шинээр оруулах нь хууль хоорондын уялдаа холбоог хангана.

Прокурорын тухай хуулийн 67 дугаар зүйлд зааснаар прокурор хууль, байгууллагын дотоод журам, прокурорын мэргэжил, ёс зүйн дүрэм зөрчсөн, эсхүл хуульд заасан албан үүргээ биелүүлээгүй бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан ногдуулах сахилгын шийтгэлийн төрөлд «зэрэг дэв бууруулах» арга хэмжээ бий. Гэтэл Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2018 онд баталсан «Прокурорын зэрэг дэв тогтоох, олгох журам»-д[15] зааснаар хүндэтгэн үзэх шалтгаанаар ажил, албан тушаал шилжсэн тохиолдолд зэрэг дэвийг бууруулж байгаа нь үндэслэлгүй бөгөөд цаад утгаараа хүний эрхийг зөрчиж байна. Иймд сахилын шийтгэлээс бусад тохиолдолд прокурорын зэрэг дэвийг бууруулахгүй байхыг хуульчлах нь зүйтэй байна.

Прокурорт ногдуулах сахилгын шийтгэлийн төрлийг олшруулж тухайлбал, нээлттэй, хаалттай сануулах, прокурорын бүрэн эрхийг 3 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, огцруулах зэрэг шийтгэл байх боломжтой.

Прокурорын тухай хуулийг зөрчсөн этгээдэд ямар хууль тогтоомжид зааснаар хариуцлага хүлээлгэхийг тодорхой зааж өгөх шаардлагатай байна. Жишээ нь, «Энэхүү хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх, хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр» заах нь зүйтэй бөгөөд энэ нь Шүүхийн тухай хууль, Өмгөөллийн тухай хуультай нийцэх юм.

## В. Хуульд өөрчлөлт оруулах

Прокурорын тухай хуулийг хэрэгжүүлэх явцад зарим зүйлийг өөрчлөн найруулах нөхцөл үүссэн байна. Тухайлбал, хуулийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилтод «...прокурорт тавих болзол шаардлага, хараат бус» гэж өөрчлөх, Прокурорын тангарагийн[16] «... Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал хуульд заасан хариуцлагыг хүлээнэ» гэснийг «Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал прокурорын албан тушаалаас нэн даруй чөлөөлөгдөж, хуульд заасан хариуцлага хүлээнэ» гэх, «прокурор ажил, үүргээ гүйцэтгэх явцад амь насаа алдсантай холбогдон гарах аливаа хохирлыг төр хариуцах»[17] гэснийг «прокурор ажил, үүргээ гүйцэтгэх явцад амь насаа алдсантай холбогдон гарах аливаа хохирлыг төр хариуцаж, прокурорын амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг улсын төсвөөс гаргана» гэх заалт оруулах боломжтой. Мөн хуулийн 44 дүгээр зүйл дэх прокурорын байгууллагын албан тушаалын бүрэлдэхүүнд дурдсан Улсын Ерөнхий прокурор, Сум буюу сум дундын Ерөнхий прокурор нь нутаг дэвсгэрийн өргөн хүрээнд эрх мэдэл хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан байдлаар ойлгогдож байгаа бол Аймаг, нийслэл, дүүрэг, дагнасан прокурорын газрын Ерөнхий прокурор нь тухайн байгууллагын хэмжээний эрх

[14] Өмгөөллийн тухай хууль.Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2019. №49
[15] Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 08 дугаар зарлигаар батлагдсан.
[16] Прокурорын тухай хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2017. №24. 47 дугаар зүйл
[17] Дурдсан эх сурвалж. 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг

мэдэлтэн байхаар жижгэрч, өөр утгаар илэрхийлэгдэж байна.

Иймд Аймаг, нийслэл, дүүргийн Ерөнхий прокурор, дагнасан прокурорын газрын Ерөнхий прокурор гэж өөрчлөн найруулах, хуулийн 43 дугаар үйлийн 43.4 дэх хэсэгт «Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэд эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, прокурорыг мэргэшүүлэх сургалт, судалгааны нэгж байна» гэснийгойлгомжтойбайдлаар«Улсын Ерөнхий прокурорын дэргэд прокурорын байгууллагын хэрэгцээ, шаардлагад тулгуурлан сургалт зохион байгуулах, судалгаа мэдээллээр хангах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал, прокурорын шийдвэрийн хураангуй бэлтгэх, олон нийтэд мэдээлэх, эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, прокурорыг мэргэшүүлэх үүрэгтэй сургалт, судалгааны хүрээлэн байна. Хүрээлэнгийн бүтэц, орон тоо ажиллах журам, прокурорын сургалтын хөтөлбөр, үзэл баримтлалыг Улсын Ерөнхий прокурор батална» гэх, (Хүрээлэн нь эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах алба, зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах алба, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах алба, прокурорыг мэргэшүүлэх сургалтын алба гэсэн бүтэцтэй байх), Улсын Ерөнхий прокурор, түүний орлогчоор хуульчийн мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, 35 насанд хүрсэн прокурорыг томилох одоогийн заалт хэт явцуу бөгөөд цаашид прокурорын байгууллагыг «хайрцаглагдсан» хаалттай байх, хөгжлийн хувьд саарсан түвшинд хүргэх магадлал өндөр тул зөвхөн «прокурор» дотроос томилохыг өөрчилж,«сүүлийн 6 жилд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй хүнийг томилохыг хориглох» шалгуур тавьж нээлттэй байх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй болох нь судалгааны үр дүн харуулж байна.

## Г. Хуулийн зарим зүйл, хэсгийг хүчингүй болгох

Прокурорын тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалт нь практик хэрэглээний явцад хэрэгжих боломж үнэхээр муу, ажлын ачааллыг зохиомлоор нэмэгдүүлсэн нь хяналтын ажлын чанар, үр дүнд илт нөлөөлж[18] ирсэн байна. Хуулийг анх боловсруулах, хэлэлцүүлэх шатанд прокурорын хяналтын ажлын зохих туршлага дутмаг, цөөн тооны эрх бүхий албан тушаалтны[19] «Дээд шатны прокурорууд машин унахаас өөр ажил хийдэггүй тул тэднийг ажилтай болгох шаардлагатай» гэсэн хийсвэр дүгнэлт, шахалтаар хуульд тусгуулсан зарим зүйл, заалт цөөнгүй байна. Тухайлан, заримыг дурдвал Прокурорын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан «Хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалтын хэргийг хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн» тохиолдолд дээд шатны прокуророос доод шатны прокурорын шийдвэрийг заавал хянахаар хуульчилсан байгааг онцолж байна. Дээд шатны прокурор[20] хууль, журмаар хүлээсэн олон талт ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн талаар гомдол гаргасан эсэхээс үл хамааран дээрх үндэслэлээр хянаж байгаа нь ажлын ачааллыг эрс нэмэгдүүлснээс хэлбэрдэлт нь ихсэж хавтгайрсан ажээ.

Харин хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас дээд шатны прокурорт гомдол, хүсэлт, мэдээлэл ирүүлсэн тохиолдолд хянах нь зүй ёсны асуудал. Иймд уг заалтыг хүчингүй болгох саналыг фокус ярилцлагад оролцогчдын дийлэнх дэмжсэн байна.

Прокурорын тухай хуульд 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар нэмсэн Улсын Ерөнхий прокурор, түүний орлогчийн бүрэн эрх «...Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж гарсан»[21] тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн шийдвэр гарснаар хугацаанаас өмнө

[18] Орон нутгийн прокурорын байгууллагын удирдах ажилтнуудтай хийсэн фокус ярилцлагын материал. УБ., 2017-2020 он
[19] Прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөний үеэр хийсэн тэмдэглэлийн хураангуй. УБ., 2016
[20] "Дээд шатны прокурор" гэдэгт Улсын Ерөнхий прокурор, түүний орлогч, туслах прокурор, аймаг, нийслэл, дүүрэг , сум буюу сум дундын, дагнасан прокурорын газрын ерөнхий прокурорыг ойлгоно. Прокурорын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг үзнэ үү.
[21] Прокурорын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6.4 дэх хэсгийг үзнэ үү. Ц.М

дуусгавар болгохоос заасан нь прокурорын хараат бус байх зарчим, төрийн эрх мэдлийг хуваарилах зарчимд сөргөөр нөлөөлж байх тул хуулиас хасах ёстой гэсэн байр суурийг илэрхийлж байна.

## Д. Прокурорын хяналт тавих зарим бүрэн эрхэд хийсэн шинжилгээ

Прокурорын тухай хуулийн 15 дугаар зүйлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавих прокурорын бүрэн эрхийг зааж өгсөн. Шинжилгээ хийж үзвэл дараах нөхцөл байдал тогтоогдсон байна. Үүнд, хуулийн 15 дугаар зүйлийн «Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд гадна...» гээд 12 бүрэн эрхийг тодорхойлсны 4 буюу 33.3 хувь нь Эрүүгийн процессын хуульд байна. Тухайлбал, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад хяналт тавих харьяаллыг зааснаас тогтоох (15.1.2), хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөгч, прокурорын шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох (15.1.5), хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад мөрдөгчөөс гаргасан саналыг шийдвэрлэх (15.1.4), прокурорын хянан шалгах ажиллагаа явуулах (15.1.9) тухай байна. Үүнээс үзвэл Прокурорын тухай хуульд 12, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 24 прокурорын бүрэн эрхийг тусдаа мэт хуульчлагдсан боловч зарим заалт нь давхардсан байна. Нөгөө талаар хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх[22] хуулийн шаардлагыг хангаагүй байна.

Прокурорын тухай хуульд дурдсан 12 бүрэн эрхийн 5 буюу «Эрүүгийн хэрэгт дугаар олгох» (15.1.1), «Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий байгууллагын хамтарсан ажлын хэсэг байгуулах» (15.1.3), «Хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй явуулсан мөрдөн шалгах ажиллагааг хуульд заасны дагуу явуулсан эсэхийг хянаж, хүчинтэйд тооцох эсэхийг шийдвэрлэх» (15.1.6), «Прокурорын шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэх» (15.1.8), «Баривчлах, түр саатуулах, цагдан хорих байрандямар ч цагт саадгүй нэвтрэн орох баривчлагдсан, түр саатуулагдсан, хоригдсон этгээдтэй биечлэн уулзах, хууль бусаар баривчлагдсан, түр саатуулагдсан, цагдан хоригдсон, эсхүл хууль, шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар хоригдож байгаа этгээдийг даруй суллах» (15.1.7) зэргийг Эрүүгийн хянан шийдвэрлэх хуулийн 4.1 дүгээр зүйлд заасан прокурорын бүрэн эрхэд заавал тусгах шаардлагатай байна. Учир нь Эрүүгийн процессын ажиллагаанд оролцогчид нь салбарын хууль болох Прокурорын тухай хуулийг тэр бүр мэддэггүйгээс маргаан тэмцэл гаргах, бодит байдлыг үгүйсгэх нь их байна.

Мөн «Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах» (15.1.10), «Гэр бүлийн хүчирхийллийн улмаас хүний амь нас хохирсон гэмт хэрэгт прокурор яллах, дүгнэлт үйлдсэн, эсхүл хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн бол дүгнэлт гаргах (15.1.11) зэргийг «прокурорын эрх» гэж үзэх боломжгүй бөгөөд «прокурорын үүрэг» гэж судлаачийн хувьд дүгнэж байна. Энэ нь зарим талаараа мөн хуулийн 42 дугаар зүйлийн «Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, хараат бус бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн» гэсэн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой үүрэг гэж гэж байна.

---oOo---

[22] Хууль тогтоомжийн тухай хууль. Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ., 2015. №25. 29.17 дахь зүйл

## III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Ийнхүү 2017 оны Прокурорын тухай хуульд судалгааны дүнг үндэслэн дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Тухайлбал, Прокурорын хяналтын үйл ажиллагаатай эрх зүйн зохицуулалт боловсронгуй болоогүй дутмаг байна. Үндсэн хуульд байхгүй хяналтыг бусад хуульд тусгасныг хүчингүй болгох, эсхүл ийм боломжгүй бол Эх хуульд[23] нэмэлт, өөрчлөлт оруулж заавал тусгах шаардлагатай байна. Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр шуурхай хийж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байх нь хуулийн хэрэгжилтэд эерэгээр нөлөөлөх нь дамжиггүй. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа бусад хууль тогтоомжтой уялдуулах талаас анхаарах нь чанартай хууль гарах нэг нөхцөл бүрдэх юм. Судалгааны үндсэн дээр дараах саналыг тоймлон дэвшүүлж байна. Үүнд:

1.Үндсэн хуульд прокурорын хяналтын төрлийг бүрэн тусгах;

2.Шинээр батлагдсан Шүүхийн тухай хууль, Өмгөөллийн тухай хуулийн үзэл баримтлалтай Прокурорын тухай хуулийг уялдуулан боловсруулах;

3.Прокурор албан тушаалтны нийгмийн баталгааг хангах, сурч боловсрох, хөгжих боломжийг нээж өгөх зохицуулалтыг хийж, хуульчлан баталгаажуулах;

4.Хууль хоорондын зөрчилдөөн, хийдэгдэл, давхардлыг гаргахгүй байх байхад анхаарч, энэхүү илтгэлд дурдсан асуудлыг шийдвэрлэх талаас нь эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, тогтмол хугацаанд мониторинг хийж, үр дүнг тооцож холбогдох арга хэмжээ авах шаардлагатай байна.

## НОМ ЗҮЙ:


**А. Дотоодын хууль тогтоомж**

- Үндсэн хууль. УБ., 1992 он
- үйцэтгэх ажлын тухай хууль. УБ., 1998 он
- Хууль тогтоомжийн тухай хууль. УБ., 2015 он
- Эрүүгийн хууль. УБ., 2015 он
- Прокурорын тухай хуульУБ., 2017 он
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017 он
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017 он
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017 он
- Өмгөөллийн тухай хууль. УБ., 2019 он
- Шүүхийн тухай хууль. УБ., 2021 он
- Прокурорын зэрэг дэв тогтоох, олгох журам. УБ., 2018 он

**Б. Судалгааны өгүүлэл, нийтлэл**

- Орон нутгийн прокурорын байгууллагын удирдах ажилтнуудтай хийсэн фокус ярилцлагын материал. УБ., 2017-2020 он
- Прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөний үеэр хийсэн тэмдэглэлийн хураангуй. УБ., 2016 он
- Чимид.Б. Өнөөгийн улс төр хуульчийн нүдээр. УБ., 2006 он
- Чимид.Б. Төрийг засах ёс. УБ., 2019 он


[23] Үндсэн хуулийг нэрлэв. Ц.М



# Элсэлттэй холбоотой бүх мэдээллийг нэг дороос аваарай

*“СИТИ” Их сургуулийн цахим хуудсанд зочилж Элсэлттэй холбоотой бүх мэдээллийг нэг дороос аваарай!*

*Манай сургууль 1998 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөр анхан шатны болон ахисан түвшинд 2005, 2010 онуудад магадлан итгэмжлэгдэж, 2012 онд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас аттестатчилагдсан, хувийн хэвшлийн үүсгэн их, дээд сургуулиудын нэг юм.*

*Эдүгээ “СИТИ” Их сургууль 6 бүрэлдэхүүн сургуультай үйл ажиллагаа явуулж байна.*

https://www.citi.edu.mn/admission-2021/

***Н.Одонтуул***
***Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Дотоод хэргийн их сургуулийн докторант***

# ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН СУДАЛГАА

## Хураангуй

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн үндсийг 2015 оны Эрүүгийн хуулиар тодорхойлж, хэрэгжүүлэх үндэслэл, журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан. Дээрх хуулиуд хэрэгжих явцад эрх зүйн зохицуулалт ойлгомжгүй, шүүхээс нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэлтэй асуудал цөөнгүй гарах болсон. Энэхүү өгүүллээр эрүүгийн хариуцлагын нэг төрөл болох эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж боловсруулахыг зорьсон.

## Түлхүүр үг

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хэрэг хариуцах чадваргүй байдал, эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт.

## I. ОРШИЛ

2015 оны Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх эрх зүйн үндсийг тодорхойлж, хэрэгжүүлэх үндэслэл, журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан. Дээрх хуулиуд хэрэгжих явцад эрх зүйн зохицуулалт ойлгомжгүй, шүүхээс нэг мөр ойлгож хэрэглэхэд хүндрэлтэй асуудал цөөнгүй гарах болсон.

Энэхүү судалгааны ажлын дүгнэлт, санал нь эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний онол-эрх зүйн зохицуулалтын уламжлал, шинэчлэл, уг арга хэмжээг хэрэглэж буй өнөөгийн байдал, 2014-2020 онд анхан шатны шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн 110 шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийсэн судалгааны үр дүнд үндэслэгдсэн болно.

## II. ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭЖ БУЙ БАЙДАЛ

2015 оны Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйл болон 7.4 дүгээр зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй хүнд Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авч буй байдлыг сүүлийн 7 жилийн байдлаар судлан үзлээ.

Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд сүүлийн 7 жилд 77954 эрүүгийн хэрэг хүлээн авч, 4996 хэргийг мөрдөн байцаалтад буцааж, 67179 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, 78735 хүнийг гэм буруутайд тооцож, 16961 хүнд хорих ял оногдуулах болон оногдуулахгүйгээр тэнсэж, 70227 хүнд ял шийтгэл оногдуулжээ.[1]

[1] Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн Тайлан, УБ., 2014-2020 он

***Хүснэгт №1 Ял оногдуулсан байдал 2014-2008 он***

| Он | Шийдвэрлэсэн нийт эрүүгийн хэрэг | Гэм буруутайд тооцсон нийт хүн | Хорих ял оногдуулах болон оногдуулахгүйгээр тэнссэн | Ял шийтгэгдсэн нийт хүн |
|---|---|---|---|---|
| 2014 | 6375 | 8178 | 3396 | 8178 |
| 2015 | 6756 | 7696 | 3197 | 7696 |
| 2016 | 5762 | 6566 | 2866 | 6566 |
| 2017 | 8839 | 10040 | 962 | 9019 |
| 2018 | 12551 | 14925 | 2040 | 12366 |
| 2019 | 13427 | 15366 | 2167 | 13011 |
| 2020 | 13470 | 15964 | 2333 | 13391 |
| **Нийт** | **67179** | **78735** | **16961** | **70227** |

Анхан шатны шүүх сүүлийн 7 жилийн хугацаанд 26264 хүн, хуулийн этгээдийг торгох ялаар, 32179 хүнийг хорих ялаар, 1520 хүнийг албадан ажил хийлгэх ялаар, 6424 хүнийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар тус тус шийтгэж, 3333 хүнд баривчлах, 857 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авч, 113 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэсэн байна. (Хүснэгт N$^0$2)

***Хүснэгт №2 Ял, албадлагын арга хэмжээний төрөл***

| № | Ялын төрөл | Он | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 |
| 1 | Торгох | 285 | 370 | 216 | 2768 | 7437 | 7533 | 7655 |
| 2 | Албадан ажил хийлгэх ял | 442 | 463 | 376 | 239 | - | - | - |
| 3 | Баривчлах | 1053 | 957 | 733 | 581 | 8 | 1 | - |
| 4 | Хорих | 6277 | 5757 | 5114 | 4596 | 3245 | 3520 | 3670 |
| 5 | Нийтэд тустай ажил хийлгэх | - | - | - | 710 | 1683 | 1965 | 2066 |
| 6 | Зорчих эрхийг хязгаарлах | - | - | - | - | - | - | - |
| 7 | Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ | 110 | 132 | 117 | 123 | 127 | 124 | 124 |
| 8 | Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ | 11 | 16 | 10 | 5 | 23 | 28 | 20 |

Дээрх судалгаанаас үзэхэд, сүүлийн 7 жилд анхан шатны шүүхийн нийт шийдвэрлэсэн 67179 эрүүгийн хэрэгт 78735 хүнийг гэм буруутайд тооцож, үүнээс 113 буюу 0.14 хувьд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэлгүй эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан нь нийт ял шийтгэгдсэн этгээдүүдтэй харьцуулахад маш бага тоо юм.

Харин 2017 онд 5 хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн нь 2018 онд 23 болж өссөн дүнтэй байна. Энэ нь 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой юм.

## III. ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж байгаа шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах тулгамдсан асуудлууд байна. Үүнд:

1/Анхан шатны шүүх сэтгэцийн эмгэгтэй хүнд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ шүүгдэгчийг хууль ёсны төлөөлөгчтэй оролцуулалгүй хэргийг хянан шийдвэрлэжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.5 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт хохирогч нас барсан, эсхүл сэтгэцийн, эрүүл мэндийн шалтгаанаар өөрийн хүсэл сонирхлоо илэрхийлж чадахгүй тохиолдолд түүний төрсөн, үрчилж авсан эцэг, эх, эхнэр, нөхөр, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хууль ёсны төлөөлөгчөөр мөрдөгч, прокурор тогтооно гэж заасан.

Гэтэл гэмт хэрэг үйлдсэн хэрэг хариуцах чадваргүй этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хэлэлцэх шүүх хуралдаанд түүний хууль ёсны төлөөлөгчийг оролцуулаагүй тохиолдол багагүй хувийг эзэлж байна. Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад “хөгжлийн бэрхшээл, сэтгэцийн, эсхүл хүнд өвчний улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ эдэлж чадахгүй” шүүгдэгч оролцох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч заавал оролцуулахаар заасан. Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, эсхүл гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон хүнд холбогдох хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэхдээ улсын яллагч, өмгөөлөгчийг оролцуулахаар хуульчилсан болно.

Цаашид Сэтгэцийн Эрүүл мэндийн тухай хууль болон Гэр бүлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар мөрдөн шалгах ажиллагаанд сэтгэцийн эмгэгтэй хүний хууль ёсны төлөөлөгчийг урьдчилан тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж байх шаардлагатай байна.

2/Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно” гэж заажээ. Шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж буй шийдвэрийг авч үзвэл шүүх Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтыг үндэслэн сэтгэцийн эмгэгтэй хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг 1 сараас 8 жил хүртэл хугацаагаар хэрэглэсэн байна.[2]

Судалгаанаас үзэхэд, шүүхээс тогтоосон хугацаа дуусгавар болсон хэдий ч тухайн этгээдийн сэтгэцийн байдал засрал сайжрал олоогүй тохиолдолд шүүхийн шийдвэргүйгээр эмнэлгийн байгууллагад уг этгээдийг үргэлжлүүлэн эмчилсээр байна.

Эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно гэж заасан хэдий ч практикт сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдлын улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдийн сэтгэцийн эмгэг хэзээ засарч сайжрахыг шинжээчийн дүгнэлтээр урьдчилан тогтоох боломжгүй талаар шинжээч эмч нар тайлбарладаг.

Судалгаанаас харахад цөөн тохиолдолд шинжээч эмч шүүхийн

[2] Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2019 оны 9 дүгээр сарын 16-ны №1000 шийтгэх тогтоол, Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017 оны 11 дүгээр сарын 02-ны №206 шийтгэх тогтоол, Өвөрхангай аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2017 оны 11 дүгээр сарын 22-ны №152 шийтгэх тогтоол, мөн шүүхийн 2018 оны 5 дугаар сарын 30-ны №87 шийтгэх тогтоол, мөн шүүхийн 2018 оны 7 дугаар сарын 06-ны №128 шийтгэх тогтоол, Өвөрхангай аймаг Хархорин сум дахь Сум дундын шүүх 2018 оны 5 дугаар сарын 18-ны №39 шийтгэх тогтоол, Архангай аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2018 оны 9 дүгээр сарын 19-ний №189 шийтгэх тогтоол.

хэлэлцүүлэгт оролцож, хугацааны талаар санал гаргасан байх ба ихэнх тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар хугацааг тогтоосон, зарим тохиолдолд шүүхийн шийдвэрт огт хугацаа заагаагүй байна. Түүнчлэн, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг сунгах эсэхийг шүүх шийдвэрлэнэ гэж заасан боловч юуг үндэслэн, ямар хугацаагаар сунгах эсэх нь тодорхойгүй, хүндрэлтэй байна. Тухайлбал, тухайн этгээдийг эмчлэх хугацааг шийтгэх тогтоолд заасан байх боловч уг тогтоосон хугацаанд тухайн этгээдийн сэтгэцийн байдал засрал сайжрал олоогүй, эдгэрээгүй тохиолдолд дахин ямар хугацаа тогтоож сунгах нь ойлгомжгүй байна.

3/Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 4.2-т “Шүүх гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн эрүүл мэндийн улмаас хэрэг хариуцах чадваргүй нь тогтоогдсон шүүгдэгчийн сэтгэцийн байдал нь өөртөө, эсхүл бусдад аюул учруулахаар байвал эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх, эсхүл сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлэх шийдвэр гаргана”, мөн зүйлийн 7 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад прокурор хяналт тавьж, уг арга хэмжээг зогсоох, хугацааг сунгах, тухайн шүүгдэгч эдгэрсэн нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдвол эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шүүхээр шийдвэрлүүлнэ” гэж тус тус заасан.

Шүүхийн практикаас үзэхэд, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан этгээдийн сэтгэцийн байдал албадан эмчилгээний үр дүнд засрал сайжрал олсон, хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагч нар өөрийн асрамжид авахаар хүсэлт гаргасан тохиолдолд шүүх эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн уг арга хэмжээг зогсоож, албадан эмчлэгдэж буй этгээдийг асран хамгаалагчид халамжлуулахаар шийдвэрлэж байна.

Шүүх хэрэг хариуцах чадваргүй байдал арилаагүй боловч сэтгэцийн байдал засарч сайжирсан, түүнийг асран хамгаалагч болон гэр бүлийн гишүүд нь асрамжиндаа авах хүсэлт гаргасан тохиолдолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхийг зогсоож, асран хамгаалагчийн асрамжид шилжүүлэн өгч Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн “...сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно” гэснийг төсөөтэй хэрэглэж байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох үндэслэл журмыг нарийвчлан тогтоох шаардлага бий болж байна.

4/Монгол Улсын хэмжээнд “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ” хэрэглэхээр шийдвэрлэсэн этгээдийг Эрүүл мэндийн яамны харьяа Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд албадан эмчилж байгаа бөгөөд 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг ... шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно” гэж, мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.1 дэх хэсэгт “гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана” гэж тус тус заасан.

Харин дээрхи хуулиудад 2002 оны Эрүүгийн хуульд тусгагдсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт этгээдийн хувийн байдлыг харгалзаж ямар төрлийн эмнэлэгт эмчлэх зохицуулалт орхигдсон байна. Дээрх байдлаас шалтгаалан анхан шатны шүүх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг тогтоохдоо Эрүүгийн хуульд заагаагүй нэр томьёог хэрэглэж байна. Тухайлбал, шүүх шийтгэх тогтоолдоо “Донтох

эмгэгийн клиник”, “Сэтгэцийн эмгэг судлалын хуулийн тасгийн энгийн зэрэглэлийн тасаг”, “Шүүх сэтгэц эмгэг судлалын энгийн клиник”, “Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний ердийн тасаг”, “Сэтгэцийн эмгэг судлалын хуулийн тасгийн энгийн зэрэглэлтэй тасаг” гэж тус тус бичжээ. Мөн хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг ердийн тасагт, хөнгөн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг тусгай тасагт албадан эмчлэхээр заасан байх боловч энэ тухай үндэслэлээ шийдвэртээ бичээгүй. 2002 оны Эрүүгийн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулах шаардлагатай гэж шүүх үзвэл тухайн этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан албадлагын арга хэмжээний төрлийг тогтооно”, мөн зүйлийн 2, 3 дахь хэсэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг сэтгэцийн эмгэг судлалын ердийн болон тусгай эмнэлэгт байлгахаар хуульчилж байсан нь оновчтой зохицуулалт юм.

Тиймээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг ямар үндэслэлээр тогтоохыг хуульчилж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах нь хууль ёсны зарчмын агуулгад нийцнэ.

5/Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд холбогдсон этгээдэд Зөрчлийн хуулийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүнийг хэрэг хариуцах чадваргүйд тооцно”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Зөрчил үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд шийтгэл оногдуулахгүйгээр хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно” гэсэн зохицуулалтыг үндэслэн шүүх зөрчилд холбогдогчид эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэжээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүх зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нийтлэг журмыг удирдлага болгоно” гэж заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй, сэтгэцийн эмгэг, эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүн гэмт хэрэг үйлдсэн, эсхүл гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн өвчнөөр өвчилсний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон яллагдагч, шүүгдэгчид эмнэлгийн чанартай алдбадлагын арга хэмжээ хэрэглэхдээ энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ бүлэгт заасан тусгай журмыг удирдлага болгоно” гэж заажээ.

Дээрх зохицуулалтаас харахад, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19 дүгээр бүлэгт заасан журмыг зөвхөн гэмт хэрэг үйлдсэн яллагдагч, шүүгдэгчид хэрэглэхээр заасан бөгөөд зөрчил шалган шийдвэрлэхдээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг удирдлага болгох боломжгүй. Тиймээс зөрчлийн шинжтэй үйлдэлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх журмыг хуульчлах шаардлагатай байна.

## IV. ДҮГНЭЛТ

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл, журмыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан боловч шүүхийн практикт дээрх хуулиудад заасан зохицуулалтыг хэрэглэхэд хүндрэл учирч байна. Тухайлбал, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх эмнэлгийн дэглэм, хугацааг тодорхой заагаагүй, уг арга хэмжээ авсан үндэслэл арилаагүй, эсхүл сунгах тохиолдолд хэрхэн шийдвэрлэх, Зөрчлийн тухай хуульд заасан эмнэлгийн чанартай арга хэмжээг хэрэглэхэд ямар журам баримтлах зэрэгт хүндрэл гарч байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт согтуурсан,

мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүн согтуурах, мансуурах донтох эмгэгтэй болох нь тогтоогдвол түүнд оногдуулсан ял дээр нэмж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно гэж хуульчилсан боловч анхан шатны шүүхүүд согтуурах, мансуурах донтох эмгэгтэй ял шийтгэгдсэн хүнд энэ арга хэмжээг хэрэглэн Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлэх талаар практик тогтоогүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэрэг шалган шийдвэрлэх үед хэрэг хариуцах чадваргүй болсны улмаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоож ял оногдуулна гэсэн заалт шүүхийн практикт хэрэгждэггүй байна. Судалгаанаас үзэхэд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилж, түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байгаа нь анхаарал татаж байна.

Түүнчлэн хэрэг хариуцах чадваргүй байдал нь арилсан этгээдэд авсан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зогсоох, ял оногдуулах асуудлыг шүүх нэг дор шийдвэрлэх боломжгүй бөгөөд хэрхэн ял оногдуулах нь тодорхойгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан сэтгэл заслын, донтох зуршлын эсрэг эмчилгээ хийлгэх эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно[3] гэж заасны дагуу шүүх хэрэг хариуцах чадваргүй этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ сэтгэл заслын болон донтох зуршлын эсрэг ямар эмчилгээ хийлгэхийг ихэнх тохиолдолд шийдвэртээ дурдаагүй орхисон зэрэг процессын алдаа гарч байна.

## V. САНАЛ

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

1/ Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдлын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй этгээдийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгчийг оролцуулахгүй байгаа алдааг засч, цаашид Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль болон Гэр бүлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар мөрдөн шалгах ажиллагаанд хууль ёсны төлөөлөгчийг урьдчилан тогтоож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж байх;

2/ Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авсан үндэслэл ямар хугацаанд арилах боломжтой эсэх талаар эмнэлгийн байгууллага дүгнэлт гаргаж чадахгүй байгаа, эсхүл эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан эмчлэгдэх боломжгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тухайн хүнийг хэрхэн шийдвэрлэх асуудлыг тодорхой хуульчлах;

3/ Шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсний дараа уг этгээдийн сэтгэцийн байдал албадан эмчилгээний үр дүнд засрал сайжрал олсон болох нь эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон, хууль ёсны төлөөлөгч болон асран хамгаалагч нар асрамжид авах хүсэлт гаргасан тохиолдолд эмчилгээний үр дүн, өвчний шинж байдлыг харгалзан уг арга хэмжээг зогсоож, албадан эмчлэгдэж буй этгээдийг асран хамгаалагчид халамжлуулахаар шийдвэрлэх талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой хуульчлах;

[3] Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг

4/ Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “...дэглэм...” гэснийг хасч, уг зүйлд “...тухайн этгээдийн сэтгэцийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан албадлагын арга хэмжээний төрлийг тогтооно” гэсэн өөрчлөлт оруулж хуульчлах;

5/ Шүүхийн шийдвэрт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Шүүхийн сэтгэц эмгэг судлалын клиник”-т хэрэгжүүлж байгаа тул энэ клиникийн тасагт гэж, мөн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхдээ сэтгэл заслын болон донтох зуршлын эсрэг ямар эмчилгээ хийлгэхийг тусган зааж байх;

6/ Шүүх гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан шүүхийн тогтоолд сэтгэл заслын болон донтох зуршлын эсрэг эмчилгээний аль нь болохыг тодорхой зааж байх;

7/ Согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүн согтуурах, мансуурах донтох эмгэгтэй болох нь тогтоогдвол түүнд оногдуулсан ял дээр нэмж эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно гэж хуульчилсныг цаашид хэрэгжүүлж практик тогтоох зэрэг болно.

## VI. НОМ ЗҮЙ

**Нэг. Монгол Улсын хууль тогтоомж**

- Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1992. №01
- Гэр бүлийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 1999. №30
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/. //Төрийн мэдээлэл. УБ., 2016. №7
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №23
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль /шинэчилсэн найруулга/. Төрийн мэдээлэл. УБ., 2013. №3
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ., 2017. №24
- “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам” Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн А/240, А/369 дүгээр хамтарсан тушаал

**Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага, нэг сэдэвт бүтээл, эмхэтгэл**

- Монгол Улсын Дээд Шүүх, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010
- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар, УБ, 2003
- С.Жанцан. “Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургааль/” II боть. УБ., 2014
- Л.Эрдэнэбаяр. “Шүүхийн сэтгэц эмгэг судлалын лекцүүд”. УБ., 2005
- С.Бямбасүрэн, Ш.Дорждамба. “Шүүхийн сэтгэц гэм судлал” УБ.,1990
- ХЗДХЯ, ШШГЕГ, ХСИС, ШУТСан. “Албадлагын арга хэмжээнд тавих хяналтын тогтолцоо: хэрэгжилт, чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2018
- Шүүхийн Ерөнхий Зөвлөл, “Монгол Улсын Шүүхийн тайлан” 2014-2020”. УБ., 2020

# CITI CONCEPT STORE

*СИТИ Их сургуулийн бусдаас ялгагдах өвөрмөц байдал, нэр хүндийг гадагш илэрхийлэх гол зүйл бол Сити брэнд бүтээгдэхүүнүүд билээ.*

*Бид Алсын хараа болон стратеги төлөвлөгөөндөө өөрсдийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх ажлыг онцгойлон тусгасаны эхлэл болгож дурсгалын зүйлс болон хувцасны коллекцыг бүтээн хөгжүүлж эхлээд байна. Цаашид уг ажил улам өргөжин нэр төрлөө нэмэн Сити брэндийн эко системийн салшгүй нэг хэсэг болох юм.*

## CITI CONCEPT STORE



Hoodie

₮130000

САГСАНД ХИЙХ



Bomber B

₮200000

САГСАНД ХИЙХ




Bomber A

₮200000

САГСАНД ХИЙХ




Кофены аяга

₮12000

САГСАНД ХИЙХ

www.citi.edu.mn/citi-stor

***Д.ЦЭНДСҮРЭН***
***Дэлхийн гаалийн байгууллагын Эрсдэлийн удирдлагын зөвлөх,***
***Монголын гаалийн итгэмжит зөвлөх, Доктор (Ph.D)***

***Г.АЛТАНТОВЧ***
***«СИТИ» Их сургуулийн Бизнесийн сургуулийн***
***Захирал, Дэд профессор***

# БНХАУ, ОХУ-ЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ МОНГОЛ УЛСТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

## Товч хураангуй

Монгол Улс нь дэлхийн улс төр, эдийн засгийн нөлөө бүхий ОХУ, БНХАУ-тай зэрэгцэн оршдогийн хувьд эдгээр орнуудтай нийгэм, эдийн засгийн болон бусад бүх салбарт хамтран ажилладаг. Үүний нэг нь худалдааны салбар. Салбарын хөгжилд төрийн байгууллага, түүний дотор гаалийн байгууллага гол үүрэг гүйцэтгэх бөгөөд улс орнууд худалдааны бодлого, гаалийн тариф, гаалийн хяналтын үйл ажиллагааг ижилтгэх, уялдуулах, стандартчлах зарчмыг баримталж ирсэн.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бодлого, чиглэл болон худалдааны үйл ажиллагаанд хяналт тавих гаалийн байгууллагууд хэрхэн хамтран ажиллаж, худалдааны урсгалыг саадгүй нэвтрүүлэх боломжийг харьцуулан судалсан.

БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдаанд гол байр суурь эзлэх тул тус улсын гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын бодлогыг түлхүү авч үзсэн бол, ОХУ-ын дамжуулан өнгөрүүлэх бодлого, гаалийн холбооны бодлого, чиглэлийг судалгаанд авч үзлээ.

## Түлхүүр үг

Гадаад худалдаа, гаалийн хамтын ажиллагаа, худалдааг хөнгөвчлөх.

## Оршил

Монголын улс төр, эдийн засгийн орчинд 1990 онд томоохон өөрчлөлт орж, нэг намын системээс олон намын системд, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэн. Энэ үеэс дэлхийн улс орнуудтай найрамдалт харилцааг хөгжүүлж, эдийн засгийг либералчлах, худалдааг хөнгөвчлөх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлд олон чухал алхмуудыг хэрэгжүүлж ирсэн билээ.

Монгол Улс Дэлхийн гаалийн байгууллагад 1991 онд, Дэлхийн худалдааны байгууллагад 1997 онд тус тус гишүүнээр элсэн орсноор гадаад худалдааны үйл ажиллагааг дэлхийн жишигт нийцүүлэн, эдгээр байгууллагаас гаргасан зохицуулалтуудын дагуу явуулах шаардлага бий болжээ. Улмаар 2006 онд Дэлхийн гаалийн байгууллагын шинэчлэн найруулсан Киотогийн конвенцид нэгдэн орж, гаалийн горимыг хялбаршуулах, уялдуулах, стандарчилах үйл ажиллагааг олон улсын жишигт нийцсэн байдлаар хэрэгжүүлэхээр болсон. Мөн уг конвенцид нэгдэн орсны дараа Гаалийн тухай хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2008 онд тус тус батлан гаргаж, холбогдох дүрэм, журам,

зааврыг шинэчлэн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Ийнхүү Монгол Улс бусад орнуудын адилаар хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагаанд өөрчлөлт, шинэчлэлт хийж, түнш орнуудын холбогдох байгууллагатай хамтран ажиллах замаар гадаад худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагааг хэрэгжүүлж ирлээ.

Энэхүү судалгаагаар дэлхийн худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаа, бодлого, чиглэлийг тодорхойлоход гол үүрэг гүйцэтгэх Дэлхийн гаалийн байгууллага (ДГБ), Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-аас гаргасан бодлогын баримт бичгийн хүрээнд хөрш орнуудтай хамтран ажиллах боломжийг өнөөгийн байдалтай харьцуулан судалж, тодруулахыг зорьлоо.

## А. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО ЧИГЛЭЛ, ХӨРШ ОРНУУДТАЙ ХАРЬЦУУЛСАН ХАРЬЦУУЛАЛТ

Гадаад худалдааны бодлогыг харьцуулан судлахын тулд өнөөгийн гүйцэтгэл буюу худалдааг хэмжих хил дамнасан үндсэн үзүүлэлтүүдийг судалгааны ажлын энэ хэсэгт харьцуулан авч үзсэн. ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бараа эргэлтийн хэмжээг Монгол Улстай харьцуулахад харилцан адилгүй байгаа нь хүн амын тоо, газар зүйн байрлал, хөгжлийн түвшинтэй шууд холбоотой.

Иймд хөрш орнуудтай хийсэн гадаад худалдааны эргэлтийг харьцуулан судлахаас гадна гурван орны гадаад худалдааны эргэлт, түнш орон, барааны тоог ДГБ-ын Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн конвенцийн 6 орны түвшинд харьцуулан Хүснэгт 1-т үзүүллээ.

***Хүснэгт 1. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны статистик, түнш орон, барааны тоогоор (2016-2019 он, тэрбум ам. доллар)***

| Он | | | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|---|---|
| **Монгол Улс** | | | | | | |
| **Экспорт** | Статистик дүн | 1 | 4.91 | 6.2 | 7.01 | 7.62 |
| | Түнш орон | 2 | 68 | 67 | 75 | 78 |
| | Барааны тоо (БТКУС 6 орон) | 3 | 880 | 892 | 896 | 765 |
| **Импорт** | Статистик дүн | 4 | 3.36 | 4.33 | 5.87 | 6.12 |
| | Түнш орон | 5 | 135 | 145 | 141 | 153 |
| | Барааны тоо (БТКУС 6 орон) | 6 | 3,385 | 3,497 | 3,527 | 3,403 |
| **Худалдааны тэнцэл** | | 7 (4-1) | 7 (4-1) | 1.87 | 1.14 | 1.50 |
| **Нийт худалдаа** | | 8 (1+4) | 8 (1+4) | **10.53** | **12.88** | **13.74** |
| **ОХУ** | | | | | | |
| **Импорт** | Статистик дүн | 1 | 182.26 | 226.97 | 238.15 | 243.78 |
| | Түнш орон | 2 | 200 | 217 | 202 | 209 |
| | Барааны тоо (БТКУС 6 орон) | 3 | 4,889 | 4,968 | 4,961 | 4,950 |
| **Экспорт** | Статистик дүн | 4 | 285.49 | 357.08 | 449.35 | 422.78 |
| | Түнш орон | 5 | 194 | 193 | 192 | 193 |
| | Барааны тоо (БТКУС 6 орон) | 6 | 4,735 | 4,780 | 4,772 | 4,817 |
| **Худалдааны тэнцэл** | | 7 (4-1) | 103.23 | 130.12 | 211.20 | 179.00 |
| **Нийт худалдаа** | | 8 (1+4) | **467.75** | **584.05** | **687.50** | **666.56** |

| БНХАУ | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Импорт** | Статистик дүн | 1 | 1,588.70 | 1,840.96 | 2,134.99 | 2,068.95 |
| | Түнш орон | 2 | 212 | 215 | 216 | 217 |
| | Барааны тоо (БТКУС 6 орон) | 3 | 4,881 | 5,010 | 5,001 | 4,989 |
| **Экспорт** | Статистик дүн | 4 | 2,118.98 | 2,271.80 | 2,494.23 | 2,498.57 |
| | Түнш орон | 5 | 213 | 214 | 215 | 216 |
| | Барааны тоо (БТКУС 6 орон) | 6 | 4,851 | 4,999 | 4,990 | 5,009 |
| **Худалдааны тэнцэл** | | 7 (4-1) | 530.28 | 430.84 | 359.24 | 429.62 |
| **Нийт худалдаа** | | 8 (1+4) | **3,707.68** | **4,112.75** | **4,629.22** | **4,567.52** |

*Эх сурвалж: *2018 он The World Integrated Trade Solution software* (Software, 2020); *Дэлхийн Гаалийн Байгууллагын 2018/2019 оны үйл ажиллагааны тайлан* (WCO, WCO Annual Report 2018/2019, 2019), *Олон улсын худалдааны төв http://www.intracen.org/itc/market-info-tools/statistics-import-country-product/ (2018)* Хүснэгт 1-д аль нэг улсын давуу байгааг харьцуулахаас илүүтэй эдгээр гурван улсын гадаад худалдааны цар хүрээг ерөнхий байдлаар үзүүлэхийг зорьсон[1].

Улс орнуудын эдийн засаг, түүний дотор гадаад худалдааны өсөлтөд гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт, ялангуяа татварын бодлого гол байр суурь эзэлнэ. Буурай хөгжилтэй, хөгжиж байгаа орны хувьд илүү тогтвортой бодлого баримтлан гадаадын хөрөнгө оруулагчийг татахыг эрмэлздэг бөгөөд энэ нь сайтар нягтлаагүй тохиолдолд эргэн эрсдэл үүрүүлэх боломжтой байдаг. Харин өндөр хөгжилтэй орны хувьд дотоодын зах зээлийг хамгаалсан, алслагдмал бүс нутгийн хөгжлийг дэмжсэн ялгаатай бодлого баримталдаг.

*Гадаад худалдааны үйл ажиллагаанд* гаалийн байгууллага гол үүрэгтэй оролцдог. ДГБ-аас өөрийн гишүүн орнуудын гүйцэтгэлийг харьцуулан жилийн үйл ажиллагааны тайландаа тусгадаг.

***Хүснэгт 2. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зарим мэдээлэл (2018/2019)***

| Д/д | Гүйцэтгэлийн үзүүлэлт, бусад мэдээлэл | | Монгол Улс | ОХУ | БНХАУ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гадаад худалдааны бараа эргэлт (тэрбум ам. доллар) | | 12.8 | 687.4 | 4,629.1 |
| | Үүнээс: | Импорт (тэрбум ам. доллар) | 5.8 | 238.1 | 2,134.9 |
| | | Экспорт (тэрбум ам. доллар) | 7.0 | 449.3 | 2,494.2 |
| 2 | Импортын гаалийн мэдүүлгийн тоо (мян.шир.) | | 248.8 | 777.05 | 23,559.8 |
| 3 | Экспортын гаалийн мэдүүлгийн тоо (мян.шир.) | | 524.9 | 1,089.9 | 55,715.4 |
| 4 | Улсын төсвийн орлогод гаалийн орлогын эзлэх хувь | | 33.3 | - | 23.1 |
| 5 | Үүнээс: | Гаалийн албан татвар (%) | 25.0 | 59.4 | 14.4 |
| | | Нэмэгдсэн өртгийн албан татвар (%) | 51.7 | 37.2 | 0.0 |
| | | Онцгой албан татвар (%) | 19.5 | 1.6 | 85.6 |
| | | Экспортын гаалийн татвартай бараа (%) | 0.0 | | 0.1 |
| | | Бусад татвар (%) | 3.8 | 1.8 | 0.0 |
| 6 | Гаалийн албан хаагчийн тоо | | 1,407 | 43,669 | 100,000 |
| 7 | Импорт, экспортын зөвшөөрөл холбогдох баримт бичиг олгох эрх бүхий байгууллагын тоо | | 11 | 42 | 14 |
| 8 | Нэг цонхны системд холбогдсон үйл ажиллагаа | | - | 4 | 14 |

[1]Олон улсын валютын сангаас гаргасан мэдээллээр 2019 онд БНХАУ-ын ДНБ 15.54 триллион ам. доллар, нэг хүнд ногдох ДНБ 10,747 ам. доллар, дэлхийн улс орнуудаас 2 дугаар байр, ОХУ-ын ДНБ 1.67 триллион ам. доллар, нэг хүнд ногдох ДНБ 11,426 ам. доллар, дэлхийн улс орнуудаас 12 дугаар байр, Монгол Улсын ДНБ 14.96 тэрбум ам. доллар, нэг хүнд ногдох ДНБ 4,563 ам. доллар, дэлхийн улс орнуудаас 126 дугаар байранд тус эрэмбэлэгджээ (IMF, 2019).

*Эх сурвалж: ДГБ-ын 2018/2019 оны үйл ажиллагааны тайлан (ДГБ, 2019), Олон улсын худалдааны төв http://www.intracen.org/itc/market-info-tools/statistics-import-country-product/*

Хүснэгт 2-т үзүүлсэн гурван улсын гаалийн байгууллагын гүйцэтгэлийн зарим үзүүлэлтийг харьцуулсан харьцуулалт хэн нэг нь илүү, дутуу гэдгийг харуулахыг зориогүй бөгөөд гаалийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, гадаад худалдааг хөнгөвчлөх замаар гадаад худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг дэмжих боломжийг харуулахыг зорьсон. Орчин үеийн гаалийн байгууллага үйл ажиллагаандаа хууль сахиулах болон худалдааг хөнгөвчлөх гэсэн эрс тэрс хоёр чиг үүргийг тэнцвэртэйгээр хангахдаа эрсдэл тооцох арга зүйд суурилсан гаалийн хяналтыг нэвтрүүлж байна. Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үндсэн үзэл баримтлал нь өндөр эрсдэл бүхий ачилтыг шалган, бага, эсхүл хүлээн зөвшөөрөх эрсдэл бүхий ачилтыг бүрдүүлэлтийн дараа болон өмнө шалгах боломжийг олгосон. Иймд эрсдэлийн удирдлага нь ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрт худалдааг хөнгөвчлөх арга хэмжээ болж орсон байдаг (ДХБ, 2013).

Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг «Бизнес эрхлэхүй» дүгнэлтийн «Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт» нь гадаад худалдааны үйл ажиллагаа хил дээр хэрхэн хэрэгжиж байгааг харуулсан гол шалгуур болдог. Энэхүү үзүүлэлтийг хэмжих шалгуурыг 2016 оноос өөрчлөн зөвхөн хил дээрх хяналтын үйл ажиллагааг хамруулдаг болсон.

***Хүснэгт 3. Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт 2020, гурван улсын харьцуулалт***


| Үзүүлэлт | Монгол Улс (143) | ОХУ +(99) | БНХАУ (56) |
|---|---|---|---|
| Экспортын хугацаа: Хилийн үйл ажиллагаа (цаг) | 134 | 66 | 21 |
| Экспортын зардал: Хилийн үйл ажиллагаа (USD) | 225 | 580 | 256 |
| Экспортын хугацаа: Бичиг баримт бүрдүүлэх (цаг) | 168 | 25 | 9 |
| Экспортын зардал: Бичиг баримт бүрдүүлэх (USD) | 64 | 92 | 74 |
| Импортын хугацаа: Хилийн үйл ажиллагаа (цаг) | 48 | 30 | 36 |
| Импортын зардал: Хилийн үйл ажиллагаа (USD) | 210 | 520 | 241 |
| Импортын хугацаа: Бичиг баримт бүрдүүлэх (цаг) | 115 | 43 | 13 |
| Импортын зардал: Бичиг баримт бүрдүүлэх (USD) | 83 | 153 | 77 |

*Эх сурвалж: Дэлхийн банк, Бизнес эрхлэхүй дүгнэлт 2020, Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт (WB, 2020)*

Хүснэгт 3-аас харахад хилийн үйл ажиллагааны зардал ОХУ-д хамгийн өндөр 520-590 ам.доллар, бичиг баримт бүрдүүлэх хугацаа нь Монгол Улсад хамгийн өндөр, БНХАУ-д бага байна. Эндээс төрийн байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо, давхардал, мэдээллийн технологи, дэд бүтцийн хөгжил зэрэг худалдаанд нөлөөлөх гол хүчин зүйлийн түвшин харагдаж байна.

«Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт»-ийг 2016 онд өөрчилснөөс хойш гурван улсын байр дараах байдалтай байна.

***Зураг 1. Дэлхийн банкны "Бизнес эрхлэхүй" дүгнэлт, "Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт": Монгол Улс, ОХУ, БНХАУ (2016-2020 он)***




*Эх сурвалж: Дэлхийн банк, Бизнес эрхлэхүй дүгнэлт 2016-2020, Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт (WB, 2020)*

Зураг 1-д үзүүлснээс харахад «Хил дамнасан худалдаа хийх үзүүлэлт»-ээр Монгол Улсын зэрэглэл буурч, харин хөрш орнуудын үйл ажиллагаа сайжирсаар байгаа нь харагдаж байна. «Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт 2020 тайлан»-д дурдсанаар ачилтын мэдээллийг урьдчилан авах үйл ажиллагааг нэмэгдүүлсэн, боомтын дэд бүтцийг сайжруулсан, гаалийн байгууллага үйл ажиллагаагаа сайжруулсан, хураамжийн хэмжээг ил нийтлэх болсон зэрэг нь БНХАУ-ын үзүүлэлтэд ахиц гаргахад нөлөөлжээ.

Харин Монгол Улсын үзүүлэлт яагаад ийнхүү буурсныг харьцуулан үзэхэд импортын бүрдүүлэлттэй холбоотой цаг хугацаа, зардлын өөрчлөлт гарсан нь ийнхүү 190 орноос 143-т ороход нөлөөлсөн байна. «Хил дамнан худалдаа хийх үзүүлэлт»-ийг сайжруулахад хилийн хяналтын, түүний дотор гаалийн хяналтын үйл ажиллагааг хялбаршуулах, уялдуулах шаардлагатай. Иймээс худалдааг хөнгөвчлөх арга хэмжээний нэг болох эрсдэлийн удирдлага нь гадаад худалдаанд оролцогч нэг байгууллагаар хязгаарлахгүй нэгдсэн байдлаар эрсдэлээ тооцох хэрэгцээ шаардлага бий болгодог. Хэдийгээр ачилтад хамрагдах барааны төрөл, тоо, шинж чанараас шалтгаалан гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацаа нь харилцан адилгүй байдаг боловч эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх замаар бараг экспортлох болон импортлох хугацааг богиносгох боломжтой юм.

Судалгааны дараагийн хэсэгт хөрш орнуудын гадаад худалдааны бодлого болон хоёр талт хамтын ажиллагаа, гадаад худалдааны мэдээллийг сүүлийн 15 жилийн байдлаар авч үзлээ.

## Б. ОХУ-ЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ХОЁР УЛСЫН ГАДААД ХУДАЛДАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

ОХУ-ын гадаад худалдааны бодлогод Евразийн эдийн засгийн холбоо (ЕЭЗХ) гол үүрэг гүйцэтгэдэг. Евразийн эдийн засгийн холбооны гаалийн кодекс (Customs Code of the Eurasian Economic Union)-д тодорхойлсны дагуу дамжин өнгөрөх барааны тээвэрлэлтийн гаалийн хяналт нь бүс нутгийн хэмжээнд Дамжуулан өнгөрүүлэх гаалийн ажиллагааг зохион байгуулах журмын дагуу явагдана. Ерөнхийдөө ЕЭЗХ-ны нутаг дэвсгэрт гадаад худалдаа, гаалийн ижил дүрэм, журам, горим үйлчилнэ. Иймд ОХУ-ын Засгийн газраас саяхан буюу энэ оны 5 дугаар сард батлсан «Холбооны гаалийн албаны 2030 он хүртэлх урт хугацааны хөгжлийн стратеги»-д ОХУ-ын гадаад худалдаа, тээврийн бодлого дараах байдлаар тусгагдсан байна. Үүнд:

1/гадаад худалдааг хөгжүүлэхдээ гол төлөв экспортын чиг баримжаатай салбарын өрсөлдөх чадварын давуу талыг ашиглахад, түүхий эдээс бусад бүтээгдэхүүний экспортын нэр төрөл болон цар хүрээг өргөжүүлэхэд, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэлийг

нэмэгдүүлэхэд хөшүүрэг болдог гаалийн бүрдүүлэлтийн горимыг практикт өргөнөөр хэрэглэх;

2/ОХУ-ын үндэсний язгуур эрх ашигт нийцсэн гадаад худалдааны болон хөрөнгө оруулалтын газар зүйн байршлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3/Евразийн эдийн засгийн хорооны гишүүн бус орнуудаас ирэх барааны хөдөлгөөнийг хялбаршуулах;


4/ОХУ-д (-аас) оруулсан (гаргасан) бараа, дамжин өнгөрөх бараа болон эрсдэлгүй барааны гаалийн бүрдүүлэлтийг 2030 он гэхэд үе шаттайгаар бүрэн цахимжуулах замаар худалдааны урсгалыг нэмэгдүүлэх;

5/гадаад худалдаанд оролцогчдод тулгарах төрийн байгууллагын хяналт, захиргааны арга хэмжээний дарамтыг багасгах;

6/гадаад худалдаа эрхлэгч хууль бус практик ажиллагаанд оролцохгүй байх болон гадаад дотоодын худалдааг ил тодоор хийх нөхцөл боломжтой байхаар гаалийн байгууллагын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагааг чиглүүлэх.

Монгол Улс, ОХУ-тай уламжлалт сайн хөршийн харилцаатай. Монгол Ардын Засгийн газар, Зөвлөлт Оросын Засгийн газрын хооронд найрсаг харилцаа тогтоох тухай гэрээг анх 1921 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр байгуулсан бөгөөд 2015 оны байдлаар Боловсрол, шинжлэх ухаан, соёл, технологи, эдийн засаг; Худалдаа, эдийн засаг; Хил, хилийн дэглэм; Төмөр зам; Геологийн салбар; Зээлийн хэлэлцээр, тусламж; Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ; Батлан хамгаалах гэрээ; Батлан хамгаалах зэрэг 40 төрлийн 257 баримт бичгийг байгуулсан байна. (яам, 2016)[2]

***Зураг 2. Монгол Улс ОХУ-ын Засгийн газар хооронд 1921-2015 оны хооронд байгуулсан баримт бичгийн чиглэл, эзлэх хувь***





*Эх сурвалж: Монгол Улс ОХУ-ын харилцааны лавлах[3] (ГХЯ, Гадаад харилцааны яамны цахим хуудас, 2015)*

Зураг 2-аас харахад хоёр орны Засгийн газар хооронд «Боловсрол, шинжлэх ухаан, соёл, технологи, эдийн засаг» төрлөөр байгуулсан баримт бичиг хамгийн их буюу 18 хувийг эзэлсэн ба үүний дараа «Худалдаа, эдийн засаг» төрөл 13 хувийг эзэлжээ. 2005-2019 оны Монгол-Орос улсын гадаад худалдааны эргэлтийг зураг 3-аас харна уу.

[2] Монгол Улсын Гадаад харилцааны яамнаас гаргасан мэдээлэлд зөвхөн тус яамны олон улсын гэрээ, хэлэлцээр хариуцсан нэгжид бүртгүүлсэн Засгийн газар хооронд байгуулсан баримт бичгийг багтаажээ.

[3] 2015 оны 4 дүгээр сараас хойш хоёр орны Засгийн газар хооронд байгуулсан баримт бичиг ороогүй.

***Зураг 3. Монгол Улс ОХУ-тай хийсэн гадаад худалдааны нийт эргэлт (2005-2019 он, сая ам. долл.)***




*Эх сурвалж: Гадаад худалдааны статистик мэдээлэл (газар Г. е., Гадаад худалдааны статистик мэдээлэл, 2005-2019)*

Зураг 3-аас харахад хоёр улсын хооронд хийсэн гадаад худалдааны эргэлт харилцан адилгүй байна. Сүүлийн 15 жилд Монгол – Оросын хооронд 18.93 тэрбум ам.долларын гадаад худалдаа хийжээ. Монгол Улсын гадаад худалдаанд 2005 оноос хойш ОХУ-ын эзэлсэн хувийг дараах хүснэгтээс харна уу.

***Хүснэгт 4. Монгол Улсын гадаад худалдаанд ОХУ-ын эзлэх хувь (2005-2019 он)***

| | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Экспорт | 2.56 | 2.93 | 3.00 | 3.41 | 3.62 | 2.85 | 2.00 | 1.81 | 1.45 | 1.07 | 1.65 | 1.13 | 1.09 | 1.23 | 0.89 |
| Импорт | 35.50 | 38.17 | 36.14 | 38.29 | 36.15 | 32.71 | 24.62 | 27.42 | 24.57 | 29.59 | 26.89 | 26.22 | 28.06 | 29.11 | 28.23 |
| **Нийт** | **19.86** | **19.92** | **20.04** | **22.99** | **20.90** | **18.49** | **15.08** | **17.32** | **15.28** | **14.63** | **12.97** | **11.31** | **12.19** | **13.94** | **13.08** |

*Эх сурвалж: Гадаад худалдааны статистик мэдээлэл (газар Г. е., Гадаад худалдааны статистик мэдээлэл, 2005-2019)*

Хүснэгт 4-өөс харахад сүүлийн 15 жилийн дунджаар Монгол Улсын гадаад худалдаанд ОХУ 16.53 хувийг эзэлжээ. Монгол Улсаас ОХУ-д экспортолсон барааны нэр төрөл, статистик дүнд багахан хэмжээний өөрчлөлт орсон байна. Харин тус улсаас импортолсон бараа 2005 онд 0.4 тэрбум ам. доллар байсан бол 2019 онд 1.79 тэрбум ам. долларт хүрч нэмэгдсэн байна. Импортын хэмжээ нэмэгдсэн хэдий ч барааны бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй бөгөөд нефть бүтээгдэхүүний импортын хэмжээ өссөн.

## В. БНХАУ-ЫН ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ХОЁР УЛСЫН ГАДААД ХУДАЛДАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

БНХАУ дэлхийн эдийн засгийн нөлөө бүх улс орны хувьд өөрийн орны худалдааны бодлогод байнга анхаарч ирсэн. Тус улсаас нэмүү өртөг шингэсэн барааг экспортлох, энэ нь дотооддоо жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах, үндэсний үйлдвэрлэл дэмжих зэрэг өндөр ач холбогдолтой. БНХАУ-ын гадаад худалдаа «Дэлхийн үнийн сүлжээ»-д гол байр суурь эзэлж байна.

Дэлхийн худалдааны 80 орчим хувь нь Дэлхийн үнийн сүлжээ (ДҮС)-ээр дамжин явагдаж байгаа бөгөөд үүнд «Барааг дотоодод болон гадаадад боловсруулах» гаалийн горим гол үүрэг гүйцэтгэж байна. ДҮС-ний торон хэлхээг дурандан харах нэг өвөрмөц тал нь боловсруулах горим ашиглан хийх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа) юм. Боловсруулах горим ашиглан хийх худалдаа гэдэг нь компаниуд түүхий эдээ өөр өөр улсаас авч, өөр нэг улсад угсарч, эцсийн бүтээгдэхүүнийг гуравдагч орны зах зээлд гаргах процесс юм. БНХАУ-ын боловсруулах горим ашиглан хийх худалдаа нь тус улс өөрчлөлт, шинэчлэлт, нээлттэй бодлого явуулсан цагаас эхлэн ийнхүү хурдацтай өссөн нь дээрх статистикаас харагдаж

байна. Түүнчлэн БНХАУ-ын аж үйлдвэржилтийн процессыг хурдасгах, аж үйлдвэрийн бүтцийг өөрчлөн шинэчлэх ажлыг идэвхжүүлэх, шинээр ажлын байр бий болгох, эдийн засгаа дэлхийн эдийн засагтай нэгтгэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

***Зураг 4. БНХАУ-ын боловсруулах горим ашиглан хийгдэх худалдааны бодлогын систем***

**Нэгдүгээрт**

- (гаалийн) баталгаат горимын бодлогын хүрээнд эд анги, материал боловсруулахаар оруулж ирэхэд гаалийн татвар, НӨАТ авдаггүй;
- зөвхөн тэдгээрийн заримыг дотоодын зах зээл дээр борлуулсан тохиолдолд л татвар ногдуулдаг.

**Хоёрдугаарт**

- боловсруулах горим ашиглан хийгдэх худалдаа (нэмүү өртөг шингэсэн худалдаа)-ны хувьд хатуу бус хяналтын бодлого мөрддөг.
- Цөөн тооны эмзэг (хориглосон, хязгаарласан) барааг эс тооцвол импортын материалд холбогдох зөвшөөрөл (лиценз) шаарддаггүй;
- тийм зөвшөөрөл (лиценз)-ийг зөвхөн зарим материалыг дотоодын зах зээлд борлуулах тохиолдолд шаарддаг.

**Гуравдугаарт**

- гадаадын талаас дотоодын талд үнэ төлбөргүй өгсөн боловсруулах тоног төхөөрөмжийг гаалийн татвар, лицензээс чөлөөлдөг.

*Эх сурвалж: ДГБ, Дотоодод болон гадаадад боловсруулах горимын тухай ДГБ-ын гарын авлага, 2017 он*

Дэлхийн үнийн сүлжээ нь сүүлийн 10 жилд, ялангуяа Хятадын экспортод чухал үүрэг гүйцэтгэж байна. 1979-2016 оны хооронд БНХАУ-ын боловсруулах горим ашиглан хийсэн худалдааны нийт импорт, экспортын үнийн дүн 235 сая ам.доллараас 1.11 их наяд ам.доллар болж өссөн бөгөөд энэ горимын тус улсын гадаад худалдаанд эзлэх хувь 1.5-30.2 хувь хүртэл нэмэгдсэн. Боловсруулах горим ашиглан хийх худалдааны үр дүнд шууд байдлаар 40 сая, шууд бус байдлаар 60 сая ажлын байр бий болгожээ (ДГБ, 2017).

БНХАУ-ын гадаад худалдааны гол түнш орон АНУ юм. Сүүлийн жилүүдэд АНУ-ын томоохон корпорациуд үйлдвэрээ БНХАУ руу нүүлгэж байсан нь хөдөлмөрийн хөлсний хямд зардал, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих бодлоготой нь шууд холбоотой. Түүнчлэн дээр дурдсан дэлхийн үнийн сүлжээ мөн нөлөөлсөн гэж үзэж болно.

БНХАУ-д 2008 оноос хүчин төгөлдөр болсон Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуулиар (Corporate Income tax law) гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн орлогын татварыг 25 хувь болгосон ба 2007 оны 03 дугаар сарын 16-аас өмнө үйл ажиллагаагаа эхэлсэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд нь 15 хувийн татвар төлөхөөр уг хуульд заасан байна.

БНХАУ-д хувь хүний орлогын татварыг 3-45 хувийн татвар ногдуулж байна. Жижиг компаниуд тодорхой тохиолдолд 20 хувийн аж ахуйн нэгжийн татвар төлдөг. Компаниуд тодорхой бүс нутгуудад 10 хувийн татвар төлдөг бол өндөр технологийн компаниуд 15 хувийн татвар төлдөг байна.

Гадаад худалдаа эрхлэгч (экспорт, импорт) аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ногдуулах татварын эрх зүйн зохицуулалтад 2016 онд шинэ журам нэвтрүүлжээ. Өөрөөр хэлбэл, импортын, эскпортын барааны нэр төрлөөс хамаарч түүнд ногдуулах татвар, хураамжийг ялгаатай зохицуулсан байна. Тухайлбал, БНХАУ-д импортолсон бүх бараанд 13 хувийн гаалийн татвар, бүх бараанд нэмэгдсэн өртгийн албан татвар 17 хувиар ногдуулж байна. Харин экспортын барааанд 0 татварыг ногдуулж байна.

***Зураг 5. БНХАУ-ын худалдааны хориглолт, хязгаарлалт***

**Хязгаарласан салбар:**

- Ховор, үнэ цэнэтэй ашигт малтмалын нөөцийн хайгуул, олборлолтын салбар.


**Хориглосон салбар:**

- Үндэсний аюулгүй байдал, Улсын батлан хамгаалахын аюулгүй байдалд халдсан;
- Хүрээлэн буй орчин, Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй;
- Байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалтад сөрөг нөлөө үзүүлэх;
- Хятадын ховор уламжлалт технологийг хэрэглэх;
- Радио идэвхт бүтээгдэхүүний хайгуул, олборлолт;
- Ерөнхий боловсролын салбар.

Зураг 5-д БНХАУ-д худалдааны хориглолт, хязгаарлалтад хамаарах салбарыг үзүүлсэн.

Монгол Улс нь БНХАУ-тай 1949 оны 10 дугаар сарын 16-ны өдөр дипломат харилцаа тогтоосон ба гадаадын хөрөнгө оруулагч орнуудыг Хятад Улс сүүлийн 14 жил тэргүүлж байна[4]. Хоёр улсын Засгийн газар хооронд 2015 оны байдлаар 41 төрлийн 132 баримт бичгийг байгуулжээ.

***Зураг 6. Монгол Улс БНХАУ-ын Засгийн газар хооронд 1955-2015 оны хооронд байгуулсан баримт бичгийн чиглэл, эзлэх хувь***





Эх сурвалж: Монгол Улс БНХАУ-ын харилцааны лавлах (ГХЯ, 2015)

Зураг 6-гаас харахад хоёр орны Засгийн газар хооронд байгуулсан баримт бичигт «Худалдаа, эдийн засаг» 11 хувийг эзэлсэн ба «Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр» нь хоёр орны худалдааг хөгжүүлэхэд томоохон үүрэг гүйцэтгэсэн. Монгол Улс нь БНХАУ-тай эдийн засаг, худалдааны харилцааг шинэ агуулга хэлбэрээр баяжуулан хөгжүүлж, 2020 он гэхэд

[4]1990-2013 оны байдлаар Монгол Улсад БНХАУ-ын талаас 3.8 тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт хийгээд байна.

худалдааны нийт эргэлтийг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг 2014 онд[5] «БНХАУ болон Монгол Улсын иж бүрэн стратегийн түншийн харилцааг хөгжүүлэх тухай хамтарсан тунхаг»-т дэвшүүлсэн. Монгол – Хятад хоёр улсын 2005-2019 оны гадаад худалдааны эргэлтийг зураг 10-аас харна уу.

***Зураг 7. Монгол Улс БНХАУ- тай хийсэн гадаад худалдааны нийт эргэлт (2005-2019 он, сая ам. долл.)***




*Эх сурвалж: Гадаад худалдааны статистик мэдээлэл (газар Г. е., Гадаад худалдааны статистик мэдээлэл, 2005-2019)*

Сүүлийн 15 жилд Монгол – Хятадын гадаад худалдааны эргэлт 71.27 тэрбум ам. долларт хүрсэн бөгөөд 2019 онд 8.85 тэрбум ам. долларт хүрсэн нь хамгийн өндөр өсөлтөд тооцогдож байна. Монгол Улсын 2005 оноос хойш гадаад худалдаанд БНХАУ-ын эзэлсэн хувийг дараах хүснэгтээс үзнэ үү.

***Хүснэгт 5. Монгол Улсын гадаад худалдаанд БНХАУ-ын эзлэх хувь (2005-2019 он)***

| | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 | 2019 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Экспорт | 48.24 | 68.06 | 72.47 | 64.55 | 73.93 | 84.80 | 92.16 | 92.59 | 86.82 | 87.86 | 83.74 | 79.36 | 85.60 | 93.31 | 89.11 |
| Импорт | 25.76 | 25.43 | 27.59 | 27.70 | 25.19 | 30.34 | 30.67 | 27.80 | 28.67 | 33.76 | 36.60 | 31.60 | 32.96 | 33.96 | 33.63 |
| **Нийт** | **36.43** | **47.51** | **49.39** | **43.86** | **48.04** | **56.27** | **56.62** | **53.34** | **52.03** | **62.13** | **62.60** | **59.98** | **63.93** | **66.25** | **64.38** |

*Эх сурвалж: Гадаад худалдааны статистик мэдээлэл (газар Г. е., Гадаад худалдааны статистик мэдээлэл, 2005-2019)*


Хүснэгт 5-аас харахад БНХАУ нь Монгол Улсын гадаад худалдааны эргэлтэд 2010 оноос хойш 50-иас дээш хувь, экспортод 80-аас дээш хувийг эзлэх болжээ. Сүүлийн 10 жилд Монгол Улсын гадаад худалдааны эргэлт БНХАУ-аас шууд хамаарч байна. Иймд ДХБ, ДГБ-аас баталсан олон улсын гэрээ, хэлэлцээр болон хоёр талт хамтын ажиллагааг зохицуулсан баримт бичгийн хүрээнд БНХАУ-тай хийж байгаа гадаад худалдааны бодлого, зохицуулалт, гадаад худалдаа, гаалийн үйл ажиллагаагаа уялдуулах шаардлагатай байна.

## Г. МОНГОЛ – ОРОС – ХЯТАДЫН НЭГДЭН ОРСОН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХҮРЭЭНД ГАДААД ХУДАЛДААНЫ БОДЛОГО, ЧИГЛЭЛИЙГ УЯЛДУУЛАХ БОЛОМЖ

Судалгааны ажлын энэ хэсэгт Монгол Улсын хөрш орнуудын гадаад худалдааны бодлого, зохицуулалтууд нь ДХБ, ДГБ-аас батлан гаргасан гадаад худалдаа, гаалийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн хүрээнд хэрхэн хамтран ажиллах боломжийг тодорхойлохыг зорьсон. НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комиссын судалгаанд гадаад худалдааны бодлогод нөлөөлөх хүчин зүйлийг дараах зурагт үзүүлснээр тодорхойлсон байдаг.

[5] БНХАУ-ын Ши Жиньпин дарга 2014 оны 8 дугаар сард Монгол Улсад айлчлах үед талууд Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтсоныг зарлан 2020 он гэхэд худалдааны хэмжээг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилт дэвшүүлжээ.

***Зураг 8. Гадаад худалдааны бодлогод нөлөөлөх хүчин зүйл***




*Эх сурвалж. НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комисс*

Гадаад худалдааны бодлогод зөвхөн тариф, татварын бодлого нөлөөлөхгүй болохыг Зураг 8-д үзүүлсэн. Өөрөөр хэлбэл, гадаад худалдааны бодлогод «Гаалийн тариф 0-10, Бодлого зохицуулалт 60-90 хувь, Газар зүйн байршил 30 хувь» нөлөөлөх боломжтойг улс орнуудын бодлогыг харьцуулан судалж гаргасан байна. Гадаад худалдааны бодлого, чиглэлийг тодорхойлоход улс төрийн зөв бодлого, шийдвэр чухал. Гэтэл дан ганц чөлөөт худалдааны, эсхүл эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулснаар эдийн засгийн хөгжлийг түргэсгэх тухай зарим шийдвэр гаргагчдын дунд байдаг өрөөсгөл ойлголтыг НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн комиссын дээрх судалгаа няцааж байна.

Гаалийн тариф нь ДХБ-д нэгдэн орохдоо улс орнуудын авсан үүрэг амлалт буюу тааз тарифын хэмжээнээс хамаарна. Энэ хэсэгт ДГБ-аас батлан гаргасан олон улсын гэрээ, хэлэлцээр, бодлогын баримт бичгийг харьцуулан судалсан гол зорилго нь улс хооронд хийх хил дамнасан худалдаанд хяналт тавих үндсэн чиг үүргийг гаалийн байгууллага хэрэгжүүлдэг. Иймд гурван улсын гаалийн үйл ажиллагааг[6] уялдуулснаар худалдааны эргэлтийг түргэсгэх, худалдааг хөнгөвчлөх боломж бүрдэх юм. Өөрөөр хэлбэл, гаалийн байгууллагын чиг үүрэгт худалдааг дэмжих, үндэсний үйлдвэрлэлийг хамгаалах бодлого хамаарах тул эдгээр байгууллагын үйл ажиллагааг уялдуулснаар Монгол Улсын гадаад худалдаа өсөн нэмэгдэх, мөн гаалийн зарим горимын тусламжтай (Тухайлбал, гаалийн баталгаат бүс, чөлөөт бүс, бараг дотоодод болон гадаадад боловсруулах гаалийн горим) эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой юм.

Гаалийн үйл ажиллагааг уялдуулахад ДГБ, ДХБ-аас гаргасан бодлогын баримт бичгийн хүрээнд хамтран ажиллахад үр дүн гарах нь дамжиггүй. Хүснэгт 6-д гадаад худалдаатай холбоотой ДГБ, ДХБ-аас гаргасан гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон огноог харьцуулан үзүүллээ *(Хавсралт 2. Монгол Улсын соёрхон батлсан гадаад худалдаа, гаалийн үйл ажиллагаатай холбоотой олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээр).*

[6] ДГБ-ын “Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай” конвенцид “гаалийн хуулийн хэрэгжилтийг хангуулах, гаалийн болон бусад татварыг хураан авах, мөн импорт, экспорт болон барааны хадгалалт, хөдөлгөөнтэй холбоотой бусад хууль, журмуудыг мөрдөх чиг үүрэг бүхий Засгийн газрын үйлчилгээний албыг гаалийн байгууллага хэмээнэ” гэж гаалийн алба болон түүний гүйцэтгэх чиг үүргийг хамтад нь тодорхойлсон.

***Хүснэгт 6. ДГБ, ДХБ-аас гаргасан зарим гэрээ, хэлэлцээр, бодлогын гол баримт бичигт Монгол Улс, ОХУ, БНХАУ нэгдэн орсон байдал****

| Д/д | Баримт бичгийн нэр | Монгол Улс | ОХУ | БНХАУ |
|---|---|---|---|---|
| **1** | ДГБ-ын Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай конвенц (ДГБ байгуулах тухай Конвенц) | 1991 | 1991 | 1983 |
| **2** | ДГБ-ын Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн конвенц | 1993 | 1997 | 1993 |
| **3** | ДГБ-ын Гаалийн горимыг хялбарчилах, уялдуулах тухай олон улсын конвенц | 2006 | 2002 | 2001 |
| **4** | ДГБ-ын Дэлхийн худалдааг аюулгүй байлгах хөнгөвчлөх багц стандарт | 2005 | 2005 | 2005 |
| **5** | Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай хэлэлцээр (ДХБ-ын Хэлэлцээр, Марракешийн Хэлэлцээр) | 1997 | 2012 | 2011 |
| **6** | ТХЕХ-ийн 1994 оны VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (Үнэлгээний Хэлэлцээр) | 1997 | 2012 | 2011 |
| **7** | ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр | 2016 | 2016 | 2015 |

**гэрээ хүчин төгөлдөр болсон огноо*
*Эх сурвалж: ДГБ (ДГБ, 2019), Дэлхийн Худалдааны Байгууллагын албан ёсны цахим хуудас (ДХБ, Олон улсын гэрээ, хэлэлцээр, 2019)*

Хүснэгт 6-д гурван улсын хооронд гадаад худалдааны бодлого, гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах боломж олон улсын түвшинд бүрдсэнийг илтгэж байна. Улс орны эдийн засгийн хөгжилд гадаад худалдаа, түүний дотор тариф, татварын бодлого гол байр суурь эзэлдэг. Монгол Улс гадаад худалдааны гол түнш орнуудтай зөвхөн хоёр талт хамтын ажиллагаагаар хязгаарлагдахгүй, олон улсын түвшинд хамтран ажиллах боломжтой хэдий ч өөрийн боломжийг бүрэн дүүрэн ашиглаагүй болох нь дараах хүснэгтэд үзүүлсэн харьцуулсан мэдээллээс харагдаж байна.

***Хүснэгт 7. Импортын тарифын хувь хэмжээ, тарифын хэлэлцээр (2018 он, БНХАУ, ОХУ, Монгол Улс)***

| Импортын тарифын хувь хэмжээ | БНХАУ | ОХУ | Монгол |
|---|---|---|---|
| Хамгийн өндөр тариф (%) | 695.50 | 100 | 40 |
| Энгийн дундаж тариф (%) | 7.56 | 4.92 | 5.04 |
| Худалдааны жигнэсэн дундаж тариф (%) | 3.39 | 3.51 | 5.26 |
| Тарифын хэлэлцээр байгуулсан тоо | 24 | 5 | 2 |

*Эх сурвалж: The World Integrated Trade Solution software (Software, 2020*)

Хүснэгт 7-гоос харахад Монгол Улсын гадаад худалдааны гол түнш орнуудад мөрдөх импортын барааны тарифын хувь хэмжээ нь улс орон бүр өөрийн үндэсний үйлдвэрлэлийг тарифын бодлогоор хамгаалах арга хэмжээний түвшин харилцан адилгүй байна. Импортын барааны хамгийн өндөр гаалийн тариф БНХАУ-д 695.5 хувь, ОХУ-д 100 хувь, харин Монгол Улсад хамгийн бага буюу 40 хувь байна. Хамгийн өндөр тарифын хувь хэмжээ харилцан адилгүй боловч, жигнэсэн дундаж тарифын хувь хэмжээ хөрш орнууд ойролцоо, Монгол улс ойролцоогоор 1.6 хувиар хөрш орнуудаас илүү байна. Энгийн дундаж тарифын хувь хэмжээ БНХАУ, Монгол Улсад ойролцоо бол, БНХАУ эдгээр хоёр улсаас ойролцоогоор 2.56 хувиар илүү байна.

Энэ нь БНХАУ дэлхийн эдийн засгийн хөгжилд гол үүрэг гүйцэтгэх орон бөгөөд дэлхийд хүн амын тоогоор тэргүүлэгч, түүнчлэн тус улсын худалдааны бодлого үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ялангуяа дэлхийн үнэ цэнийн сүлжээнд гол байр эзлэх орон. Иймд импортын энгийн дундаж тариф нь Монгол Улс, ОХУ-тай харьцуулахад өндөр байна.

Монгол Улсын зарим албан татварын хувь хэмжээг хөрш орнуудтай харьцуулан үзүүллээ.

***Хүснэгт 8. Монгол Улсын зарим албан татварын хувь хэмжээг хөрш орнуудтай харьцуулсан харьцуулалт, хувиар***

| Татварын төрлүүд | Хятад | ОХУ | Монгол |
|---|---|---|---|
| **Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар** | 10-25 | 15.5-20 | 10-20 |
| **НӨАТ** | 17 | 20 | 10 |
| **Роялти** | 10 | 20 | 2.5 |
| **Нийгмийн хандив, дэмжлэг** | Сайн дурын | Шаарддаг | Сайн дурын |

*Эх сурвалж: https://www.pwc.com/gx/en/energy-utilities-mining/publications/pdf/pwc-gx-miining-taxes-and-royalties.pdf*

Хүснэгт 8-д үзүүлсэн гурван улсын зарим татварын хэмжээнээс харахад ОХУ-д аж ахуйн нэгжийн орлогын албан татварын доод хувь, НӨАТ, Роялти өндөр байна. БНХАУ-д аж ахуйн нэгжийн орлогын албан татвар үйл ажиллагааны төрлөөс хамаарч 10-25 хувь, НӨАТ 17 хувь байна. Монгол Улсад эсрэгээрээ хөрш орнуудтай харьцуулахад бага татвар ногдуулдаг байна. Сонирхол татсан нэг асуудал нь ОХУ-д аж ахуйн нэгж нийгмийн хариуцлагын хүрээнд хандив, дэмжлэг заавал өгөх шаардлагатай бол БНХАУ, Монгол Улсад сайн дураараа өгдөг нь харагдлаа.

БНХАУ, ОХУ нь ДХБ-д Монгол Улстай харьцуулахад хожуу элсэн орсон. Түүнчлэн аж үйлдвэр өндөр хөгжсөн тул, өөрсдийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд татварын бодлогод тун болгоомжтой ханддаг болох нь харагдаж байна. Зөвхөн БНХАУ төдийгүй дэлхийн эдийн засгийн нөлөө бүхий улс орнууд ДХБ байгуулах тухай Марракешийн хэлэлцээрт нэгдэн орохдоо өөрийн импортын барааны гаалийн тарифын хувь хэмжээг өндрөөр авдаг байна. Өөрөөр хэлбэл, тухайн улс өөрийн үндэсний үйлдвэрлэл, түүний дотор хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбараа хамгаалан ийнхүү тарифын хэмжээг өндөр авсан байдаг.

ДХБ[7] -ын гадаад худалдаа, үйлчилгээний худалдаа, гарал үүслийн дүрэм, оюуны өмч, худалдааг хөнгөвчлөх зэрэг чиглэлээр гаргасан олон улсын гэрээ, хэлэлцээр, бодлогын баримт бичгийг олон улсын хэмжээнд нэгдсэн стандартаар мөрдүүлэх, уялдуулах чиглэлийг ДГБ тодорхойлдог гэж хэлж болно. Иймд тус хоёр байгууллагын үйл ажиллагаа нэг зоосны хоёр тал шиг уялдаатай явагддаг болох нь олон улсын худалдааны бодлого, чиглэлийн судлаачдын бүтээлээс тод харагдана.

*Гарал үүслийн дүрэм:* ДХБ-аас гишүүн орнуудын хоорондоо ямар нэгэн худалдааны саад тотгоргүй, худалдааг аль болох либералчлах бодлого баримтлан тус байгууллагын олон талт худалдааны системийн хэлэлцээрт үндсэн зарчмыг тусгасан байдаг. Эдгээрийн нэг нь нэн тааламжтай болон хөнгөлөлттэй гаалийн тарифыг гишүүн орнууд хоорондоо эдлэх боломж олгосон явдал юм.

Иймд ДХБ-ын гишүүд хоорондоо хөнгөлөлттэй гаалийн тариф эдлэх зорилгоор Эдийн засгийн түншлэл, эсхүл Чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулан ажиллаж байна. БНХАУ 16[8] бүс нутгийн болон хоёр талт (Өнөөдрийн байдлаар 6 улстай эдийн засгийн болон чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хэлэлцээг эхлүүлсэн), ОХУ[9] 5 бүс нутгийн болон хоёр талт Чөлөөт худалдааны хэлэлцээр болон Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулан ажиллаж байна. Мөн Иран, Энэтхэг, Египет, Сингапур Улстай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлыг ОХУ 2016 онд эхлүүлсэн байна.

Монгол Улс Япон болон АПТА-тай чөлөөт худалдааны хэлэлцээр болон эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулсан. Монгол Улсын гааль олон улсын конвенцид заасны дагуу гарал үүслийн улсыг тодорхойлох 2 шалгуур («Барааг бүрэн үйлдвэрлэсэн улс» – барааг нэг улсад үйлдвэрлэсэн бол мөрдөх, «Бараанд үлэмж хэмжээний боловсруулалт хийх» - барааг хоёр буюу

[7] Гаалийн тарифаас гадна худалдааны гажилтыг зохицуулах “Демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу авах демпингийн эсрэг арга хэмжээ; Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах саармагжуулах арга хэмжээ; Хамгаалалтын арга хэмжээний тухай Хэлэлцээрийн дагуу авах хамгаалалтын арга хэмжээ” гэсэн гурван арга хэрэгслийг ДХБ-аас тодорхойлсон байдаг.

[8] БНХАУ-тай Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан түнш орон: ASEAN, Сингапур, Пакистан, Шинэ Зеланд, Чили, Перу, Коста Рика,Исланд, Швейцарь, Малдив, Гүрж, Хонг-Конг, Макао, Тайван, БНСУ, Австрали.

[9] ОХУ-Беларус-Украин-Молдав-Тажикистан-Армен-Казахстан-Кыргыз-Узбекистан, ОХУ-Украин, Евроазийн эдийн засгийн холбоо (ОХУ-Казахстан-Беларусь-Армен-Кыргыз), Евроазийн эдийн засгийн холбоо-Вьетнам, Евроазийн эдийн засгийн холбоо-Серб.

түүнээс дээш улсад үйлдвэрлэсэн бол мөрдөх)-ийг мөрдөхөөр 2008 оны Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд тусгасан. Тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуулиар *«4.5. Нэн тааламжтай болон хөнгөлөлттэй тариф хэрэглэх улсын жагсаалтыг Засгийн газар батлах бөгөөд уг жагсаалтад хамаарах улсын гарал үүсэлтэй бараа нь гарал үүслийг нотлох баримт бичигтэй байна», «31.8.Гарал үүслийн гэрчилгээ заавал шаардагдах барааны жагсаалтыг Засгийн газар батална» гэж заасан байна.* Харин Эдийн засгийн түншлэлийн болон Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулсан улс орны хувьд уг хэлэлцээрт гарал үүслийн дүрмийг хэрхэн тодорхойлохыг тусгасан байдаг.

## ДҮГНЭЛТ

Монгол Улс далайд гарцгүй, эдийн засгийн хөгжлөөр сул дорой орны хувьд гадаад худалдаанаас үлэмж хамааралтай. Иймд гадаад худалдааны бодлого, чиглэлийг зөв тодорхойлох, ялангуяа худалдааны гол түнш болсон хөрш орнуудын гадаад худалдааны бодлого, чиглэл, тээврийн дэд бүтцийн чиг хандлага, хөгжилтэй уялдуулах, нягт хамтран ажиллах хэрэгцээ, шаардлага байсаар байна. Энэхүү судалгааны ажлаар гурван орны гадаад худалдааны өнөөгийн байдал, бодлого чиглэл, ДХБ, ДГБ-ын бодлого, чиглэлийг уялдуулах, худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаа, гаалийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийн талаар судалсан. **Судалгааны ажлыг дараах байдлаар дүгнэж байна:**

1/Тухайн улсын хүн ам, газар зүйн байршил, эдийн засгийн хөгжил зэргээс хамаарч гадаад худалдааны бараа эргэлтийн хэмжээ, төрөл харилцан адилгүй байна. Тухайлбал, Дотоодын нийт бүтээгдэхүүнээр БНХАУ 2, ОХУ 12, Монгол Улс 126 дугаарт тус тус жагссан. Дэлхийн эдийн засагт манай хөрш орнуудын гүйцэтгэх үүрэг үлэмж их бөгөөд зөвхөн Монгол Улсад төдийгүй дэлхийн бүх улс орны гадаад худалдаанд гол түнш орны нэгд тооцогддог.

Монгол Улсын экспортод 2005 онд БНХАУ 48 хувь эзэлж байсан бол 2019 онд 89 хувь эзэлжээ. Сүүлийн таван жилийн дунджаар нийт гадаад худалдааны эргэлтэд БНХАУ 63.4 хувь эзэлсэн, түүний дотор экспортод 86 хувийг эзэлж байгаа нь нэг улсаас гадаад худалдаа үлэмж ихээр хараат болохыг харуулж байна. Барааны бүтцийг харьцуулан судлахад Монгол Улсын экспортод уул уурхайн бараа эзлэн, хэрэглээний барааны дийлэнх хэсгийг импортолж байгаа нь хөрш орнуудтай харьцуулахад аж үйлдвэрийн хөгжил сул байгааг илтгэж байна.

ОХУ-тай хийсэн худалдаанд томоохон хэмжээний өөрчлөлт ороогүй. Сүүлийн таван жилийн дунджаар нийт гадаад худалдааны эргэлтэд ОХУ 12.7 хувь эзэлсэн бөгөөд түүний дотор импортод 27.7 хувийг эзэлж байна. Тус улсад экспортолсон бараа нь уул уурхайн эрдэс бүтээгдэхүүн, малын гаралтай бараа, түүхий эд эзэлжээ. Импортын бүтцээс харахад нефть бүтээгдэхүүн гол байр суурь эзэлсэн хэвээр байна.

2/ДХБ, ДГБ-аас гаргасан бодлогын баримт бичиг, хоёр орны хооронд болон бүс нутгийн хэмжээнд байгуулсан, байгуулахаар төлөвлөсөн баримт бичгийн хүрээнд хамтран ажиллах боломж өргөн хүрээнд байгааг гурван улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээр харуулж байна.

Монгол Улс, ОХУ, БНХАУ гадаад худалдааны үйл ажиллагааг зохицуулсан олон улсын түвшний долоон баримт бичигт нэгдэн орсон талаар IV хэсэгт өгүүлсэн. Эдгээр олон улсын гэрээ, хэлэлцээр, стандартад гадаад худалдааг хөнгөвчлөх, худалдааны мэдээлэл солилцох, хөнгөлөлттэй гаалийн тарифын хувь хэмжээ мөрдөх, гаалийн үйл ажиллагааг хялбарчлах, уялдуулах боломжууд багтсан.

ДХБ-аас тус байгууллагын гишүүн орнууд импортын гаалийн тарифын хөнгөлөлт эдлэх болон эдийн засгийн түншлэл байгуулах хоёр талт хэлэлцээр байгуулах боломжийг олгосон. Монгол Улс «Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр»-т 2019 онд нэгдэн орсон бөгөөд 2021 оноос хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хэлэлцээрт БНХАУ нэгдэн орсон.

Монгол Улс БНХАУ, ОХУ-тай Засгийн газар хооронд болон байгууллага хооронд худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх олон төрлийн баримт бичиг байгуулжээ. Төрийн байгууллагаас эдгээр баримт бичгийн хэрэгжилтийн талаар мэдээлэл авахыг хүсэхэд нэгдсэн байдлаар дүгнэлт хийсэн байдал харагдсангүй.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын эдийн засгийн хөгжилд гол үүрэг гүйцэтгэх гадаад худалдааны бодлого, чиглэлийг хөрш орнуудтай харьцуулан судалж, дараах санал, зөвлөмжийг гаргаж байна:

**Нэг. Худалдаа, эдийн засаг, хилийн хяналт, дэд бүтцийн чиглэлээр байгуулсан баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх:**

1/ОХУ, БНХАУ-тай хоёр орны Засгийн газар хооронд худалдаа, эдийн засаг, дэд бүтцийн чиглэлээр байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, хамтын ажиллагааны төлөвлөгөө зэрэг баримт бичгийн нэгдсэн жагсаалтыг гарган, давхардсан баримт бичгийг уялдуулах, нэгтгэх ажлыг зохион байгуулах;

2/ОХУ, БНХАУ нь Монгол Улсын мөнхийн хөрш, стратегийн гол түнш орон. Монгол Улсын гадаад худалдааны бараа эргэлтэд сүүлийн таван жилийн дунджаар ОХУ, БНХАУ хамтдаа 76.1 хувийг эзэлсэн. Эсрэгээрээ Монгол Улс хөрш орнуудын худалдаанд нэг хувь хүрэхтэй үгүйтэй хувь эзэлдэг. Энэ талаар худалдааны чиглэлийн судлаачид[10] «... чөлөөт худалдааны хэлэлцээр нь түнш улсуудын хувьд «худалдааны бус агуулга»-тай (tradeless)» болох талаар бодлогын судалгааны ажилд өгүүлсэн байдаг.

Хөрш орнуудын гадаад худалдаанд бид маш бага хувь эзэлж байгаа нь хэдийгээр олон төрлийн худалдааг хөгжүүлэх баримт бичиг байгуулсан боловч хэрэгжилтийг Монголын талаас санаачилга гаргаагүй тохиолдолд хөрш орнууд түрүүлж санаачилга гаргахгүй байгаа байдал ажиглагдсан. Хэдийгээр олон төрлийн худалдаа, эдийн засаг, хилийн хяналтын чиглэлийн баримт бичгийг даяарчлалын эрин зуунд байгуулсан боловч тунхаглалын шинжтэй, зөвхөн уулзалтаас уулзалтад, цаасан дээр хамтын ажиллагаа үлдсэн гэж хэлж болохоор байна. Иймд Монголын тал өөрсдөө идэвх, санаачилга гаргаж ажиллах нь зүйтэй.

**Хоёр. Гадаад худалдаа, хилийн хяналтын үйл ажиллагааг зохион байгуулах төрийн байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэх:**

1/Монгол Улс, ОХУ болон БНХАУ-ын хооронд худалдааны хөгжлийг дэмжихийн тулд таатай нөхцөл бүрдүүлэх хүрээнд хамтран ажиллах тухай Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, ОХУ-ын Холбооны гаалийн алба, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар хоорондын Санамж бичгийн хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, барааны нэр төрлийн сонголтыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны механизмыг бий болгох;

2/Гурван улсын эдийн засгийн коридорын хөгжлийг түргэтгэх, гадаад худалдааг тээврийн дэд бүтэцтэй уялдуулан хөгжүүлэх бодлого баримтлах;

3/ОХУ, БНХАУ-ын гадаад худалдааны бодлогод, тариф, татварын бодлогоос гадна, үйл ажиллагааг уялдуулах, хялбаршуулах, стандартчилах чиглэл давамгайлж байна. Иймд гаалийн хяналтыг харилцан хүлээн зөвшөөрөх, хилийн хяналтын байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар үйл ажиллагааны горимоо ижилтгэж, гадаад худалдаанд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулах;

4/Нэмүү өртөг шингэсэн барааны экспортыг нэмэгдүүлэхдээ «Барааг дотоод, гадаадад боловсруулах», «Гаалийн баталгаат бүс, чөлөөт бүс»-ийн гаалийн горимыг ашиглах. Барааг дотоодод болон гадаадад боловсруулах гаалийн горимын дагуу уул уурхайн бус гаралтай барааны экспортыг нэмэгдүүлэх, худалдаа эрхлэгч нарт хөрш орнуудын зах зээлд бараагаа

[10] МУИС-ийн Бизнесийн сургуулийн Маркетинг, Олон улсын худалдааны тэнхимийн I багийн 2012 онд гүйцэтгэсэн “Худалдааны гол түнш орнуудтай чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах боломж болон эрсдэл” сэдэвт бодлогын судалгаанд “Худалдааны гол түнш эдгээр улсууд Монгол Улсын гадаад худалдаанд 80 гаруй хувийг эзэлж байгаа ба манай гадаад худалдаа хоёр хөрш улсаас, ялангуяа БНХАУ-аас үлэмжхэн хамааралтай байна. Харин эсрэгээр эдгээр улсуудын гадаад худалдаанд Монгол Улс өчүүхэн бага буюу экспортод 0.02-0.3, импортод 0.0005-0.2 хувийг эзэлж байгаа юм. Эндээс харахад бидний байгуулахыг зорьж буй чөлөөт худалдааны хэлэлцээр нь түнш улсуудын хувьд “худалдааны бус агуулга”-тай (tradeless) болох нь харагдаж байна.” гэж манай улсын өнөөгийн нөхцөлийг тоон мэдээлэлд үндэслэн судалсан байна.

экспортлоход нь дэмжлэг үзүүлэх. Үүнтэй уялдуулан тодорхой нэг салбарыг сонгон, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. Тухайлбал, Монгол Улсад үйлдвэрлэхэд түүхий эд элбэг салбарын (Мал аж ахуй, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн салбар: дулааны аргаар боловсруулсан мах, хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн, ноос, ноолууран бараа, гоо сайхан, эмийн ургамал гэх мэт) үйлдвэрлэлийг үе шаттай дээрх гаалийн горимыг ашиглан хөгжүүлэх. Энэ нь нэмүү өртөг шингэсэн барааг дотооддоо үйлдвэрлэн, ажлын байр бий болгож, гадаад зах зээлд Монголын барааг худалдаалах, өөрөөр хэлбэл экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх боломжтой болно;

5/БНХАУ, Монгол Улсын гаалийн байгууллага хооронд байгуулсан «Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх» хэлэлцээрийн цар хүрээг нэмэгдүүлэн, нэн тэргүүнд итгэмжлэгдсэн экспортлогч, тээвэрлэгчийн хөтөлбөрийг нэвтрүүлэхэд стратегийн түвшний дэмжлэг авах ажлыг зохион байгуулах. Энэ нь Монголын Улсын тус улсаар дамжин өнгөрөх болон бусад тээвэр хугацаа хүлээхгүйгээр түргэн шуурхай нэвтрэх боломжтой болох юм;

6/ОХУ-ын Холбооны гаалийн албатай «Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж хөтөлбөрийг харилцан хүлээн зөвшөөрөх» хэлэлцээр байгуулах ажлыг судлах.

**<u>Гурав. Хөрш орнуудын гадаад худалдааны бодлого, чиглэлтэй өөрийн үйл ажиллагааг уялдуулах, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, худалдаанд зарцуулах цаг хугацаа, зардлыг бууруулах:</u>**

1/Гадаад худалдааны бодлогод нөлөөлөх бодлого, зохицуулалттай холбоотой «Тарифын бус хориг саад»-ыг хэрхэн хэрэгжүүлдэг туршлагыг хөрш орнуудаас суралцан нэвтрүүлэх. Тухайлбал, мал, амьтны гаралтай барааны стандарт, хориг саад хэрэгжүүлж буй бодлого;

2/БНХАУ-ын нэмүү өртөг шингэсэн барааны үйлдвэрлэлийг дэмжих «Боловсруулах горим»-ыг хөгжүүлж, Дэлхийн үнийн сүлжээнд оролцож буй туршлага, хөрөнгө оруулалтын бодлогыг экспортын дэмжлэг үзүүлэх салбартай уялдуулсан туршлагаас суралцан, үндэсний онцлогт тохирсон бодлого бий болгох;

3/Хөрш орнууд Монгол Улсын гадаад худалдаанд гол байр суурь эзлэх тул гааль, худалдааны төлөөлөгч (атташе)-ийг Монгол Улсаас БНХАУ, ОХУ-д суух ЭСЯ-нд ажиллуулах боломжийг Засгийн газраар шийдвэрлүүлэх. Ингэснээр худалдааны үйл ажиллагаатай холбоотой гарах хүндрэлтэй асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэх, гааль, хилийн хяналтыг түргэвчлэх, худалдаа, эдийн засгийн чиглэлээр олон салбарт хэрэгжүүлж буй санаачилгыг хооронд нь уялдуулах боломж бүрдэнэ.

Иймд гадаад худалдааг саадгүй нэвтрүүлэхтэй холбоотой төрийн захиргааны, түүний дотор хилийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай;

4/Хөрш орнуудын эрх бүхий байгууллага (гааль, хорио цээр)-тай хилээр нэвтрэх барааны хяналтыг ижилтгэх, түргэн шуурхай нэвтрүүлэх, цахим мэдээлэл солилцох, худалдааны нэгдсэн бичиг баримттай болох ажлыг шат дараалалтайгаар төлөвлөн хэрэгжүүлэх ажлыг дээд түвшний уулзалтын үеэр санал тавьж шийдвэрлүүлэх арга замыг эрэлхийлэх;

5/Дамжин өнгөрөх эрх чөлөөний талаар ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн 11 дүгээр зүйлд тусгасан байдаг. Практикт хөрш орнуудаар дамжин өнгөрч буй ачилт удаашрах, олон цагаар хүлээх, давхардсан хяналтаар дамжих, аюулгүй байдлын баталгаа хангагдаагүй зэрэг асуудал байсаар байна.

Иймд хэлэлцээрийн дагуу ижил боломж эдлэх асуудлын Зам, тээвэр хөгжлийн яам, Гадаад харилцааны яамнаас (2020 оны 6 дугаар сарын 25-ны байдлаар гадаад

худалдааны асуудлыг хариуцаж байгаа) хөрш орнуудын ижил түвшний байгууллагад хүсэлт тавьж, харилцан санал солилцож, олон улсын хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх;

6/Монгол Улс өнгөрсөн дөрвөн жилд үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зорилгоор тодорхой нэр төрлийн бараатай холбоотой тарифын бус зохицуулалт хийсэн байдаг. Энэ нь ДХБ-ын өмнө Монгол Улсын хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлээгүй гэсэн үндэслэлээр ОХУ-ын талаас ДХБ-д энэ асуудлыг тавьж, тус байгууллагын гишүүн зарим орон Монголын шийдвэрийг буруутгаж, өнөөг хүртэл гомдол үргэлжилсээр байна. Эндээс бид олон сургамж авч байна.

Худалдаа, үйлдвэрлэлд тавих төрийн хяналтын хувьд БНХАУ энгийн, хялбар, стандарт үйл ажиллагааны бодлого хэрэгжүүлдэг. Иймд БНХАУ-ын үйлдвэрлэл, худалдааг дэмжих бодлогоос суралцахыг зөвлөж байна;

7/Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах ажлыг эрчимжүүлэх, Евразийн гаалийн нутаг дэвсгэрт хөнгөлөлттэй гаалийн тариф эдлэх барааны үйлдвэрлэлийг хөгжүүлэх ажлыг хэлэлцээрт нэгдэн орох хэлэлцээ хийх явцад зэрэгцүүлэн эхлүүлэх. Мөн энэхүү хэлэлцээрт тээврийн салбарын хамтын ажиллагааг оруулах;

8/Төрийн олон төрлийн хяналт, төрөөс худалдаа, үйлдвэрлэлийн салбарыг дэмжсэн бодлого, үйл ажиллагаа нь оновчтой бус байгаа талаар худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчид гомдол, хүсэлтээ төрийн байгууллагад уламжилдаг. Иймд худалдаанд тавих төрийн хяналтын үйл ажиллагааг хялбаршуулах, уялдуулах, стандартчилах ажлыг зохион байгуулах нь зүйтэй;

9/Монгол Улс хөрш орнуудын зах зээлд дагнасан барааны үйлдвэрлэлээр өрсөлдөх боломжтой. Мөн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх, түүний дотор аялал жуулчлал, мэдээллийн технологи, боловсролын салбарыг тэргүүлэх чиглэлээ болговол Монгол Улсад нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах боломж бүрдэж, худалдаа, эдийн засгийн хөгжилд дэмжлэг болно;

10/Монгол Улс хөрш орнуудтай олон чиглэлээр, түүний дотор худалдаа, эдийн засаг, тээврийн салбарын үйл ажиллагаатай холбоотой хамтран ажиллах олон төрлийн баримт бичиг байгуулжээ. Гэхдээ яг ямар үр дүнд хүрсэн нь тодорхойгүй, зөвхөн жил бүр, эсхүл түүнээс ч ойр хугацаанд уулзалт зохион байгуулж ярилцдаг байдал ихэнх байгуулсан баримт бичгийн хэрэгжилттэй танилцахад харагдлаа. Товчхондоо төр нэгдсэн бодлогоор гадаад худалдаанд оролцогч талуудын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай гэж дүгнэж байна;

11/ДХБ-аас худалдааг чөлөөтэй болгох чиглэлээр олон ажлыг хэрэгжүүлсэн боловч худалдаанд тавих төрийн хяналтын байгууллагын хүнд суртал, давхардсан хяналт худалдааны эргэлтэд саад учруулж байгаа талаар ярьсаар ирсэн. Энэ ажлыг шинэ шатанд гаргах зорилгоор хэрэгжүүлсэн ажил нь биеллээ олж ДХБ-ын «Сайд нарын IX бага хурал» (Индонези Улсын Бали хот 2013 он)-аар «Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр»-ийг баталж, тус байгууллагын гишүүн орнуудын 2/3 нь хэлэлцээрт нэгдэн орсноор 2017 оноос хэрэгжиж эхлээд байна. Хөрш орнууд уг хэлэлцээрийг 100 хувь хэрэгжүүлэх үүрэг амлалт авсан.

Монгол Улс худалдааг хөнгөвчлөх 36 арга хэмжээнээс 11 арга хэмжээг шууд хэрэгжүүлж, үлдсэн 25 арга хэмжээтэй холбоотой техникийн туслалцаа авах болон бусад арга хэмжээг хэрэгжүүлсний дараа бүрэн хэрэгжүүлэх үүрэг амлалтыг ДХБ-ын өмнө авсан. Иймд арга хэмжээ тус бүрээр хөрш орнуудтай хамтран ажиллах ажлыг стратегийн түншлэлийн хүрээнд байгуулсан баримт бичигт оруулах нь зүйтэй.

---oOo---

**НОМ ЗҮЙ:**

**Нэг. Монгол хэлээр хэвлэгдсэн бүтээлүүд**

- Гадаад худалдааны статистик мэдээлэл. УБ.,2005-2019
- Үйл ажиллагааны тайлан. ГЕГ УБ.,2011-2019
- ОХУ-ын Холбооны гаалийн албаны 2030 он хүртэлх урт хугацааны хөгжлийн стратеги. Москва хот. М., 2020
- ГХЯ. Гадаад харилцааны яам. Хөрш орнууд: http://www.mfa.gov.mn/?p=28018-ээс Гаргасан. УБ.,2015
- ГХЯ. Гадаад харилцааны яамны цахим хуудас. http://www.mfa.gov.mn/?p=28020-аас гаргасан. УБ.,2015
- Баярсайхан Д. Монгол Улсын гаалийн холбогдолтой олон улсын гэрээний тойм. УБ.,2011
- ДГБ. Дотоодод болон гадаадад боловсруулах горимын тухай ДГБ-ын гарын авлага. Брюссель. 2017
- ДГБ. ДГБ-ын 2018/2019 оны үйл ажиллагааны тайлан. Брюссель: ДГБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын хэвлэлийн газар. 2019
- ДГБ. Олон улсын гэрээ, хэлэлцээр. ДГБ-ын цахим хуудас: http://www.wcoomd.org/en/about-us/legal-instruments/conventions.aspx-ээс Гаргасан. December 01, 2019
- ДХБ. (2013). Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр. Бали.
- ДХБ. Олон улсын гэрээ, хэлэлцээр. ДХБ-ын цахим хуудас: https://www.wto.org/english/tratop_e/tradfa_e/tradfa_e.htm-ээс Гаргасан. November 11, 2019
- УИХ. Гаалийн тариф, гаалийн татварын хууль. Төрийн мэдээлэл. УБ.,2018
- УИХ. Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай. Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ., 2016
- Оюунбилэг Ц., Баярмаа Б. «Толь» статистик ба мэдээлэл солилцоо. ГЕГ, (хууд. 97). УБ.,2012
- ГХЯ. Монгол Улс, ОХУ-ын харилцаа. http://www.mfa.gov.mn/?page_id=19050-ээс Гаргасан. УБ.,2016

**Хоёр. Гадаад хэлээр хэвлэгдсэн бүтээлүүд**

- Cantens, T.. Mirror Analysis and Revenue Fraud. WCO Reserach Paper No35. Brussels: WCO Research unit. (2015)
- EUROSTAT. International trade statistics - background. (2017).
- IMF. (2019). World Economic Outlook database.
- ITC. International Trade Centre. Market Info & Tools: http://www.intracen.org/itc/market-info-tools/trade-statistics/. June 10, 2020.
- John S. Wilson; Catherine L. Mann and Tsunehiro Otsuki.. Assessing the Benefits of Trade Facilitation: A Global Perspective. Washington DC: World Bank. (july 2004)
- Software, T. W. Trade statistics by country. The World Integrated Trade Solution Software: https://wits.worldbank.org/countrystats.aspx?lang=en. January 31, 2020.
- WB. Doing Business 2020. Washington: WB. (2020).
- WCO. The SAFE Framework of Standard. WCO. (2005).
- WCO. WCO Annual Report 2018/2019. Brussels. (2019).
- WTO. International Trade Centre. Trade statistic database: http://www.trademap.org/tradestat/Product_SelCountry_TS.aspx?nvpm=1|496||||TOTAL|||2|1|1|1|2|1|1|1|. January 31, 2020.

**ХАВСРАЛТ:**

***Хавсралт 1. Импортын бүтэц, Уялдуулсан системийн хэсэг, улсаар (2016-2019 он)***




Дээрх зураг импортын дүнд голлох хувийг эзлэх хэсгийн дүнг импортын гол түнш орон болох БНХАУ, ОХУ, Япон Улсаар харьцуулан үзүүлсэн.

***Хавсралт 2. Монгол Улсын гадаад худалдаа, гаалийн үйл ажиллагаанд мөрдөж буй олон улсын гэрээ, хэлэлцээр***

| Д/д | Гэрээний нэр | Хүчин төгөлдөр болсон өдөр (Хэлэлцэн тохирогч Талын тоо) | Монгол Улсын хувьд хүчин төгөлдөр болсон өдөр |
|---|---|---|---|
| **Дэлхийн гаалийн байгууллагаас хэрэгжүүлж буй баримт бичгүүд** | | | |
| 1 | Гаалийн хамтын ажиллагааны зөвлөл байгуулах тухай Конвенц (Дэлхийн гаалийн байгууллага байгуулах тухай Конвенц, 1950-12-15. Бельги Улсын Брюссель хот) | 1952-11-04 (2009: 177) (2015: 180) | 1991-09-17 |
| 2 | Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай олон улсын Конвенц (БТКУС-ийн Конвенц, 1983-06-14. Бельги Улсын Брюссель хот) | 1988-01-01 (2018: 157) | 1993-01-01 |
| 3 | Гаалийн горимыг хялбарчилах, уялдуулах тухай олон улсын Конвенц (Киотогийн Конвенц, 1973-05-18. Япон Улсын Киото хот) | 1974-09-25 (2019: 120) | 2006 |
| 4 | Түр хугацаагаар оруулах тухай Конвенц (Стамбулын Конвенц, 1990-06-26. Турк Улсын Стамбул) | 1993-11-27 (2019: 71) | 2003-09-05 |
| **Дэлхийн худалдааны байгууллагын баримт бичгүүд** | | | |
| 5 | Дэлхийн худалдааны байгууллага байгуулах тухай Хэлэлцээр (Дэлхийн Худалдааны БайгууллагынХэлэлцээр, Марракешийн Хэлэлцээр, 1994-04-15. Марокко Улсын Марракеш хот) | 1995-01-01 (2019: 164) | 1997-01-29 |
| 6 | 1994 оны ТХЕХ-ийн VI зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (Демпингийн эсрэг татварын тухай Хэлэлцээр, 1994-04-15. Марокко Улсын Марракеш хот) | 1995-01-01 (2019: 164) | 1997-01-29 |
| 7 | 1994 оны ТХЕХ-ийн VII зүйлийг хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр (Дэлхийн Худалдааны БайгууллагынҮнэлгээний Хэлэлцээр, 1994-04-15. Марокко Улсын Марракеш хот) | 1995-01-01 (2019: 164) | 1997-01-29 |
| 8 | Ачилтын өмнөх шалгалтын тухай Хэлэлцээр (1994-04-15. Марокко Улсын Марракеш хот) | 1995-01-01 (2019: 164) | 1997-01-29 |
| 9 | Гарал үүслийн дүрмийн тухай Хэлэлцээр (1994-04-15. Марокко Улсын Марракеш хот) | 1995-01-01 (2019: 164) | 1997-01-29 |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | Татаас болон нөхөн төлөөсийн/ саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээр (1994-04-15. Марокко Улсын Марракеш хот) | 1995-01-01 (2019: 164) | 1997-01-29 |
| 11 | Худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр (Бали, Сайд нарын Бага хурал, 9 дүгээр хуралдаан 2013 оны 12 дугаар сарын 3-б) | 2017-02-22 (2019: 146) | 2016-11-24 |
| **Нэгдсэн үндэстний байгууллагын байгаль орчныг хамгаалах байгууллагаас хяналт тавин хэрэгжүүлж буй баримт бичгүүд** | | | |
| 12 | Аж үйлдвэрийн омчийг хамгаалах тухай Парисын Конвенц (Парисын Конвенц) 1883-03-20. Франц Улсын Парис хот | 1884-07-07 | 1985-04-21 |
| 13 | Олон улсын хэмжээнд бараа худалдах, худалдан авах гэрээний тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенц 1980-4-11. Австри Улсын Вена хот | 1988-01-01 | 1999-01-01 |
| 14 | Барааны хилийн хяналтын үйл ажиллагааг уялдуулах тухай олон улсын конвенц (Женевийн Конвенц) 1982-10-21. Швейцарь Улсын Женев хот | 1987-09-12 | (УИХ: 2007-05-04) |
| 15 | Хуурай боомтын тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр | 2016-04-23 | 2016-02-05 |
| 16 | ТИР карнеӣ ашиглан олон улсын хэмжээнд бараа тээвэрлэх тухай Конвенц (ТИР Конвенц) 1975-11-14. Швейцарь Улсын Женев хот | 1978 | 2003-04-01 |

## Б. Хөрш орнуудтай байгуулсан олон улсын хоёр талт гэрээ

(Гадаад худалдаа, хилийн боомттой холбоотой)

| Д/д | Утга | Гэрээ байгуулсан огноо |
|---|---|---|
| **I. Гаалийн хүрээнд хамтран ажиллах, харилцан туслах тухай асуудлаар** | | |
| 1 | Гаалийн асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр | 1993-01-20 |
| 2 | Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр | 1993-09-07 |
| **II. Хил, хилийн боомтын асуудлаар** | | |
| 1 | Хилийн боомт болон Монгол-Оросын улсын хилийг хялбарчилсан журмаар нэвтрэх тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр | 1994-08-10 |
| 2 | Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр | 2004-07-05 |
| 3 | Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, ОХУ хоорондын гэрээ | 2006-12-08 |
| 4 | Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ | 2010-06-01 |
| **III. Бусад асуудлаар** | | |
| 1 | БНМАУ, БНХАУ-ын хоорондын консулын Конвенц | 1986-08-09 |
| 2 | Монгол Улс, ОХУ-ын нутгаар дамжин тээвэр хийж, далайд гарах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр | 1992-10-19 |

---oOo---



CitiZone

«СИТИ» Их сургуулийн алсын хараа болон 2020-2021 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан томоохон ажлуудын нэг бол СитиЗон төсөл юм. Уг төслийн бэлтгэл ажил дуусаж, эхлэхэд бэлэн болж байна.

**СитиЗон төслийн хүрээнд:**

- Багш, оюутнуудын дунд хувь хүний хөгжлийн сургалт, лекцүүд;
- Багш, оюутнуудын өдөрлөг, чөлөөт уулзалт, бүтээлийн үзэсгэлэн, урлаг, соёл, спортын арга хэмжээнүүд;
- Оюутан, төгсөгчид ажилд ороход, өөрийн бизнесээ эхлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах, ажил горилогчдод тавигддаг, шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх, хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөхөд нь туслах;
- Багш, оюутнуудын санаачлан боловсруулсан инновац, бизнесийн төслүүдийг шалгаруулж, жил бүр 1-3 төсөлд тус бүр 30 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт олгон, хамтран ажиллах зэрэг арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулна.
- Оюутнууд академик мэдлэгээс гадна практик дадлага, туршлагатай, хувь хүний хөгжлөөр өрсөлдөхүйц, бие даан ажиллаж, амьдрах чадвартай төгсөх ёстой.

***Мэдлэг бол Хүч, Эрх чөлөө - Scientia est Potentia, Libertas***




https://www.citi.edu.mn/citizone1/

*Н.Отгонсайхан*
*Худалдаа, үйлдвэрлэлийн их сургууль, Доктор (Ph.D)*

# МОНГОЛ, ХЯТАДЫН НҮҮРСНИЙ ХУДАЛДААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## Хураангуй

Монгол Улсын гадаад худалдаанд нүүрсний экспорт чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд дэлхийн нүүрсний зах зээлийн төлөв байдал, Монгол Улсын нүүрсний экспортод БНХАУ-ын эзлэх байр суурь, БНХАУ-ын нүүрсний импортын зах зах зээлд Монгол Улсын эзлэх байр суурийн талаар гаалийн статистик болон олон улсын худалдааны төвийн статистик мэдээнд тулгуурлан судалсан болно.

## Түлхүүр үг


Нүүрсний экспорт, нүүрсний импорт, нүүрсний үнэ, нүүрсний зах зээл.

## I. ДЭЛХИЙН НҮҮРСНИЙ ЗАХ ЗЭЭЛ

### 1.1. Импорт

Дэлхийн нүүрсний нийт импорт 2018 онд 1225.0 сая тоннд хүрсэн ба 2009 онтой харьцуулахад 257.3 сая тонноор өсчээ. Дэлхийн нийт нүүрсний импортын 80 гаруй хувийг Энэтхэг, Япон, БНХАУ, БНСУ, Тайвань, Герман, Турк, Малайз, Тайланд, Бразил, ОХУ зэрэг ТОП 11 орон эзэлж байна (Зураг 1).

***Зураг 1. Дэлхийн нүүрсний импорт, түүнд ТОП 11 орны эзлэх хувь, 2010-2018 он***





*Эх сурвалж: Олон улсын худалдааны төв*

2018 онд дэлхийн нүүрсний нийт импортод Энэтхэг 18.6% (227.4 сая тонн), Япон 15.5% (189.4 сая тонн), БНХАУ 15.2% (186.4 сая тонн), БНСУ 12.1% (148.7 сая тонн), Тайвань 5.6% (69.2 сая тонн) эзэлж, эхний 5 байрт байгаа бол ОХУ 1.8% (22.1 сая тонн) эзэлж 11 дүгээрт оржээ. (Зураг 2)

Энэтхэг улс нүүрсний хэрэглээнийхээ 85 хувийг импортоор бүрдүүлдэг бөгөөд 2025 он гэхэд коксжих нүүрсний хамгийн том импортлогч БНХАУ-ыг гүйцнэ хэмээн «Fitch solutions macro research» үзэж байна. Энэтхэгийн нүүрсний импортын зах зээлд Индонези (103.3 сая тонн, хилийн дундаж үнэ 67$), Австрали (50 сая тонн, хилийн дундаж үнэ 186$), Өмнөд Африк (34 сая тонн, хилийн дундаж үнэ 90$) тэргүүлж байна. Эндээс харахад, Монгол нүүрс Энэтхэгийн зах зээлд Австралийн өндөр үнэтэй нүүрстэй өрсөлдөх боломжтой байна.


***Зураг 2. Нүүрс импортлогч ТОП 11 орны дэлхийн нүүрсний импортод эзлэх хувийн жин, 2010-2018 он***




*Эх сурвалж: Олон улсын худалдааны төв*

Дэлхийн зах зээл дээр нүүрс импортлогч ТОП 10 орны 1 тонн нүүрсний импортын үнийг Зураг 3-т харьцуулан харуулав.

***Зураг 3. Нүүрс импортлогч ТОП 10 орны 1 тонн нүүрсний импортын хилийн дундаж үнэ, ам.доллар, 2018 он***





*Эх сурвалж: Олон улсын худалдааны төв*

## 1.2. Экспорт

Дэлхийн нийт нүүрсний (HS 2701. Чулуун нүүрс; чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлш) экспортын 90 гаруй хувийг Австрали, Индонези, ОХУ, АНУ, Колумб, Өмнөд Африк, Монгол, Канад, Казахстан, Мозамбик зэрэг ТОП 10 орон эзэлж байна (Зураг 4).

***Зураг 4. ТОП 10 орны дэлхийн экспортод эзлэх хувийн жин, %***





*Эх сурвалж: Олон улсын худалдааны төв*

2018 онд дэлхийн нүүрсний нийт экспортод Австрали 28.6% (382.2 сая тонн), Индонези 25.7% (343.1 сая тонн), ОХУ 14.9% (199.5 сая тонн), АНУ 7.9% (105.4 сая тонн), Колумб 6.3% (83.8 сая тонн) эзэлж эхний 5 байрт байгаа бол Монгол Улс 1.1% (35.8 сая тонн) эзэлж 7 дугаар байрт оржээ (Зураг 5).

Австралийн нүүрсний экспортын зах зээлд Япон (116.8 сая тонн, хилийн экспортын дундаж үнэ 119$) БНХАУ (87.7 сая тонн, хилийн экспортын дундаж үнэ 114$), Энэтхэг (48.7 сая тонн, хилийн экспортын дундаж үнэ 153$), БНСУ (47.8 сая тонн, хилийн экспортын дундаж үнэ 112$), Тайвань (32.2 сая тонн, хилийн экспортын дундаж үнэ 114$) тэргүүлж байна. Эндээс харахад, Монгол Улс Японтой байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг ашиглан энэ зах зээлд нэвтрэх, мөн Энэтхэгийн зах зээлд үнээр өрсөлдөх боломж өндөр байгаа бөгөөд транзит тээврийн асуудлыг шийдэх шаардлагатай юм. Ингэснээр нүүрсний экспортын зөвхөн нэг орноос хараат байдлыг бууруулах нэг гол гарц байж болох юм.

***Зураг 5. Нүүрс экспортлогч ТОП 10 орны дэлхийн нүүрсний экспортод эзлэх хувийн жин, 2010-2018 он***





*Эх сурвалж: Олон улсын худалдааны төв*

Дэлхийн зах зээлд Австрали нүүрсний экспортоор тэргүүлдэг бөгөөд 2011 онд их үер болж, уурхайнууд нь хаагдсанаар экспорт 2010 онтой харьцуулахад 3.3 сая тонноор буурч 24.2 сая тонн болсон. 2012 оны сүүлээр уурхайнууд хэвийн байдалдаа орж 25.2 сая тонн, 2013 онд 26.7 сая тонн нүүрс экспортолсон. 2014 оноос нийлүүлэлтээ эрс нэмэгдүүлж 29.3 сая тонн, 2015, 2016 онд 32 орчим сая тонн нүүрс экспортолжээ. Мөн Австралийн нүүрсний экспортын бууралттай зэрэгцээд Индонези, ОХУ, АНУ зэрэг орнууд нүүрсний нийлүүлэлтээ нэмэгдүүлсэн.

## II. МОНГОЛ УЛСЫН НҮҮРСНИЙ ЭКСПОРТ

Монгол Улс 2005 онд 7.5 сая тонн нүүрс олборлож, 2.2 сая тонн нүүрс экспортолж байсан бол 5 жилийн хугацаанд огцом өсч 2010 онд нүүрсний олборлолт 3 дахин, экспорт бараг 8 дахин өссөн. Харин 2018 онд 51.4 сая тонн (үүнээс 34.9 сая тонныг хувийн хэвшлийн уурхай) нүүрс олборлож, үүнээс 35.8 сая тонныг нь экспортолсон нь 2005 онтой харьцуулахад олборлолт бараг 7 дахин, экспорт 16 дахин (Зураг 6) нэмэгджээ.

***Зураг 6. Монгол Улсын үйлдвэрлэсэн, экспортолсон нүүрс, сая тонн, 2005-2018***





*Эх сурвалж: Монгол Улсын статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Гаалийн ерөнхий газрын статистик*

2019 онд нийт 36.5 сая тонн чулуун нүүрсийг 3.07 тэрбум ам.долларoор экспортолсон нь өнгөрсөн онтой харьцуулбал үнийн дүнгээр 288.1 сая ам.долларoор, тоо хэмжээний хувьд 708.6 мянган тонноор тус тус нэмэгдсэн. Засгийн газар 2019 онд 42 сая тонн нүүрс экспортлохоор төсөөлж байсантай харьцуулахад нүүрсний экспортын бодит дүн бага юм. Хэдий тийм боловч өмнөх жилүүдтэй харьцуулахад урьд өмнө нь байгаагүй өндөр дүнд тооцогдож байна. Оны сүүлийн хоёр сард БНХАУ-ын талын татан авалт буурсантай холбоотой нүүрсний экспорт огцом багассан талаар боомтууд мэдээлсэн. Гэхдээ голлох экспортлогч компаниуд өмнөх оны үзүүлэлтээ давуулсан байна. Тухайлбал, Ховдын Булганы боомтоор нүүрсээ гаргадаг «Mongolia Energy Corporation»-ийн экспорт 70 хувиар өсөж, 1.2 сая тонн болжээ. Боомтоор нь харвал Тавантолгойн бүлэг ордын нүүрсийг гаргаж байгаа Гашуунсухайт боомтоор 20.6 сая тонн нүүрс гаргасан. Голчлон Нарийнсухайтын бүлэг ордоос нүүрс олборлож байгаа компаниуд экспорт хийдэг Шивээхүрэн боомтын экспорт 12.4 сая тонн хүрчээ[1].


Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын статистик мэдээлэлд нүүрсийг «БТКУС-ийн 2701. Чулуун нүүрс; чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлш» ангиллаар бүртгэсэн тул коксжих, эрчим хүчний нүүрсийг ялгах боломжгүй байна. Харин Ашигт малтмал газрын тосны газраас нүүрс олборлогч аж ахуйн нэгжээс тус газарт ирүүлсэн мэдээнд үндэслэн 2015 оноос нүүрсийг Чулуун баяжуулсан коксжих, Чулуун түүхий коксжих, Чулуун сул коксжих, Чулуун эрчим хүчний гэж ялган статистик гаргажээ. Уг статистикээс харахад, Монгол улс гол төлөв чулуун түүхий коксжих нүүрс экспортолж байна. Тухайлбал, 2019 онд 16.8 сая тонн чулуун түүхий коксжих нүүрс экспортолсон нь нийт нүүрсний 45.6 хувь болжээ (Зураг 7-оос дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү).

[1] http://bloombergtv.mn/ 2020.01.13

***Зураг 7. Монгол улсын экспортолсон нүүрсний төрөл, хувиар,, 2015-2019 он***




***Зураг 8. Монгол улсын экспортолсон нүүрс, төрлөөр, сая тонн, 2015-2019 он***





*Эх сурвалж: Ашигт малтмал газрын тосны газрын статистик мэдээ, 2015-2019*

Монгол Улс 2005 онд БНХАУ, ОХУ, Япон, БНСУ, АНУ болон бусад оронд 2.2 сая тонн нүүрс экспортолсноос 99.99 хувь БНХАУ-д ногдож байсан бол 2010 онд дээрх орнуудаас гадна Их британи, Энэтхэг улсуудад экспорт хийсэн ч БНХАУ-д ногдох экспортын хувь 0.09 хувиар л буурсан. 2005-2018 онд нүүрсний нийт экспортын 99.1-99.99 хувь нь зөвхөн БНХАУ-д ноогдож, нүүрсний экспорт нэг орноос хэт их хамааралтай болсон билээ. 2019 онд нүүрсний нийт экспортын 98 хувийг БНХАУ-д, үлдсэн багахан хэсгийг Их Британи болон Сингапурт гаргажээ.

2016 оноос Монгол Улсаас БНХАУ-д экспортлох нүүрсний хэмжээ эрс нэмэгдэж 25.3 сая тонн (949.2 сая доллар, 1 тонн нүүрсний хилийн дундаж үнэ 37.5$) болсон нь өмнөх онтой харьцуулахад 55% буюу 11.3 сая тонноор нэмэгдсэн бол 2019 онд 3014.3 сая долларын 35.8 сая тонн нүүрсийг тонн тутмыг дундажаар 84.2 доллароор экспортолсон нь хамгийн оргил үе байлаа. Дэлгэрэнгүй мэдээллийг дараах зургаас дэлгэрүүлэн үзнэ үү.

***Зураг 9. Монгол улсаас БНХАУ-д экспортолсон нүүрс***




*Эх сурвалж. МУ-ын ГЕГ-ын статистик мэдээлэл*

Австралид 2011 онд их үер болж, уурхайнууд нь хаагдсанаар БНХАУ-ын зах зээлд борлуулах Монголын нүүрсний хэмжээ өсөх үндсэн нөхцөл болжээ. Харин 2012 оны сүүлээр Австралийн уурхайнууд хэвийн байдалдаа орж, нүүрсний нийлүүлэлтээ эрс нэмэгдүүлсэн. Үүний зэрэгцээ бусад топ экспортлогчид БНХАУ-ын зах зээлд нүүрсний нийлүүлэлтээ нэмэгдүүлсээр 2013 онд БНХАУ-ын зах зээлд нүүрс илүүдэлтэй болж, эрэлт, нийлүүлэлтийн хуулиар нүүрсний үнэ буурсан гэж үзэж болно.


Монголын нүүрсний экспорт БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлээс ихээхэн хамааралтай байгаа тул дараагийн хэсэгт энэ зах зээлийн импортын төлөв байдлыг товч авч үзэв.

## III. БНХАУ-ын нүүрсний импортын төлөв байдал

БНХАУ нь 2018 онд 19.6 тэрбум долларын 186.4 сая тонн нүүрс импортоор авсан бөгөөд дэлхийн нүүрсний импортын зах зээлийн 15.2 хувийг (Зураг 2) эзэлж, Энэтхэг, Японы дараа III байрт орсон. Тус зах зээлд нүүрс экспортолж буй ТОП 10 орныг авч үзэхэд, дэлхийн нүүрсний зах зээлийн гол тоглогч Австрали (43.1%) I байрт, Индонези (20.2%) II байр, Монгол (19.2%) III байрт жагсаж байна. 2010-2012 онд Индонези БНХАУ-ын зах зээлд гол экспортлогч буюу нүүрсний нийт импортын зах зээлийн 30-35 хувийг эзэлж байсан бол 2013 оноос Австрали нүүрсний нийлүүлэлтийг эрс нэмэгдүүлснээр 20 хувь болтол буурчээ.

Монголын нүүрсний экспорт 2016 оноос эрс нэмэгдэж 25.3 сая тонн байсан бол 2018 онд 10 сая тонноор нэмэгдэж 35.4 сая тонн болсноор БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлийн 19 хувийг эзэлсэн. Харин 2019 онд Монголын нийлүүлэлт нэмэгдсэн ч БНХАУ-ын зах зээлд эзлэх хувийн жин 1 орчим хувиар буурчээ. Түүнчлэн ОХУ-ын нүүрсний экспорт тогтвортой нэмэгдэж 14-15 хувь болсноор Австрали, Индонезийн дараа манай гол өрсөлдөгч болжээ. Зураг 10-аас дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.

***Зураг 10. БНХАУ-ын зах зээлд нүүрс экспортлогч ТОП 5 орон, хувийн жингээр, %***




*Эх сурвалж. Олон улсын худалдааны төв*

ОХУ-ын нүүрсний салбар асар хурдацтай хөгжиж, дэд бүтэц, баяжуулах үйлдвэрүүд нь жилээс жилд хүчирхэгжиж байгаа бөгөөд 2018 онд 199.5 сая тонн нүүрс экспортолсон нь 2014 онтой харьцуулахад 46.4 сая тонн, өмнөх онтой харьцуулахад 18 сая тонноор нэмэгдэж дэлхийн нүүрсний зах зээлийн 15 орчим хувийг эзэлсэн бол цаашид 25 хувьд хүргэх зорилттой стратегийн баримт бичиг баталсан.

БНХАУ-ын зах зээлд нүүрс экспортолж буй ТОП 5 орны 2019 оны төлөв байдлыг авч үзэхэд, дэлхийн нүүрсний экспортын зах зээлд Австрали 1 дүгээр байр, Индонези 2, ОХУ 3, Канад 5, Монгол 8 дугаар байрыг тус тус эзэлж байгаа ба Монголоос бусад 4 орны БНХАУ-д нийлүүлж буй нүүрс нь нийт нүүрсний экспортын 7-17 хувийг (Үүнд Австрали -17%, Индонези – 14%, ОХУ-7%, Канад 15%) л эзэлж байгаа юм. Гэтэл Монголын нүүрсний нийт экспортын 98 хувь нь зөвхөн БНХАУ-д ногдож байгаа гэдгийг бид мэдэх билээ.

***Зураг 11. БНХАУ-ын зах зээлд нүүрс экспортлогч орны төлөв байдал, 2019 он***







*Эх сурвалж. Олон улсын худалдааны төв*

2018 онд БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлд 1 тонн нүүрсний[2] хилийн дундаж үнэ 105 ам.доллар байсан бол 2019 онд 96 ам.доллар болж буурчээ. Мөн хугацаанд Канад 179-өөс 177 ам.доллар, АНУ 163-аас 141 ам.долларын хилийн дундаж үнээр (зураг 12-оос дэлгэрэнгүй танилцана уу) нүүрс нийлүүлсэн нь хамгийн өндөр үнэ аж.

***Зураг 12. БНХАУ-ын нүүрсний импортын хэмжээ, дундаж үнэ ТОП 10 орноор, 2018-2019 он***




*Эх сурвалж. Олон улсын худалдааны төв*

Дээрх зургаас үзэхэд, Монгол Улс 2018 онд 79 ам.доллар буюу БНХАУ-ын импортын зах зээлийн дундаж үнээс 26 ам.долларын доогуур үнээр нүүрсээ нийлүүлж байсан бол 2019 онд 85 ам.доллар болж өссөн. Харин Австрали импортын тарифын хөнгөлөлт эдэлж байгаа хэрнээ Монгол Улсаас 36-50 ам.долларын илүү үнээр БНХАУ-ын зах зээлд нүүрсээ борлуулж байна.

БНХАУ-д нүүрс экспортолж буй ТОП 10 орноос зайны хувьд хамгийн ойр нь Монгол Улс бөгөөд манай гол өрсөлдөгч Австрали 8621 км, Индонези 3959 км-ийн зайнаас нүүрсээ тээвэрлэж байгаа юм.

***Зураг 13. Нүүрс экспортлогч орнууд болон БНХАУ хоорондын зай, ТОП 10 орноор***




*Эх сурвалж. Олон улсын худалдааны төв*

[2] БТКУС-ийн 2701. Чулуун нүүрс; чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлш

Түүнчлэн БНХАУ нь тус улсын нүүрсний импортын зах зээлд манай гол өрсөлдөгч Австралитай 2015 онд, Шинэ Зеландтай 2008 онд, Вьетнамтай 2014 онд, Зүүн өмнөд азийн орнуудын холбоо (ASEAN)-тай 2005 онд тус тус Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулснаар эдгээр орнууд нүүрсээ БНХАУ-ын зах зээлд «0» тарифтай экспортолж байгаа бол бусад орнуудад ногдуулах дундаж нэн тааламжтай тариф 4.5 хувь байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын хувьд бүх орнууд ижил 13 хувийн татвар төлнө. Мөн Монгол Улс Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр (АНДХХ)-т 2020 онд нэгдэж, 2021 оны 1 дүгээр сарын 1-ээс хэлэлцээрийн заалтыг мөрдөх учраас нүүрсний нэр төрлөөр импортын гаалийн тарифыг судалж, дараах зурагт оруулав.

***Зураг 14. БНХАУ-ын импортын гаалийн тарифын дундаж, ТОП 10 орноор, 2020 он***

| Экспортлогч орон | Австрали | Индонези | Монгол | ОХУ | Канад | АНУ | Колумб | Казакстан | Вьетнам | Шинэ Зеланд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| HS 2701 | 0% FTA 2015/12/20 | 0% ASEAN 2005/7/1 | 4.5% | 4.5% | 4.5% | 4.5% | 4.5% | 4.5% | 0% ASEAN 2005/7/1 | 0% FTA 2008/10/1 |

| БТКУС/ HS | Барааны нэр | Ердийн тариф | MFN | НӨАТ /VAT | АНДХХ/ АРТА | АРТА (ГЭвэтгэг) | ЭЗТХ/EPA (Japan) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 270111 | Антрацит | 20% | 3% | 13% | | 50% (MFN 2.5%) | 0 |
| 27011210 | Битумжсан коксжих | 20% | 3% | 13% | | 50% (MFN 2.5%) | 0 |
| 27011290 | Бусад битумжсан | 20% | 6% | 13% | | 50% (MFN 2.5%) | 0 |
| 270119 | Бусад | 20% | 5% | 13% | 30% | 50% (MFN 2.5%) | 0 |
| 270120 | Чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлш | 50% | 5% | 13% | | 45% (MFN 2.5%) | 0 |

*Эх сурвалж. Олон улсын худалдааны төв*

***Тайлбар:*** *MFN–нэн тааламжтай тариф, FTA – Чөлөөт худалдааны хэлэлцээр, ASEAN-Зүүн өмнөд азийн орнуудын холбоо, БТКУС/HS- Барааг тодорхойлох кодлох уялдуулсан систем, АНДХХ/ АРТА- Ази номхон далайн худалдааны хэлэлцээр, ЭЗТХ/EPA-Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, НӨАТ/VAT-Нэмэгдсэн өртгийн албан татвар.*

Дээрх нөхцөл байдлаас харахад Австрали, Индонези зэрэг манай гол өрсөлдөгчид нүүрсний үнийг бууруулах, эсхүл илүү ашиг олох боломжтой нь харагдаж байна. Монгол Улсаас БНХАУ-д экспортолж буй битумжсан коксжих нүүрс АНДХХ-ийн хүрээнд хөнгөлөлт эдлэхгүй ба Энэтхэг Улсад экспорт хийсэн тохиолдолд нэн тааламжтай тарифаас 50 хувийн хөнгөлөлт (5%-2.5%) эдлэх, харин Японтой байгуулсан ЭЗТХ-ийн хүрээнд гаалийн тариф «0» байгаа юм.

---oOo---

## ДҮГНЭЛТ, САНАЛ

1/ Дэлхийн нүүрсний импортын зах зээлд хэрэглээнийхээ 85 орчим хувийг импортоор бүрдүүлдэг Энэтхэг Улс тэргүүлж байгаа бөгөөд 2025 он гэхэд коксжих нүүрсний хамгийн том импортлогч болох ажээ. Тиймээс Монгол нүүрс Энэтхэгийн зах зээлд Австралийн өндөр үнэтэй (хилийн дундаж үнэ 186$) нүүрстэй өрсөлдөх боломж байна;

2/ Дэлхийн нүүрсний экспортын зах зээлд Австрали, Индонези, ОХУ тэргүүлж байгаа бөгөөд Монгол Улс ТОП 10 оронд ордог. Монгол Улс Япон улстай байгуулсан Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг ашиглан энэ зах зээлд нэвтрэх, Энэтхэгийн зах зээлд хямд үнээр өрсөлдөх боломж өндөр байгаа учраас транзит тээврийн асуудлыг шийдэх нь чухал байна. Ингэснээр нүүрсний экспортын хувьд зөвхөн нэг орноос хараат байдлыг бууруулах нэг гол гарц байж болох юм;

3/ Монгол Улсын нүүрсний экспорт 2015 оноос тасралтгүй өсч байгаа хэдий ч бараг 100 хувь БНХАУ-д экспортолж байгаа нь энэ улсын нүүрсний импортын зах зээлээс хараат боллоо. Гэтэл БНХАУ-ын зах зээлд нүүрс экспортолж буй ТОП 5 орны 2019 оны статистикээс үзэхэд, Австрали нүүрсний нийт экспортынхоо 17%, Индонези 14%, ОХУ 7%, Канад 15%-ийг л Хятад улсад экспортолж байна. Монгол Улс БНХАУ-ын нүүрсний эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдлыг нүүрсний нэр төрөл бүрээр байнга ажиглах, нөгөө талаас нүүрсний экспортын зах зээлийг өргөжүүлэхэд шаардлагатай бүхий л боломжийг хайх хэрэгтэй байна;

4/ БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлд Монгол Улс 2010 онд 16.6 сая тонн нүүрс экспортолж, импортын зах зээлийн 10 орчим хувийг эзэлж байсан бол 10 жилийн хугацаанд буюу 2019 онд 36.6 сая тонн экспорт хийж, зах зээлд эзлэх хувь 18.3 болж өссөн. 2019 оны байдлаар БНХАУ-ын нүүрсний импортын зах зээлийн 39 хувийг Австрали, 24.3 хувийг Индонез, 18.3 хувийг Монгол Улс, 14.8 хувийг ОХУ эзэлж эхний байрыг эзэлж байгаа ба хилийн дундаж үнэ нь дээрх орнуудын хувьд тус тус 121, 62, 85, 87 доллар байгаа ба ОХУ-аас БНХАУ-д экспортлох нүүрсний хэмжээ тогтвортой нэмэгдэж манай гол өрсөлдөгч болох магадлал өндөр байна;

5/ Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн хүрээнд БНХАУ-ын нүүрсний гаалийн тарифыг бууруулах асуудлыг дараагийн буюу 6 дугаар үе шатанд тавьж шийдвэрлүүлэх, ингэхдээ Монгол Улсын нүүрсний нөөц, БТКУС-ийн кодыг анхааралдаа авах шаардлагатай;

6/ Монгол Улс Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай Ерөнхий хэлэлцээрт нэгдэж, цаасгүй худалдааны чиглэлээр шинээр гарч буй стандарт, шийдлийг хугацаа алдахгүй турших, чадавхыг бэхжүүлэх замаар худалдааг хөнгөвчлөх, худалдааны хэлцлүүдийг илүү үр ашигтай, ил тод болгох нь зүйтэй байна.

## НОМ ЗҮЙ:


- Монгол улсын гаалийн ерөнхий газрын статистикийн мэдээлэл, 2019
- Монгол улсын статистикийн мэдээллийн нэгдсэн сан
- Ашигт малтмал газрын тосны газрын нүүрсний мэдээлэл
- Олон улсын худалдааны төвийн статистик мэдээлэл
- БНХАУ-ын гаалийн тарифын мэдээлэл
- Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийн үндэсний тарифын хөнгөлөлтийн жагсаалт (БНХАУ, Энэтхэг)
- Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай Ерөнхий хэлэлцээр
- Монгол-Японы эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр http://bloombergtv.mn/ 2020.01.13


---oOo---

## СИТИ ХӨДӨЛМӨРИЙН БИРЖ

Ажлын зар нэмэх | Зарлагдсан ажлын байр

**400+**
ЖИЛД ДУНДЖААР

**6 000+**
НИЙТ ТӨГСӨГЧИД

# “СИТИ” хөдөлмөрийн бирж ажиллаж эхэллээ

*Манай “СИТИ” Их сургууль оюутан, төгсөгчдөө ажилд ороход, өөрийн бизнесээ эхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажил горилогчдод тавигддаг, шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг эзэмшүүлэх, хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөхөд нь туслах зорилгоор “CitiZone” инновац, бизнес хөгжлийн төв байгуулсан билээ.*

*Тэгвэл энэхүү ажлын хүрээнд “СИТИ” хөдөлмөрийн бирж шинээр байгуулж,оюутан,төгсөгчид болон ажил олгогчдыг холбох гүүр бий болголоо.*

*Ажил олгогч Та бүхэн www.citi.edu.mn цахим хуудасны “Төгсөгч” цэсний “СИТИ хөдөлмөрийн бирж”-д хандаж, хайж байгаа ажилтан, хүний нөөцөд тавигдах шаардлага, мэргэжлийн чиглэл, ур чадварын талаар бичихэд хангалттай юм. Бид 1700 гаруй оюутан болон 6000 гаруй төгсөгчдөөсөө сонгон шалгаруулж, таны хайж буй ажлын байранд тохирох ажилтныг зуучилж өгөх боломжтой.*

*Та бүхэн **www.citi.edu.mn/alumni** болон **www.citi.edu.mn/citizone1** линкээр орж, дэлгэрэнгүй мэдээлэл авааарай.*

***Баярлалаа.***

***XIAO-LI CAI***
***Lecturer in Visual Communication Design, Faculty of Digital Art and Design, the College of Guangzhou Nanyang Polytechnic, Guangzhou***

# THE APPLICATION OF «BRAND-VISUAL-GENES» IN «SMALL TOURIST TOWNS» DESIGN

## Abstract

This paper discusses the research on visual recognition of tourism town brand, analyzes the brand gene structure of tourism town with tourism industry gene, regional culture gene and natural resources gene as the core, puts forward the brain bank sorting technique which is the core of gene analysis and extraction, and establishes the research system of «gene analysis-gene extraction-visual design» based on visual recognition. Through an empirical study of tourist towns in Guangzhou, Guangdong Province, China, this paper combs the high correlation between brand recognition genes and town image, solves the problems of insufficient cultivation ability and low popularity of town brands, and provides certain theoretical guidance for the construction of other characteristic town brands in the future.

## Key words

Brand identities, visual genes, visual design.

## Introduction

Under the contemporary cultural background, the brand itself has a heroic image and has become an indispensable part of the modern consumer society. Brand not only refers to a commercial product, but a city, a small town, or an individual, all of them can be considered as a brand. However, to transfer the brand's own content into unique competitiveness and value relies on brands' visual identities. This is the soft power of brand, which can be promoted unconsciously.

Visual identities are to spread personal ideas to the society and consumers through visual design with the core of trademark, to gain public recognition. Taking the tourist towns under Guangzhou (a metropolis of south China) as an example, due to the lack of brand cultivation ability, the developments of many towns are not ideal, and their public awareness stays low. Accordingly, this study deeply explores the brand genes of characteristic small towns in Guangzhou, formulates brand symbols and concepts, and design brand visual recognition based on brain-bank approach. This paper aims at providing theoretical basis and case references for some tourist towns' constructions and also broadening the research fields of brand visual recognition.

## Literature Review

Originated from Greek, «Gene» was put forward by Danish geneticist Wilhelm Ludwig Johannsen in 1909 which means «life». Studies have found that genes have two characteristics, one is that they can faithfully duplicate themselves to keep the basic operations of organism, and the other is that genes can mutate in their developing.

In modern gene theory, genome is the whole information of the occurrence, development and change of the whole organism system, which coincides with the origin and development of brand.Brand gene, namely Brand DNA, is grafted on the cell biology theory, and has been promoted in the «brand building», including the core value and brand personality of the brand. In Decoding Brand Gene Sequences, it is mentioned that 'a brand is a human be-

ing that has its own life, development, growth and even extinction of all living organisms are derived from the instinct of life and its innate life gene sequence. Early in the 2012, Chinese researcher, Liu Jun, inspired by gene theory and applied brand genes to the design of Limitless brand recognition, designed visual recognition system through brand genes, and completed diversified recognition design through variation and innovative design methods based on brand genes, which also met the requirements of multi-media and brand extension.

In 2018, Dai Fangmei, a teacher from Hubei University in China, also explored how to build the brand identity of sports-characteristic towns from the perspective of «brand gene» theory. She proposed that the core value of the brand is the essence, and the brand gene compositions of established sports towns should include: sports industry brand gene, natural resource brand gene, cultural heritage brand gene and financing mechanism brand gene.

In addition, applications of brand identities are also used in other towns. For example, «I love NY», the city logo of New York, is one of the most copied print works in the world, and «I love New York», an image logo created by Milton Glaser in 1977, is currently the city logo of New York City. Forty years ago, the crime rate in New York reached the highest in history, and some areas were completely corrupt. Therefore, he designed such a logo, and developed a visual gene with love, warmth and empathy by redefining the concept. This simple and lovely logo has become one of the most classic graphic design works in the American history, and is still filled in every corner of the city as a symbol of New York spirit.

Besides, the Queen Town of New Zealand, which is located on the crystal-clear Wakatipu Lake and surrounded by towering mountains, has a marvelously natural environment. With lakes and mountains presented in its logo, this logo is impressive, and this small town in New Zealand has become a famous tourist resort in the southern hemisphere and even around the world for professional outdoor sports experience.

Another example is Chongqing, China, which fully combines historical culture and regional culture in brand building, develops a visual gene with Chongqing Bayu(□□) culture and unity, and takes «Double Festivals» as its creative theme. Two joyful people combine as a word «Qing»(□) and put forward the image symbol of «Chongqing for all».




***Figure1. New york City Logo / Queen Town Logo / Chongqing city Logo***

Brand visual genes mainly contain variable design forms through the common features of visual elements to maintain unity. Although the development of logo is still the basic point, the logo itself is only a symbol. What we need to do is to make it not only a pattern image, but also have greater coverage and space. The target audience must keep cognition of the image recognition and gain meaning in the hearts of the target audience to shape the brand and gain brand strength.

In addition to the research and application of «brand genes», there are many visual research theories related to the brand of tourist towns. Yanhua Zhang, a teacher from Shandong union medical college hospital in China, mentioned the research on regional tourism culture in the paper «research on the visual interaction design of tourism destination brands based on regional features». She thinks that regional tourism culture is mainly composed of natural geographical features, historical and cultural features and national cultural features, and puts forward that it is of great significance to adhere to the design of tourism culture based on regional characteristics when designing the brand image of tourism destination, which also provides theoretical help for my research.

Chinese Caochen Xue et al. published a paper entitled «design and research on visual

image of rural tourism brand in pinggu district of Beijing under the background of rural renewal IAT» Ion combines the background of rural revitalization policy and the characteristics of rural tourism brand image, constructs the brand image model of rural tourism, takes Pinggu as the research object, deeply studies and analyzes its present situation, firmly grasps Pinggu's largest peach industry with agricultural characteristics, gives full play to the role of culture, and designs a complete set of visual identification manuals.

## Thinkings on Brand Visual Identity of Small Tourist Towns

In this paper, based on the research of brand visual recognition genes, taking the tourist towns in Guangzhou, Guangdong Province, China as an example, through on-the-spot investigation of the tourist towns and consulting related literature, from the perspective of brand visual recognition in tourist towns, the basic system of «gene analysis-gene extraction-visual design» is studied, and the research ideas are determined on this basis, as shown in the following figure:





***Table1. Research Ideas of Brand Visual Recognition in Tourist Towns***

From the technical roadmap above, we can find that the gene analysis is carried out on the basis of taking the tourism industry genes, regional culture genes and natural resources genes as the core for literature research, expert consultation, interview records, etc. Then the brain bank approach is used to extract the core values and symbols and convert them into visually visible symbols and colors. Afterwards, the visual design of the case model is carried out, and the overall research is completed from the logo design, basic system and application system, and the high correlation between the brand identification that inherits its unique cul-

ture and the image of the town is discussed.

## Case study of brand visual recognition in tourist towns

The author takes Conghua characteristic tourist town located in Guangzhou as a case study. There are 19 characteristic towns in Conghua, which are famous characteristic town groups. Xitang Fairy Town is surrounded by mountains and rivers, with beautiful ecological environment. It is characterized by pastoral scenery, farming culture and fairy tale creativity, and promotes and develops excellent local culture such as paddy field culture, weaving art, traditional diet and straw culture, making it a first-class town in Guangdong Province. Based on the genetic analysis of tourism industry, regional culture and natural resources, we used cerebrum arrangement method to extract genes and make it run through the whole study.

The word «Arranging Approach» comes from the book «KASHIWA SATO'S Ultimate Method for Reaching the Essentials», which is an efficient working methodology put forward by contemporary Japanese designer Sato Koshi.

That is, the research system on classification, induction and summarization, as well as the subconsciousness and design thinking mode of perceptual cognition of things, whose purpose lies in combing and distinguishing, thinking and integrating the information of research objects. In 2019, Wang Tingting, a Chinese scholar, applied it into the teaching of the dining space course of environmental art design, and explored the teaching mode to meet the needs of contemporary environmental art design talents from three aspects: space arrangement, information arrangement and thinking arrangement for solving the phenomenon of separation between theoretical teaching and students' practice, help to construct a new curriculum mode and enhance students' innovative ability .

On the basis of studying a large number of literatures, the author tried to combine visual recognition genes with arrangement Method, and obtained the cerebrum arrangement method for gene core symbols. The collation is divided into seven steps, as shown in the figure below.





*Table2.Brain Bank Sorting in visual gene research*

The approach of Brain Bank Sorting is divided into three major phases which include seven small steps totally. In the stage of gene information classification and arrangement, information is visualized and listed for consultation by means of in-depth interviews, expert information, questionnaire survey, field investigation, and village history museum data study. On this basis, visual consultation is formed, and priority is set, the relationship is clarified to find out the essence, and then gene exploration and refinement are carried out.

Applying it to Xitang fairy tale town, based on the analysis, it is concluded that the pattern is mainly wheat ears, round, the font is slender sans serif, and the color is mainly vibrant golden yellow, with green and brown, as shown in the following figure:

| ***Analysis of Xitang Fairy Tale Town*** | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| ***Gene analysis*** | | | | | ***Gene extraction*** | |
| Natural resource+Regional culture+Tourism industry gene | | | | | Core symbol+value | |
| ***1、Grasp the situation*** | | | ***2、Import ideas*** | | ***3、Set the subject*** | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Gene information reception | Gene information formation | Classification of genetic information | Sequence of gene information | Understand genetic information | Find the essence | Gene extraction |
| Beautiful environment<br>With hills and waters<br>It is characterized by pastoral scenery, farming culture and fairy tale creativity<br>Develop rice field culture、Weaving art | Xitang<br>Paddy field<br>Weave<br>Fairy tale<br>art<br>Towns | Cultural Tourism town<br>Ears of wheat, gold, pastoral style<br>Handmade art, strip block, crisscross, plant<br>Children, innocence, loveliness and animation<br>Cultural-minded<br>Tourism and characteristics | Ear of wheat<br>Interlock<br>Lovable<br>Tourism town<br>gold, pastoral style, Handmade art, strip block, Children, Cultural-minded ... | Slim, lovely, golden tourist town?<br>Staggered ears of wheat?<br>Lovely cartoon image of children? | The pattern is mainly wheat ears, round, with slim linerless font and vibrant golden yellow color, matched with green and brown. | Woven golden ears of wheat |

***Table3.Brain Bank Sorting for Xitang Fairy Tale Town***

Taking this as an example, we can apply it to other towns. For example, Pingxiu Town in the southern Guangzhou takes natural resources as the core, and can extract genes with characteristics of Pingxiu and Xishi; Xitang fairy tale town takes tourism industry as the core, and can extract rice fields and vitality as characteristic genes; Hot spring wealth town takes regional culture combined with tourism industry as the core, and can utilize thermal spring and finance as characteristic genes, and finally obtain the core value of brand and unique brand symbol.

---oOo---

## Methodology

The research on brand identification system of tourist towns is an interdisciplinary subject, which involves design, tourism and communication. Therefore, it is necessary to adopt a variety of research methods, such as literature research, reading academic works on brand identification design of tourist towns and scenic spots, dissertations and academic journals on related topics, mining relevant knowledge and information about research objects, and determining the research direction and focus. The field investigation method and interview record are used to conduct field investigation and research. The brand visual system is regarded as an important parallel branch of urban construction by double line crossing method, which constitutes an important part of urban construction together with hardware facilities, cultural creations, dissemination and promotion, etc. At the same time, a large number of latest technologies and methods of brand vision research are introduced to create a visual identification system based on town construction, which fully takes into account the characteristics of the two and achieves effective integration. Finally, the research objects are demonstrated by various methods such as induction and classification, analysis and synthesis, and comparison.

## Conclusion

In this paper, brand visual genes are studied to build a brand. The system of brand visual identity is developed, a complete set of gene research system is established, and a new field of brand recognition genes research is broadened. Based on this, this study not only provides theoretical guidance for cultural brand construction in tourist towns, puts forward new ideas for its research, effectively supplements the flaw of brand recognition system, but also refines brand core values and symbols, converts them into visual logos and colors, and embodies «characteristics» for visitors. The visual identification genes related to tourist towns are integrated into the brand design, and then extended to the design of posters, packaging and guide systems. It not only meets the basic functions and cultural carrier functions, but also produces an emotional exchange with tourists, meets people's psychological needs, and can be transformed into the advantages of cities and towns to drive more consumers, promote a virtuous circle of ecology and economy, accelerate the appreciation of urban natural capital, and realize the leap-forward development of small towns' tourism.

## References:


- Jun Liu.Brand Identity Design of Limitless Based on GeneTheory[J]. Zhuangs□2012(06):114-115.
- Fang-mei Dai.Analysis on Namebrand Development of Sports-oriented Small Towns from the Brand Gene Theory[J].Journal of Hubei University(Philosophy and Social Science), 2018(06)□116-122.
- Kashiwa Sato..KASHIWA SATO'S Ultimate Mrthod for Reaching the Essentials[M]. Jiangsu fine arts publishing house, 2009.
- Ting-ting Wang.Construction of catering space desgin course mode by ultimate method for reaching the essentials[J].Design,2019(11):134-135.
- Girish Prayag.Exploring the Relationship between Destination Image & BrandPersonality of a Tourist Destination–An Application of Projective Techniques[J]. Journal of Travel and Tourism Research,2007(11):111-130.
- Yan Fei.Exploration of «Super-arrangement Method» in the Teaching of Environment Art Design[J].Zhuangshi□2013□06□□141-142.
- Yanhua Zhang, Xiaoyan Wang.Research on the Visual Interaction Design of Tourism Destination Brands Based on Regional Features[J].Journal of Physics: Conference Series□2020.
- Caochen Xue et ali, Design and Research on Visual Image of Rural Tourism Brand in Pinggu District of Beijing under the Background of Rural Revitaliation[J].IOP Conf. Series: Earth and Environmental Science,2020.

# "СИТИ АЯНГА" БАГ

"СИТИ" Их сургуулийн сагсан бөмбөгийн "Сити Аянга" баг анх 2013-2014 оны хичээлийн жилд байгуулагдсан бөгөөд Монголын оюутны сагсан бөмбөгийн спортын нүүр царай болсон шилдэг багуудын нэг юм. Үзүүлсэн амжилтуудаас дурдвал:




**2014-2015 он:**
Монголын оюутны спортын их наадам буюу Универсиад их наадмын хүрэл медаль
**2015-2016 он:**
Үндэсний оюутны лигийн аварга, алтан медаль, шилдэг тоглогч "Сити Аянга" багийн тамирчин, оюутан Г.Саранхүү
**2016-2017 он:**
1/Сүхбаатар дүүргийн Оюутны спортын IV наадмын аварга, алтан медаль
2/Монголын оюутны спортын их наадам буюу Универсиад 2017 наадмын сагсан бөмбөгийн төрөлд мөнгөн медаль
3/"Оюутны лигийн хошой аварга, алтан медаль, шилдэг тоглогч Сити Аянга" багийн тамирчин, оюутан Б.Болдбаатар
4/"Сити Аянга" багийн тамирчин Б.Болдбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг хүртсэн.
**2018-2019 он:**
1/Оюутны улсын аварга шалгаруулах тэмцээний хүрэл медаль
2/Үндэсний оюутны лигийн аварга. Монгол оюутны сагсан бөмбөгийн спортын түүхэнд анх удаа 3 жил дараалан түрүүлсэн баг болсон. Шилдэг тоглогч "Сити Аянга" багийн тамирчин, оюутан Г.Болд
**2019-2020 он:**
1/Үндэсний оюутны лигийн хүрэл медаль
2/"Сити Аянга" багийн ахлагч Т.Цогбадрах Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг хүртсэн.

***Purevdash Munkhtogtokh***
***Assistant professor to the «CITI» University (MBA)***

# MEASURING KNOWLEDGE

## Abstract

There are many discussions with regards the measuring knowledge which is a key leverage of the development issues such innovation, knowledge economy, increased competitiveness. Knowledge-intensive value creation process helps organizations to improve their long-term security and survival. So, creating an effective knowledge management forms the basis of successful innovation processes, increase an organization's ability to innovate. The development trend of assets are mostly connected with an intangible assets rather than tangible assets. Therefore, companies are doing much more investment in their intellectual assets.

## Keywords

Knowledge, innovation, management, policy, research.

## Introduction

The developed countries succeeds on new technology. Concept of new technology is measured using knowledge and innovation. Even though measuring knowledge and innovation is difficult task there can be two measures considered further in this article. These two measures are an innovation, expenditure on research and development and Knowledge Economy Index (KEI). The measures express different views of innovation and knowledge economy in a country.

## Expenditure on research and development

Expenditure on research and development as a percentage of GPD is a simple measure of innovation. Figure 1 shows that R&D spending and data are for 2006 in general, except for India (2004), New Zealand and Mexico (2005), and China (2007). (GERD = gross expenditure on research and development; GDP = gross domestic product.) The figure 1 express the developed countries invest more in R&D.




Figure 1.
https://www.researchgate.net/figure/Gross-expenditure-on-research-and-development-as-a-percentage-of-the-gross-domestic_fig1_265609386

In term companies the same trend is shown. The figure 3 shows the most successful companies are doing higher investment in R&D projects.





Figure 2.
https://ec.europa.eu/eurostat/statisticsexplained/index.php?title=File:Gross_domestic_expenditure_on_research_and_development_relative_to_GDP,_2003_and_2013.png





Figure 3. https://www.ideatovalue.com/inno/nickskillicorn/2019/08/top-1000-companies-that-spend-the-most-on-research-development-charts-and-analysis/

According to ZEF Strategy (Bonn, 2015) it is stated clearly about a vision of core research areas with regards governance issues. Out of six research areas the governance and innovation, knowledge and science policy are closely linked to the governance. Especially, the decision making process would be based on evidence.

According to PARI Brief No 7 (Daum T, 2018) historical examples of the United States and Germany about agricultural mechanization policy would help to transfer a knowledge and skills to the African countries providing their approaches and strategies. How public sector support is an advantageous to create a systematic approaches. Therefore the dissertation of Daniel Tutu Benefoh (Daniel Tutu Benefoh, 2018) explains how to assess the land-use in Ghanaian cocoa landscape.

In order to understand a governance and its impact is emerged from ISO[1] standards ISO 30401:2018 Knowledge management standard.

According to ISO organizational structure and its standard development processes «Standards are based on consensus» because there are many working groups composed of each member country. So standards are only confirmed after voting processes. There are so much pressures regarding governance issues such as corruption, constitutional changes, education quality discussed daily in the society of developing countries such as Mongolia.
According to World Justice Project report, Mongolia (data portal, 2018) is ranked at 51 out of 113 countries. So in term of governance, we need to run many projects into the concerned sectors based on prioritization from the worst parts to the least ones.

While looking through certain knowledge fields studies the developed countries' universities are mostly cluster based systems in order to provide a deep knowledge share networks such as America, Germany, UK, Singapore.

According to the paper (Evers, 2008), the importance of knowledge management is considered deeply conducting analysis of both technological and non-technological approaches. Botkin (Menkhoff, 2011) estimated that eighty percent of knowledge is a tacit. So the main task of knowledge management is to create an effective ways to transfer the knowledge. Based on ICT[2] background advantage there could be several initiatives about K-Clusters and K-hubs learning from case studies of ASEAN. Examples are the Silicon Valley, the Hyderabad IT cluster, the Munich high-tech zone and the ABC (Aachen-Bonn-Cologne) cluster in Germany, the MSC in Malaysia.

Asian governments supported by Asian Development Bank have created their strategic objectives about to set up knowledge hubs towards variety of industries such as education, environment, technology and economy. It would be great idea or the initial step running certain number of projects to create K-hub among the universities of Mongolia. Due to its nature of research orientation the universities could implement the systems little easier comparing to the rest sectors.

## Knowledge economy index

Measuring knowledge can be divided into two main categories of knowledge economy index and knowledge index. Figure 4 shows that knowledge economy is considered as an institutional capacity mostly for macro economy issues which creates a rule of law. But knowledge index measure is used mainly for organizational learning or competitiveness which helps to create a suitable environment for education, innovation and ICT.

[1] ISO-international standardization organization
[2] ICT-Information and Communication Technology





Figure 4.
https://www.researchgate.net/figure/Knowledge-Economy-Index-KEI-and-the-Knowledge-Index-KI-World-Bank-2012_fig2_318005213

To implement a consensus based systems in order solve any social issues in a manner of institutional approach. For example, Mongolia, especially capital city Ulaanbaatar has many problems covering of air pollution, land pollution, clean water lack… etc. So, knowledge economy index would be right measurement to deal with above problems. Lack of simulation tools to analyze data so that a demand of policy based on science is substantial.

While providing a training and consulting service to the public offices what are learned is insufficient research is conducted before any decision making. So the devoir of law implementation is a problem now. According to Anna-Katharina's interview named as «I can build on a very strong team» it is stated that (ZEFnews, 2014) development means «positive» change and different processes are interlinked in order to get a result. Therefore knowledge is can be considered as «development». Based on ZEF strategy and Anna-Katherina policy it is clear that interdisciplinary is a key concept to the development of any country regarding knowledge management. Best practices and standards, programs all should be shared in order to fulfill the SDG goals.

Since knowledge management and knowledge economy and innovation are interlinked together the importance of knowledge study and its impact would be key factor to the development of companies, countries. Great opportunity is to learn both systematic approaches and tools to be used the policy implementation such as open source ((PSC), 2018) would help to decision making of public policies of Mongolia.





Figure 5. Tangible vs intangible asset

To conclude, measuring knowledge requires new measurement methods using new indicators. Traditional measurement methods are no longer useful. Indicators would be adapted to meet corporate requirements. Innovation, knowledge economy and knowledge management are strategic components of knowledge measurement methods. The result of Figure 5 shows that the trend of intangible assets application has been in progress.

[3]SDG-Sustainable Development Goals

**References:**


- (PSC), T. G. (2018, August 26). GeoNetwork opensource. Retrieved from https://geonetwork-opensource.org/manuals/3.4.x/en/overview/index.html
- Bonn, C. f. (2015). ZEF strategy 2015-2020. Bonn: Zentrum fьr Entwicklungsforschung (ZEF).
- Daniel Tutu Benefoh. (2018, August 26). http://hss.ulb.uni-bonn.de/. Retrieved from University of Bonn: http://hss.ulb.uni-bonn.de/2018/5142/5142.htm data portal. (2018, August 26). https://data.zef.de/geonetwork_zef/apps/search/. Retrieved from data portal: https://data.zef.de/geonetwork_zef/apps/search/
- Daum T, H. m. (2018). HOW TO DEVELOP KNOWLEDGE AND SKILLS FOR AGRICULTURAL. PARI Policy Brief No7, 1-2.
- Delmon, J. (2011). Public-Private Partnership Projects in Infrastructure projects. New York: Cambridge University Press.
- ECOLOGIA. (2011). Handbook for Implementers of ISO 26000. Middlebury Vermont: Creative Commons.
- Evers, H.-D. (2008). Knowledge hubs and knowledge clusters:Designing a knowledge architecture for development. Munich Personal RePEc Archive, 5-18. http://hss.ulb.uni-bonn.de/2018/5142/5142.htm. (2018, a).
- Menkhoff, T. (2011). Beyond the Knowledge Trap: Developing Asia's Knowledge-based Economies. Singapore: World Scientific publication.
- Mongol bank. (2017). Mongol bank. Retrieved from https://www.mongolbank.mn/documents/statistic/externalsector/tradebalancereview/2017/06e.pdf
- National Power Transmission Grid State Owned Joint Stock Company. (2018). National Power Transmission Grid State Owned Joint Stock Company. Retrieved from http://transco.mn/#/en
- Purevdash, M. (2014). Anti bribery and corruptions standards. TOIM, 36-37.
- Purevdash, M. (2014). Memoirs of studying at Leeds. Ulanbator: Munkhiin Useg LLC.
- Purevdash, M. (2014). Standards for food safety . HUNS, 22-24.
- Purevdash, M. (2017). Corruption and the development of states cause, consequences, scope and cure. In L. E. University, Law Enforcement operations:Theoretical and practical issues (pp. 181-186). Ulanbator: Law Enforcement University.
- Word Integrated Trade Solution. (2018). About us. Retrieved from https://wits.worldbank.org/CountryProfile/en/Country/MNG/Year/2016/Summary Zaluu com. (2016). http://www.zaluu.com/. Retrieved from About us: http://www.zaluu.com/read/57b5c5g4
- ZEFnews. (2014). In focus: Governance of natural resources. Bonn: Center for Development Research (ZEF), University of Bonn.


---oOo---




Манай хамт олноос гадаад харилцаандаа баримталж байгаа зарчим болон хэрэгжүүлж байгаа үндсэн бодлого бол дэлхийн нэр хүндтэй сургуулиудтай солилцооны хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх замаар багш, оюутан, ажилтнуудынхаа мэргэжлийн болон хувь хүний өсөлт, хөгжлийг дэмжиж, үндэсний дээд боловсрол төдийгүй улсын хөгжилд хувь нэмрээ оруулах өндөр мэдлэг, чадвар, хандлагатай мэргэжилтэн, багш, судлаачдыг бэлтгэх явдал юм.

Энэхүү бодлого, зарчмын хүрээнд бид 2014 оноос Европын Холбооны дээд боловсролын тэтгэлэгт солилцооны ERAMUS MUNDUS MOBILITY ASIA / EMMA/ хөтөлбөрийн Монгол Улс дахь түнш байгууллагаар сонгогдон ажиллаж, уг хөтөлбөрийн хүрээнд 30 гаруй багш, оюутнууд Франц, Итали, Польш Улсад амжилттай суралцуулаад байна.

Европын Холбооны "Erasmus Mundus Mobility with Asia" хөтөлбөрийн хүрээнд "СИТИ" Их сургууль дараах төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Үүнд:

2013 оноос Францын Ницца хотын Софиа Антиполис их сургуультай хамтран Дээд боловсролын тэтгэлэгт солилцооны Eramus Mundus" хөтөлбөр;
2016 оноос "Их сургууль, бизнесийн байгууллагын түншлэлийг бэхжүүлэх Erasmus+" төсөл;
2017-2018 онд "Ажил эрхлэлт ба мэргэжлийн өсөлтийн талаар их сургуулиас үзүүлж буй үйлчилгээний менежмент" төсөл.
Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Та "СИТИ" Их сургуулийн Гадаад харилцааны албанаас аваарай.

**https://www.citi.edu.mn/international-program/**

***Chen Zhenghan***
***«СИТИ» Их сургуулийн Хувцас дизайны магистрант***

***Б.Алтанхайч***
***«СИТИ» Их сургуулийн Хувцас дизайны тэнхимийн багш, магистр***

# ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН СААДГҮЙ ХУВЦАС-МОДУЛЬ АРГА ЗҮЙН СУДАЛГАА БОЛОН ХЭРЭГЛЭЭ

## Хураангуй

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст анхаарал хандуулах нь хүмүүнлэг, иргэний нийгмийн тулгамдсан чухал асуудлуудын нэг мөн билээ. Модуль загварын аргачлалыг бусад олон салбарт хэрэглэдэг боловч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан саадгүй хувцас зохион бүтээхэд ховор хэрэглэдэг.

Энэхүү судалгааны хүрээнд хувцсыг суурь модуль болон нэмэлт модульд хуваж, хослуулснаар, хувцасны хэв маяг, загварыг өөрчлөн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувцсаа тайлж, өмсөхөд хэрхэн амар хялбар болгох талаар судлав. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрөө хялбар өмсөж тайлах боломжтой байх хувцсыг нэрлэхдээ «Саадгүй хувцас» гэх хэллэг ашиглав.

## Түлхүүр үгс

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, модуль загварын арга, саадгүй хувцас, загварчилгаа, бүсэлхийн хувцас.

## ОРШИЛ

Хөгжлийн бэрхшээлтэй хүн нь сэтгэлзүй, физиологи болон бие махбодын хувьд аль нэг хэсэгтээ үйл ажиллагааны алдагдалтай, хэвийн нөхцөлд ямар нэгэн үйл ажиллагааг гүйцэтгэх чадвараа бүрэн, эсхүл хэсэгчлэн алдсан байдаг. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг харааны, сонсголын, хэл ярианы, бие махбодын, оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн бэрхшээлтэй, хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй болон бусад хөгжлийн бэрхшээлтэй гэж ангилдаг.

Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо маш их боловч тэдний хэрэгцээнд тусгайлан зориулан үйлчилгээ үзүүлдэг салбар, эсхүл бүтээгдэхүүний төрөл цөөн байдаг. Хувцас зохион бүтээх салбар бол дээрх салбаруудын нэг юм.

Олон шалтгаанаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувцас нь сонголтын хувьд хязгаарлагдмал бөгөөд үүнийг дагаад хувь хүний өөртөө анхаарал тавих боломж ч ихээр хязгаарлагддаг байна. Олон тооны тэргэнцэртэй хүмүүс, бие физиологийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хувцас нь өөрийн биед тохирдоггүй, мөн хувцас өмсөхөд товч, цахилгаан, дэгээ нь саад учруулдаг зэрэг түгээмэл асуудлууд тулгардаг байна. Түүнчлэн хувцас өмсөх, тайлах үед түвэгтэй, хэрэглээний явцад зарим хэсгээрээ амархан элэгдэж, муудах зэрэг асуудлууд гардаг байна.

Өнөөгийн нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүсийн адилаар баян чинээлэг сэтгэл хангалуун амьдарч, тухайн нийгмийн амьдралд бүрэн оролцож, бусдад хүлээн зөвшөөрөгдөн амьдрах хүсэлтэй болсон. Тиймээс саадгүй

хувцас нь хувцасны загвар зохион бүтээх салбарын үндсэн болон заавал байх ёстой дэд салбар юм. Өнөө үед цөөнгүй загвар зохион бүтээгчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан анхаарлаа хандуулж эхэлж байна.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ХУВЦАСЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

АНУ, Канад зэрэг улсуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан хувцас үйлдвэрлэдэг, мэргэшсэн загварын компаниуд олноор бий болж, бие физиологи, сэтгэлзүйн хэрэгцээнд нь тохируулан материал, хэв маяг, функцэд нь сайжруулалт хийж, хувцаар хангадаг байна. Мөн «Asos», «Tommy Hilfiger» гэх мэт томоохон компаниуд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан хувцасны бизнес эрхэлдэг болсон ч өнөөг хүртэл саадгүй хувцасны эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй хэвээр л байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хувцаслалтын тал дээр тулгамдаж байгаа асуудал үндсэн 3 шалтгаантай гэж үзэж байна. Үүнд:

1/Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувцас сонгон өмсөхөд тодорхой бэрхшээл учирдагийн улмаас өмсөж л болж байвал тухайн хувцсыг шууд өмсдөг бөгөөд илүү тохирох хувцас хайх боломж ч бага байдаг байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан, тэдний биеийн онцлогт тохируулан зохион бүтээсэн хувцас зах зээл дээр байдаг, эсхүл худалдаж авах боломжтой эсэх талаарх мэдээлэл муу;

2/Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулан хувцас зохион бүтээх судалгааны ажил нь тодорхой үйл явц шаарддаг тул судалгааны явцад хувцасны хэв маяг, түүнтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэхэд дахин давтан турших цаг хугацаа их шаардагддаг нь үйлдвэрлэлийн өртөг зардлыг ихэсгэдэг;

3/Хувцас загвар зохион бүтээгчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан хувцас бүтээх тал дээр практик туршлага хангалтгүй байдаг. Хувцас загвар зохион бүтээгчид, судлаачид өөрсдийн гэсэн онцлогтой энэ бүлэг хүмүүсийн талаарх мэдлэг, мэдээлэл багатай байдгаас олон судалгаа онолын хүрээнд хязгаарлагдаж, хувцас үйлдвэрлэгч нар бодит үйлдвэрлэл явуулж чаддаггүй байна.

## МОДУЛЬ ЗАГВАРЫН АРГЫН АЧ ХОЛБОГДОЛ

Модулийн тухай ойлголтыг анх Герберт Саймон дэвшүүлсэн бөгөөд зах зээлийн эрэлт хэрэгцээг илүү сайн хангахын тулд аль болох цөөн төрөл, тоо хэмжээ бүхий модулийг ашиглан олон төрлийн хэв хэмжээ, гүйцэтгэл, функцтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой загварын арга юм. Модуль хослолын арга нь шаардлагатай мэдээлэл дээр суурилан оновчтой хослолыг сэргээх аргаар гүйцэтгэдэг бөгөөд загварыг сайн үнэ цэнэтэй байлгахын тулд аль болох олон загварын элементүүдийг мөн янз бүрийн аргуудыг байрлуулж нэгтгэдэг арга юм.

Зорилго нь бүтээгдэхүүний хязгаарлагдмал төрөл, хэв хэмжээг ашиглан хэрэглэгчдийн эдийн засгийн эрэлт хэрэгцээг хамгийн боломжит байдлаар хангах явдал юм. Хэрэглэгч нэгээс олон функцтэй болохын тулд өргөтгөсөн функцүүдийг өөрсдийн хэрэгцээний дагуу сонгож боломжтой. Загварын хувьд модуль загвар нь төрөл зүйл, олон төрлийн хэв хэмжээ, мөн үйлдвэрлэлийн мэргэшлийн хоорондын зөрөөтэй байдлыг арилгаж, хүмүүсийн бүтээгдэхүүнд тавьдаг төрөл бүрийн хэрэгцээ, шаардлагыг хангах боломжтой болгосон юм. Нэг хувцсыг илүү олон функцтэй болгосноор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувцасны хэрэгцээг хангах боломж нэмэгдэнэ.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН САДГҮЙ ХУВЦАСНЫ МОДУЛЬ ЗАГВАРЫН АРГЫН ДАВУУ ТАЛУУД

Модуль загварт оновчтой байдал, мөн мэдрэмжтэй байдал зэрэгцэн байдаг бөгөөд загвар зохион бүтээгч хувцасны суурь загварыг «дахин шинэчлэн

загвар зохиох» байдлаар өөрчилдөг.

Энэ төрлийн модуль аргаар саадгүй хувцасны загварыг гаргахдаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн биеийн онцлог байдал, хүйс зэргийг харгалзан аль нэг биеийн хэсгийн мөчний дутагдал, эсхүл биеийн нэг талдаа доод мөчний богинохон байдал зэргийг харгалзан үздэг. Гэхдээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог бүрд зориулан хувцас зохион бүтээвэл хувцасны үнэ өртөг өндөр байхаас гадна хүртээмжийн хувьд хүн бүрд хүрч чадахгүй. Хувцсыг бүрдэл хэсгээр нь хуваахад модуль загварын аргыг ашиглана. Жишээлбэл, ханцуй, өмдний хэсэг, хувцасны урд ба ар хэсгийг бүгдийг нь тусад нь авч үздэг.

Хувцасны стандарт загвар дээр үндэслэн хувцасны урд хэсэг, ар хэсэг, ханцуйн хэсэг, өмдний гуя, өгзөг хэсэг гэх мэтээр хувцасны бүрдэл хэсгүүдийг тусад нь модуль болгон биеийн ерөнхий хэмжээг өөрчлөхгүйгээр тухайн хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогоос хамааран холбогдох бүрдэл болох ханцуй, өмдний гуя, хэмжээ, урт богиныг өөрчлөн хэвтээ цуврал модулийн загварыг гаргадаг. Мөн нэг болон хоёр гаргүй хөгжлийн бэрхшээлтэй хүний хувцасны ханцуйг хөөсөн ханцуйтай, хоёр ханцуйтай загвараар хийх гэх мэт. Хэрэв ханцуй нь элэгдэж хуучирсан бол ижил хэмжээтэй боловч өөр шинэ ханцуйгаар сольж болох байдлаар шийдэх юм.

Бүх хувцасны загвар үлгэрийн бүрдэл хэсгүүдийг тусад нь нэг хэсэг болгож, эдгээр үлгэрүүдийг хэрэглэгч өөрийн онцлогийн дагуу өөрт тохирсон загвар, хэмжээг сонгож, мөн өөрийн өмсөж буй хувцасны онцлогт тааруулж болно. Коноп, соронзон товч, зангуу, цахилгаан гэх мэт бэхэлгээний аргууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувцаа өмсөж, тайлахад илүү амар болгодог. Модуль нь загварын шинэ аргын хувьд уламжлалт загвартай харьцуулашгүй давуу талтай.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН СААДГҮЙ ХУВЦАСНЫ МОДУЛЬ ДИЗАЙНЫ АРГА

Саадгүй хувцас нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хувцаа солиход тулгардаг бэрхшээлийг арилгахад чиглэдэг. Энэхүү судалгааны ажлын гол зорилго нь саадгүй хувцасны функцийг оновчтой болгож, модуль загварын аргыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тохирох олон функцтэй, өмсөж, тайлахад хялбар хувцас зохион бүтээх юм. Харилцан адилгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст саадгүй хувцсыг хэрхэн түгээмэл болгох вэ? Модуль загварын арга нь саадгүй хувцас хийх өртөг, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах ч харилцан адилгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлогт тохирсон хувцасны хэрэгцээг хангаж чадахгүй юм.

Модуль загварын аргыг ашиглан саадгүй хувцас бүтээхэд загвар зохион бүтээгчээс тухайн хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийн онцлог шинж, бие махбодын бүтэц, хэв хэмжээ, хувцас солиход тулгардаг бэрхшээл, материал нийлүүлэлт, хосолсон холболтын аргууд болон модуль холболтын талаар бүрэн дүүрэн ойлголттой байхыг шаарддаг.

## СААДГҮЙ ХУВЦАСНЫ МОДУЛЬ САН БИЙ БОЛГОХ

Хувцасны үндсэн загварт суурилсан модуль хуваалт нь модуль функцийг ашиглан хувцас холболтын загварын хийц, технологийн шаардлагад нийцүүлдэг. Хувцасны модуль загварын түлхүүр нь модулиудыг хуваах, загварчлах, хослуулах, өөрөөр хэлбэл, хувцасны янз бүрийн хэсгүүдийн жагсаан нэгтгэх явдал юм. Тиймээс нийтлэг модуль холбоосоор дамжуулан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог хэрэгцээг хангахын тулд салгаж, сольж болох модулиудыг ашиглахыг хичээдэг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн илүү амар байдлаар хувцас өмсөх хэрэгцээ, шаардлагад үндэслэн, мөн хувцас өмсөхөд үүсдэг бэрхшээлд дүн шинжилгээ хийж, хувцасны загвар, ангилал, хүйс зэргийн дагуу хувцасны модуль санг бий болгосон. / Хүснэгт 1-д үзүүлсний дагуу/

*Хүснэгт 1. Хувцасны модуль бүрэлдэхүүнүүд*

| Модулийн төрөл | Дугаар Код | Модулийн нэрс | Шинж чанар |
|---|---|---|---|
| Суурь модуль | M1 | Зах | Захын төрөл, эмжих ирмэг, захны өргөн |
| | M2 | Их бие | Их биеийн урд,ар хэсэг, энгэр, хувцасны урт, хувцасны сул болон чөлөөт байдал |
| | M3 | Ханцуй | Ханцуйн төрөл, ханцуйн урт, ханцуйн үзүүр (нударга, манжет) |
| | M4 | Бүсэлхий | Бүсэлхийн байрлал, тойрог, өргөн |
| | M5 | Доод Манжет | Манжет байрлал, манжетны төрөл, урт |
| | M6 | Өмдний урд хэсэг | Бүсэлхийн тойрог, төрөл, урд суудлын урт, өмдний төрөл, өмдний урт |
| | M7 | Өмдний хойд хэсэг | Бүсэлхийн тойрог, төрөл, ар суудлын урт, өмдний төрөл, өмдний урт |
| | M8 | Хормой(юбка) | Бүсэлхийн тойрог, юбканы төрөл, юбканы урт |
| Нэмэлт модуль | M9 | Хээ дүрс | Хэлбэр загвар, байрлал, төрөл, хэв хэмжээ, тоо хэмжээ |
| | M10 | Өнгө | Хэлбэр загвар, байрлал, төрөл, хэв хэмжээ, тоо хэмжээ |
| | M11 | Халаас | Хэлбэр загвар, халаасны байрлал, хэв хэмжээ, тоо хэмжээ, төрөл |
| | M12 | Дагалдах хэрэгсэл | Хэлбэр загвар, байрлал, төрөл зүйл, хэв хэмжээ, тоо хэмжээ |
| | M13 | Бусад | Хуниас нугалаас, геометрийн дүрслэл загвар, хуниастай хормой |

Хувцасны модулиудыг хуваахад: найман суурь модуль - M1 □ M8, таван нэмэлт модуль - M9 □ M13. Модулийн тодорхой нэрсийг Хүснэгт 1-д үзүүлэв. Хяналтын шинж чанарыг модулиудын тодорхой хэв маягийг тодорхойлоход ашигладаг. Шинж чанар бүр тодорхой шинж чанарын утгатай болсны дараа бүрэлдэхүүн хэсгийн модуль нь цорын ганц үр дүнтэй байдаг. Хэрэв ямар нэгэн шинж чанарын утга өөрчлөгдсөн бол бүрэлдэхүүн хэсгийн модуль нь мөн адил өөрчлөгдөж, төрөлжсөн бүрэлдэхүүн хэсгийн модулийг бүрдүүлдэг. Мөн өөр модулиудыг хооронд нь тохируулан шинж чанаруудын өөрчлөлтийг хянах замаар төрөл бүрийн хувцас загварыг зохион бүтээж болно.

## ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСТ ЗОРИУЛСАН САДГҮЙ ХУВЦАСНЫ ХОСОЛСОН МОДУЛИЙН ХЭЛБЭР

Хувцсыг тусад нь нэг модуль болгон хуваадаг тул бүтээгдэхүүн тус бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг, эсхүл бүтээгдэхүүнийг бүхлээр нь өөр дан бүтээгдэхүүнүүдтэй сольж, нэгтгэж, уусгаж мөн болно. Хувцсыг өмсөх хүн энэ цувралын хоёр ба түүнээс дээш загварыг нэгтгэж болно. Нэг буюу дан бүтээгдэхүүн байвал өөрчилж болох хэв маягийн тоо эрс нэмэгдэж болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан саадгүй хоёр төрлийн модуль загвар байдгаас нэг нь биеийн үндсэн хэсэгт өмсөж, үндсэн хэв маяг нь хувцас, эсхүл илүү бүрэн цогц хувцаснаас бүрддэг. Үүний үндсэн дээр хувцасны модулиудыг нэгтгэх хоёр арга байдаг бөгөөд нэг нь сольж болох чимэглэлийн, эсхүл функционал модулиудыг үндсэн бүтцэд нэмэх явдал юм. Өөр нэг арга бол үндсэн бүтцийг хуваах бөгөөд хуваагдсан модулиудыг нэмэх, хасах, эсхүл нэгтгэх замаар хувцсыг өөр, өөр хэв маягаар өөрчилж, өмсөхөд илүү тохиромжтой болгодог.

Модулиудын хоорондын холбоосонд коноп, соронзон товч, зангуу, цахилгаан гэх мэтийг ашигладаг. Цахилгаан нь доод мөчний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувцсанд тохиромжтой. Учир нь цахилгааныг нээж, хаахад хоёр гар шаардлагатай бөгөөд нэг гартай хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд цахилгааныг нээж, хаахад маш хэцүү байдаг.

Тиймээс цахилгааныг голчлон бүсэлхийн буюу доод хэсгийн хувцас хийхэд ашиглаж болох бөгөөд өмдний ташааны оёдлыг цахилгаанаар хийснээр босож зогсохгүйгээр өмдөө өмсөх, тайлах боломжтой болно.


Дээд мөчний хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд зангуу болон коноп хэрэглэх нь зөв сонголт. Дээд хэсгийн хувцасны залгаан дээр зангуу болон коноп ашиглавал хувцсаа өмсөж, тайлах боломжтой болдог.

Бие физиологийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд тохой, хойд халаас, сугах хэсэг илүү амархан элэгдэх магадлалтай байдаг бол модуль загварын аргын тусламжтайгаар эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийг бие даасан модуль болгож, хувцасны үндсэн модулиудыг солих шаардлагагүйгээр зөвхөн халаас, ханцуй зэрэг бүрдэл хэсгээр нь тусад нь сольж байх боломжтой.

/Зураг 1-д үзүүлсний дагуу/ богино хүрэмний зах, тохой, доод эмжээрт коноп бэхэлж, суурь модуль дээр нугалсан (заамтай) зах, ханцуй, доод эмжээр, халаас, малгай, гоёл чимэглэл гэх мэт нэмэлт модулиудыг хослуулж боломжтой.

Модулиудын хоорондох тодорхой хэв хэмжээнүүдийн хувьд олон янзын хэлбэрээр их биеийн хэсгийг мөн хувцасны коллекцуудийг хооронд нь чөлөөтэй сольж, хослуулж болно.

***Зураг 1 Модуль хосолсон хувцасны загвар***



---oOo---

## ДҮГНЭЛТ

Эцэст нь дүгнэхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан зориулсан хувцсанд модуль загвар, модуль хуваалт, хослол зэрэг загварчлалын аргуудын давуу талыг ашиглах бөгөөд энэхүү саадгүй хувцсанд бүтээлч, хялбаршуулсан байдлуудыг тусгаж болно. Энэ загварын арга нь загвар зохион бүтээгчдэд илүү шинэлэг загвар зохион бүтээх боломжийг олгож, мөн модуль загварыг бүтээх дүрэм, дараалыг суралцсанаар цаашид загвар зохион бүтээх шийдэл санааг илүү баяжуулж өргөжүүлсэн.

Энэ удаагийн модуль загвар нь саадгүй хувцасны загварын зөвхөн нэг хэсэг юм. Цаашид дараагийн судалгаандаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан саадгүй хувцасны загварыг сайжруулахын тулд хувцас дизайны салбарын үйл ажиллагааг олон төрлийн шаардлага, хэрэгцээнд тулгуурлан илүү өргөжүүлэн хөгжүүлэх хэрэгтэй.

---oOo---

## НОМ ЗҮЙ:


- Лю Линг. Хувцас загвар зохион бүтээхэд модуль загварын аргыг ашиглах судалгаа [J]. Аж үйлдвэрийн загвар, 2017 (12): 57-58.
- Жоу Хаймэй, Сю Яньни, Жан Сюжин. Хувцасны хэв маягийн модуль загварын арга [J]. Нэхмэл судлалын сэтгүүл, 2015 (8): 104-109.
- Ци Янан, Ду Хуан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан хувцас загварын шинжилгээ [J]. Dazhong утга зохиол, урлагийн хэвлэлийн газар 2016 (13): 137.
- Чен Ши. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувцасны загварын тогтвортой байдлын судалгаа [J]. Экологийн эдийн засаг: Эрдэм шинжилгээний хэвлэл,, 2014 (2): 261-264.
- Жу Жин. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувцаслалтад модуль загварын аргыг хэрэглэх хэтийн төлөв [J]. Нэхмэлийн тайлан, 2020 (3): 56-57.


---oOo---



СИТИ Их сургууль
Веб сайт: www.citi.edu.mn
Холбоо барих утас: 77442244
И-мэйл: info@citi.edu.mn



# СИТИ ИХ СУРГУУЛЬ

Денверийн гудамж, 7 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар, Монгол

+976 77442244 www.citi.edu.mn info@citi.edu.mn /citiuniversity /Citi_University